



ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ
MONGOLIAN UNIVERSITY OF SCIENCE AND TECHNOLOGY



ᠰᠢᠨᠵᠡᠯᠡᠬᠡ ᠤᠬᠠᠭᠠᠨ, ᠲᠡᠬᠨᠣᠯᠣᠭᠢᠨ ᠶ᠋ᠢᠰᠤᠷᠭᠠᠭᠤᠯᠢ

2019-2020 оны хичээлийн ЖИЛИЙН ТАЙЛАН



1959
ШУТИС

УЛААНБААТАР ХОТ
2020 ОН



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛЬ**

2019-2020 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

Хянасан:

Захиргаа, хүний нөөцийн газрын дарга Н.Ганзориг
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ж.Арслан

Эмхэтгэсэн:

ЗХНГ-ын мэргэжилтэн Ш.Доржсүрэн

Үсгийн гагнитур: Times New Roman

Хэвлэлийн хэмжээ: B5 /176x250/

Хэвлэлийн хуудас:25.16

Хэвлэсэн тоо: 60 ширхэг

ШУТИС, Хэвлэлийн газарт хэвлэв



Өмнөх үг.....	5
НЭГ. Удирдлага, зохион байгуулалт.....	8
1.1. Удирдах зөвлөл.....	8
1.2. Эрдмийн зөвлөлийн үйл ажиллагаа.....	10
1.3. Захирлын зөвлөл.....	12
1.4. Хөгжлийн хөтөлбөр төлөвлөлт.....	13
1.4.1. Төсөв, төлөвлөлтийн талаар.....	17
1.4.2. Төвлөрсөн бус мэдээллийн статистик тайлан.....	19
1.4.3. Мэдээллийн технологийн чиглэлээр гүйцэтгэсэн ажил.....	33
1.5. ШУТИС-ийн музей.....	43
ХОЁР. Сургалтын үйл ажиллагаа.....	48
2.1. Бакалаврын сургалт.....	48
2.1.1. Элсэлтийн үйл ажиллагаа.....	48
2.1.2. Сургалтын үйл ажиллагаа.....	50
2.1.3. Улирлын шалгалт.....	50
2.1.4. Төгсөлтийн үйл ажиллагаа.....	50
2.1.5. Суралцагчдын тоо, үнэлгээний голч дүн (гра).....	53
2.1.6. Шилжилт хөдөлгөөн, кредит дүйцүүлэлт.....	63
2.1.7. Төгсөх оюутны дүн тулгалт.....	66
2.1.7. Цахим сургалт.....	68
2.1.9. Ерөнхий боловсролын ахлах сургууль.....	70
2.1.10. ШУТИС-коосэн технологийн коллеж.....	70
2.1.11. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл.....	71
2.1.12. Оюутны сэтгэл ханамжийн судалгаа.....	72
2.1.13. Сургалтын үйл ажиллагааны хяналт, шалгалт.....	73
2.1.14. ШУТИС-ийн хөтөлбөрийн ерөнхий хорооны үйл ажиллагаа.....	76
2.1.15. Үндсэн сурах бичиг хэвлэлт /сүүлийн 3 жилээр/.....	78
2.2. Ахисан түвшний сургалт.....	83
2.2.1. Магистрын сургалтын үйл ажиллагаа.....	84
2.3. Докторантурын сургалтын үйл ажиллагаа.....	88
ГУРАВ. Эрдэм шинжилгээ, инноваци.....	98
3.1. Эрдэм шинжилгээний арга хэмжээ.....	98
3.2. Судалгаа, боловсруулалтын ажил.....	104
3.2.1. Улсын захиалгат төсөл.....	106
3.2.2. ШУТИС-ийн технологийн сангийн санхүүжилттэй төсөл.....	109
3.2.3. Олон улсын санхүүжилттэй төсөл, хөтөлбөр.....	111
3.2.4. "Инженер технологийн дээд боловсрол" (mjeed) төсөл.....	114
3.2.5. Гэрээт ажил.....	122
3.3. Судалгааны хүрээлэн.....	125
3.4. Судалгааны лаборатори.....	133
3.5. Судалгааны хүний нөөц.....	136
3.6. Оюуны өмчийн эрхийн хамгаалалт.....	139
3.7. Эрдэм шинжилгээний хэвлэн нийтлэл.....	139
3.8. Эрдэм шинжилгээний хамтын ажиллагаа.....	159
3.9. Оюуны өмчийн эрхийн хамгаалалт (аж үйлдвэрийн салбараар).....	162
ДӨРӨВ. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа.....	166
4.1. ШУТИС-ийн багш, ажилтны гадаад томилолт, мэргэжил дээшлүүлэлт.....	166
4.2. Хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг.....	167
4.3. Гадаадын мэргэжилтэн, багш зочин профессор.....	168
4.4. Оюутан солилцоо, гадаадын тэтгэлэг.....	168
4.5. Гадаадын тэтгэлгүүд.....	169

ТАВ. Оюутны хөгжил, үйлчилгээ	172
5.1. Хувь хүний хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа.....	172
5.1.1. ШУТИС-ийн оюутны клубүүдийн үйл ажиллагаа	179
5.2. Оюутны тэтгэлэг, урамшуулал, хөнгөлөлт	182
5.3. Нэгдсэн арга хэмжээ	188
5.4. Олон нийт нийгэмд чиглэсэн ажил	200
5.5. Хөдөлмөр эрхлэлт	201
5.6. Эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр.....	203
5.6.1. Шинээр элсэгчдийн үзлэгийн мэдээ	203
5.6.2. Covid-19 корона вирусийн халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хяналт таңдалт.....	212
5.6.3. Орчны эрүүл ахуй ариутгал, халдваргүйжүүлэлт.....	214
ЗУРГАА. Номын сангийн үйлчилгээ.....	220
6.1. Шинжлэх ухаан, технологийн номын сан	220
6.2. Номын сангийн үйлчилгээ, фонд бүрдүүлэлт.....	220
6.3. Сангийн автоматжуулалт, цахим үйлчилгээ.....	224
6.4. Шутис хэвлэлийн газар.....	228
ДОЛОО. Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээ, маркетинг олон нийттэй харилцах үйл ажиллагаа.....	232
7.1. Чанарын менежментийн тогтолцоо iso 9001:2015 стандарт.....	232
7.2. ШУТИС-ийн дотоод аудит	233
7.3. Маркетинг, олон нийттэй харилцах үйл ажиллагаа	235
7.1.1. ШУТИС-ийн нээлттэй хаалганы өдөр	236
7.1.2. ШУТИС-ийн сурталчилгааны контент бэлтгэх чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажил.....	238
7.1.3. Маркетингийн идэвхжүүлэлтийн чиглэлээр явуулсан үйл ажиллагаа. Геологи уул уурхайн салбарт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн чанартай боловсон хүчин бэлтгэнэ. ГУУС-ийн захирал Л.Пүрэв.....	239
7.1.4. “ШУТИС-ийн цаг” подкаст, “мэргэжил сонголт” вебинарын чиглэлээр гүйцэтгэсэн ажил.....	244
7.1.5. “ШУТИС-ийн албан ёсны пэйж” хуудас хөгжүүлэх чиглэлээр гүйцэтгэсэн ажил.....	245
7.4. Нээлттэй боловсрол.....	247
7.4.1. Дээд боловсролын судалгаа хөгжүүлэлт.....	250
7.4.2. Сургалтын үйл ажиллагааг дэмжих, багшийн багшлах ур чадварыг сайжруулах хөтөлбөр боловсруулах, батлуулан мөрдөх	258
7.4.3. Гадаад хамтын ажиллагаа	264
7.4.4 “Боловсрол судлал”, “боловсролын удирдлага” хөтөлбөрийн сургалт, төгсөлт ..	266
7.4.6. Системийн динамикийн загвар боловсруулах	267
НАЙМ. Санхүү, бүртгэл.....	272
8.1. Санхүү, нягтлан бодох бүртгэл.....	272
8.2. Балансын бүтэц	272
8.3. Орлого үр дүн.....	277
8.4. Зарлага үр дүн.....	282
8.5. Санхүү тайлангийн аудитын үр дүн.....	292
8.6. Хөрөнгө оруулалт, хангамжийн талаар.....	292
8.7. Байр ашиглалт	230

ӨМНӨХ ҮГ

ШУТИС-ийн хамт олон бид 2019-2020 оны хичээлийн жилийг бүтээн байгуулалтын жил болгон зарлаж, эрхэм хүндэт профессор багш, ажилтан оюутан залуучууд хөдөлмөр бүтээлийн өндөр амжилт гаргасан жил байлаа. ШУТИС-ийн түүхт 60 жилийн ой энэ хичээлийн жилд тохиож, манай их сургуулийн хамт олон бүтээлч ажил, зорилго зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж 60 жилийн ойн баярыг 2019 оны 10 дугаар сарын 04-ний өдөр ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих зорилтын хүрээнд судалгаа, инновацийн дэд бүтцээ бүрдүүлэх зорилгоор хичээлийн шинэ VIII байрыг барьж, ашиглалтад хүлээн авч, манай сургуулийн судалгааны тэргүүлэх лабораториуд, гарааны компаниуд, Инженерийн ахисан түвшний сургууль, Нээлттэй боловсролын төв, “ШУТИС-Коосэн” технологийн коллеж, ШУТИС-ийн музей, Олон улсын Эрдэм шинжилгээний хурлын танхим зэрэг олон чухал нэгжүүд үйл ажиллагаа явуулж байна. Тус хичээлийн байр 40 лаборатори, лекцийн 9 танхим, хурлын нэг танхимтай орчин үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон, оюутнуудыг ая тухтай орчинд суралцах, тэдний хөгжлийг дэмжихэд чиглэсэн 12 давхар цогцолбор юм. VIII байрны “Олон улсын эрдэм шинжилгээний хурлын их танхим”-ыг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ хамтын ажиллагааны хүрээнд сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр бүрэн тохижуулж хүлээлгэн өглөө.

ШУТИС-ийн түүхэн хөгжлийг нийтэд сурталчлан таниулах, Монгол улсын шинжлэх ухааны хөгжлийн үе шат, ололтыг харуулах, дэвшилтэт техник технологийг гадаад, дотоодын зочид төлөөлөгч, багш, ажилтан, оюутан суралцагчдад үзүүлэх зорилгоор “ШУТИС-ийн Музей”-г шинээр байгуулав. Манай эрдэмтэн багш нар их орчин үеийн агуулга, стандартад нийцүүлэн сургуулийн 60 үндсэн сурах бичгийг шинэчлэн хэвлэн гаргалаа. Мөн их сургуулийнхаа нэгэн жарны түүхийн 6 ботийг бүтээж заллаа.


Улс орны ирээдүйн хөгжилд ШУТИС-ийн гүйцэтгэх үүрэг, их сургуулийн цаашдын хөгжлийн зорилго, зорилтуудыг үндэслэн ШУТИС-ийг 2030 он хүртэл хөгжүүлэх “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг боловсруулан батлав. “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”-г нийт оролцогч талуудын оролцоонд тулгуурлан 2030 онд дэлхийн шидэг 1000 сургуулийн эгнээнд багтаж, дэлхийн жишигт нийцсэн их сургууль болон хөгжих, төр бизнесийн өмнө тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэгч нь байх зорилго тавин ажиллаж байна.

Энэ оны эхнээс Монгол улсад тогтоосон өндөржүүлсэн бэлэн байдал, хөл хорионы дэглэм хэрэгжсэнтэй холбоотой бид сургалтын үйл ажиллагаагаа цахим хэлбэрээр зохион байгуулсан. Цаг үеийн байдлаас шалтгаалж хорио цээрийн дэглэмийн үед манай их сургуулийн хаврын улирлын сургалтын бүхий л үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулж, цахим сургалтын үйл ажиллагаанд манай их

сургуулийн профессор багш, оюутан залуучууд өөрсдийн бүх боломж бололцоог дайчлан оролцов. Цахим сургалтын онцлог нь шинэ арга зүй, шинэ хэлбэрээр сургалтын арга зүйг зохион байгуулах, шинэ зүйл суралцах боломж олгосон, мөн элсэлт төгсөлтийг цахим хэлбэрээр гүйцэтгэн шинээр элсэгчдийн хуваарь сонголтыг улс орныг хамарсан байдлаар цахим хэлбэрээр зохион байгуулсан нь өвөрмөц онцлогтой байлаа. Манай их сургуулийн профессор багш нар урьд өмнөхөөс илүү хариуцлагатай ажиллаж, эх орны өнцөг булан бүрд суугаа оюутнууддаа зайнаас бололцоотой бүх хэлбэрээр, хичээлийн агуулга материалаа хүргэж хамтран ажиллалаа. Энэ бол манай багш нарын цаашдын хөгжил, шинэ арга зүй, боломжуудыг эрэлхийлсэн үр дүнтэй хичээлийн жил юм гэж бид дүгнэж байна.

Хичээлийн шинэ жилд бид энэ ололт амжилтаа улам бататгаж, их сургуулийн үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 стандартыг нэвтрүүлэх, судалгаанд суурилсан их сургууль болон хөгжих, “ШУТИС-2030” стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зэрэг томоохон зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. ШУТИС-ийн эрхэм хүндэт профессор багш, оюутан, суралцагчид та бүхэнд шинэ хичээлийн жилдээ улам их амжилт гаргахыг хүсэн ерөөе!

ШУТИС-ийн РЕКТОР



Б.ОЧИРБАТ



НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

ШУТИС 2019-2020 оны хичээлийн жилд Улаанбаатар хотод 10, орон нутагт 1, нийт 11 бүрэлдэхүүн сургууль, харьяа “Эрдэнэт цогцолбор” дээд сургууль, ШУТИС-Коосен технологийн коллеж, ШУТИС-ийн харьяа ЕБС-ийн ахлах сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 2 төв, бүрэлдэхүүн 2, харьяа 2 хүрээлэн үйл ажиллагаа явууллаа.

ШУТИС-ийн захиргаа, удирдлагын түвшинд 5 газар, 8 алба, 4 төвтэй үйл ажиллагаа явууллаа. ШУТИС-ийн захиргаа нь ШУТИС-ийн ректор, Сургалт, оюутны асуудал эрхэлсэн, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн, Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн 5 дэд захирал, Захиргаа, хүний нөөцийн газар, Сургалтын бодлого зохицуулалтын газар, Эрдэм шинжилгээ, инновацийн газар, Хөгжлийн хөтөлбөр, төлөвлөлтийн газар, Хөрөнгө оруулалт, хангамжийн газар, Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба, Оюутны соёл, үйлчилгээний алба, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Чанарын хяналт, шинжилгээ, үнэлгээний алба, Маркетинг, олон нийтгэй харилцах алба, Санхүү, нягтлан бодох бүртгэлийн алба, Байр ашиглалтын нэгдсэн алба, Нээлттэй боловсролын төв, Мэдээллийн технологийн төв, Технологи дамжуулах төв, Эрүүл мэнд, спортын төв, Шинжлэх ухаан технологийн төв номын сан, ШУТИС-Хэвлэлийн газар үйл ажиллагаа явууллаа.

1.1. УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Монгол Улсын Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэгийн 2019 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн А/202 тоот тушаалаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн удирдах зөвлөлийн үүсгэн байгуулагчийн төлөөллийг нэгдүгээр хавсралтаар, Боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг хоёрдугаар хавсралтаар шинэчлэн баталсан.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлд хамт олныг төлөөлөн суух гишүүдийн саналыг бүрэлдэхүүн сургууль бусад нэгжүүдээс авч хамт олны хурлаар хэлэлцүүлэн, ШУТИС-ийн Захирлын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 1/307 тоот албан бичгээр БСШУСЯ-ны Дээд боловсролын газарт уламжлав.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн

Хүснэгт 1.1

Д/д	Албан тушаал	Нэрс	Эрхэлж буй албан тушаал
I. Төрийн төлөөлөл			
1	Дарга	Д.Бадарч	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Нээлттэй боловсролын төвийн захирал
2	Дэд дарга	Г.Батнэмэх	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч
3	Гишүүн	С.Магнайсүрэн	Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга

4		Б.Гүнчинхүү	Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын референт
5		Ж.Ганбат	Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга
6		Т.Гантогтох	Хүнс хөдөө аж, ахуй хөнгөн үйлдвэрийн яамны газрын дарга
7		О.Хуягцогт	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын дарга
8		Б.Дамдинсүрэн	ШУТИС-ийн Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн зөвлөх профессор
9		Д.Баяр	БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын ахлах мэргэжилтэн
II. Хамт олны төлөөлөл			
10	Гишүүн	Д.Цолмонбаатар	Механик тээврийн сургуулийн захирал
11		Б.Сэргэлэн	Эрчим хүчний сургуулийн салбарын эрхлэгч
12		Я.Төгөлдөр	Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн салбарын эрхлэгч
13		Д.Болор	Эн Си Эс ХХК-ийн гүйцэтгэх захирал
14		Ц.Энхбаатар	“ШУТИС-Бидний бахархал” төгсөгч, дэмжигчдийн холбооны тэргүүлэгч гишүүн
15		С.Болд-Эрдэнэ	Геологи уул уурхайн сургуулийн оюутан

Тайлант хугацаанд удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд хоёр удаа өөрчлөлт орсон байна. БСШУС-ын Сайдын 2019 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн А/388 тоот тушаалаар 2019 оны А/202 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар ГХЯ-ны Гадаад сурталчилгаа, соёлын харилцааны газрын дарга Х.Мандахцэцэгийн оронд БСШУСЯ-ны Төрийн захиргаа удирдлагын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Хуягцогтоор БСШУС-ын Сайдын 2020 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн А/243 тоот тушаалаар мөн тушаалын хавсралтад өөрчлөлт оруулж БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Т.Амаржаргалангийн оронд БСШУСЯ-ны Дээд боловсролын бодлогын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Г.Батнэмэх нарыг томилон өөрчлөлт оруулав.

ШУТИС-ийн захиргаанаас удирдах зөвлөлийн 2019 оны хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтыг гарган Удирдах зөвлөлийн даргын 2019 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 01 тоот албан бичгээр гишүүдэд хүргүүлсэн. COVID-19 цар тахлын улмаас Монгол улс өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах үед ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн хурлыг онлайнгаар зохион байгууллаа.

ШУТИС-ийн Удирдах зөвлөл 2019-2020 оны хичээлийн жилд таван удаа хуралдаж ШУТИС-ийн Захирлын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх, ШУТИС-ийн 2019 оны зарлагын төсөвт өөрчлөлт оруулах, ШУТИС-ийн 2020 оны төсөв батлах, “Эрдэнэт цогцолбор” дээд сургуулийг ШУТИС-д харьяалуулах, "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө" дэмжих, Сургалтын төлбөрийн нэг кредитийн үнэлгээг тогтоох, Оюутны байрны төлбөрийг шинэчлэн тогтоох тогтоох, "ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө"-г батлах, ШУТИС-ийн Музей байгуулах, Найдваргүй авлагыг

хүчингүй болгох, Удирдах зөвлөлийн орлогч даргыг томилох, Элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог тогтоох, Элсэлтийн хяналтын тоог батлах, ШУТИС-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагааг дүгнэх, Санхүүжилтийн зөвшөөрөл олгох, ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардал батлах тухай, ШУТИС-ийн 2020 оны төсвийн тодотгол батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж, тодорхой шийдвэрүүдийг гаргажээ.

Хичээлийн жилийн хугацаанд ШУТИС-д зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн, уулзалт семинар бусад арга хэмжээнд Удирдах зөвлөлийн гишүүд оролцож, их сургуулийг хөгжүүлэх, материаллаг баазыг нэмэгдүүлэх, бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын чанарыг сайжруулахад анхаарч, дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

1.2. ЭРДМИЙН ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2019-2020 оны хичээлийн жилд Эрдмийн зөвлөл 4 удаа хуралдаж, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, сургуулийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө, Эрдэм шинжилгээ, инновацийн бодлого, хүндэт цолны асуудлуудыг хэлэлцүүлэн шийдвэрлэлээ.

ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал /2020-2021/

Хүснэгт 1.2

Д/Д	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
1	ШУТИС-ийн "Хүндэт профессор" цол олгох тухай	2019.09.25	№08
2	Сургалтын хөтөлбөр шинээр нээх, нэр өөрчлөх, сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай		№09
3	"ШУТИС-2030 Стратеги төлөвлөгөө"-г дэмжих тухай	2019.12.25	№10
4	Сургалтын хөтөлбөр шинээр нээх, хөтөлбөрт мэргэжлийн чиглэл нэмэх, хөтөлбөр, мэргэжлийн чиглэлийн нэр өөрчлөх тухай	2020.04.28	№01
5	"ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн талаар баримтлах бодлого"-ыг батлах тухай		№02
6	Инженерийн бэлтгэлд элсэлт авах тухай	2020.06.16	№03
7	ШУТИС-ийн "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цол олгох тухай.		№04,05,06,07

Түүнчлэн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх байнгын ажиллагаатай дэд зөвлөлүүд эрдэм шинжилгээний хуанли, төлөвлөгөөний дагуу асуудлуудыг 3 удаагийн хурлаар хэлэлцэж дараагийн шатны хуралд оруулсан байна.

Дэд зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн асуудал /2019-2020/
Хүснэгт 1.3

д/д	Хэлэлцсэн асуудал	Огноо	Тогтоол
Эрдмийн ба хүндэт цолны дэд зөвлөл			
1	ШУТИС-ийн "Хүндэт профессор" цол олгох тухай	2019.09.24	№02
2	ШУТИС-ийн "Хүндэт доктор", "Хүндэт профессор" цол олгох тухай	2020.06.08	№01
Эрдэм шинжилгээ, инновац, хамтын ажиллагааны дэд зөвлөл			
1	ИТДБ төслийн хамтарсан судалгааны багуудын үйл ажиллагааны тайлан хэлэлцэх	2019.12.09	Баг тус бүр дээр үнэлгээ хийж, зөвлөмж гаргав.

Тайлант онд ШУТИС-ийн хүндэт доктор цол 2, хүндэт профессор цол 17 хүн хүртсэн байна.

ШУТИС-ийн Хүндэт цол хүртэгчэд /2019-2020/
Хүснэгт 1.4

Д/Д	Овог нэр	Байгууллага	ЭЗ-ийн тогтоолын тогтоол
Хүндэт доктор			
1	Х.Бадамсүрэн	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Ерөнхий захирал	2020.06.16, №04
2	Набүхико Азүма	Японы Нагаока технологийн их сургуулийн ерөнхийлөгч	2020.06.16, №05
Хүндэт профессор			
1	Л.Болд	ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан	2019.09.25, №08
2	Б.Батжаргал	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх станц ХК-ийн дэд захирал	2019.09.25, №09
3	Ш.Ангар	ЭХС-ийн ахлах багш	2019.09.25, №10
4	Д.Цэрэндорж	Менежментийн Холбооны тэргүүн	2019.09.25, №11
5	Б.Мажинбуу	Монгол-Оросын найрамдлын Эрдэнэт нийгэмлэгийн тэргүүн	2019.09.25, №12
6	М.Бадамсүрэн	Дорнод аймгийн засаг дарга	2019.09.25, №13
7	Д.Дамба	Айвуунтэс ХХК-ийн захирал	2019.09.25, №14
8	Г.Чинзориг	Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга	2019.09.25, №15
9	Жэ Ёнг Ким	Сөүлийн үндэсний их сургуулийн Байгаль ба Хүрээлэн буй орчны салбарын эрхлэгч	2019.09.25, №16
10	Л.Тотев	Монгол-Болгарын найрамдлын нийгэмлэгийн гишүүн, Болгарын	2020.06.16, №06

		их дээд сургуулиудын ректоруудын холбооны дарга	
11	Д.Ганбат	"Цайрт минерал" ХХК-ийн захирлуудын зөвлөлийн дэд дарга	2020.06.16, №07
12	Г.Сандагдорж	ГУУС, Эрдэс боловсруулалт, инженерийн салбарын ахлах багш	2020.06.16, №07
13	Б.Энхжаргал	Хүрд ХХК-ийн захирал	2020.06.16, №07
14	Я.Содбаяр	ЭХС, Цахилгааны инженерийн салбарын ахлах багш	2020.06.16, №07
15	Б.Тунгалаг	МХТС, Ахмад багш	2020.06.16, №07
16	Ш.Сүхээ	Эрдэнэт цогцолбор сургууль, Ахмад гэрээт багш	2020.06.16, №07
17	Ш.Ганбат	Эрдэнэт цогцолбор сургууль, Ахмад гэрээт багш	2020.06.16, №07

1.3. ЗАХИРЛЫН ЗӨВЛӨЛ

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулах саналыг бүрэлдэхүүн сургууль, институт, захиргааны газар, алба нэгжээс авч нэгтгэн батлуулав.

Тайлант хугацаанд захирлын зөвлөлийн хурал батлагдсан төлөвлөгөөний дагуу 26 удаа хуралдаж элсэлтийн хяналтын тоо, төсөв, төсвийн тодотгол, төлөвлөгөө, тайлан баланс, цалин, элсэлт төгсөлт, сургалтын үйл ажиллагааны тухай, мэргэжил, сургалтын төлбөр, судалгааны төв, эрдэм шинжилгээний хурал, үзэсгэлэн зохион байгуулах, дүрэм, журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, бодлогын баримт бичиг, багш, ажилчдын нийгмийн асуудал, ой тэмдэглэх, уралдаан зарлах, гадаад харилцаа, ахисан түвшний сургууль байгуулах тухай, аудит болон дотоод хяналт шалгалтын дүгнэлт, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл /хөтөлбөрүүд/-ийн явц, үр дүн, засвар тохижилтын ажил, эрдэм шинжилгээний болон сургалтын нэгдсэн хуанли зэрэг , цаг үеийн асуудлыг хэлэлцэв.

Дэлхий нийтэд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахал дэгдсэнтэй холбогдуулан халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжсэнтэй холбогдуулан захирлын зөвлөлийн хурлыг онлайнгаар 4 удаа зохион байгуулж ажиллав.

Захирлын зөвлөлийн хурлын тэмдэглэл хөтөлж, хурлын шийдвэрийг цаг тухайд нь их сургуулийн <https://www.must.edu.mn/mn/content/t/5> веб хуудаст байршуулан ажиллаж байна.

Захирлын зөвлөлийн бүрэлдэхүүн
Хүснэгт 1.4

Д/д	Овог нэр	Албан тушаал	Тайлбар
1	Б.Очирбат	ШУТИС-ийн Захирал	
2	Х.Энхжаргал	Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал	
3	Т.Намнан	Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал	
4	Б.Сүхбат	Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал	
5	Л.Баяр-Эрдэнэ	Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал	
6	Ц.Баатархүү	Хяналт шинжилгээ, үнэлгээ эрхэлсэн дэд захирал	
7	Н.Ганзориг	Захиргаа, хүний нөөцийн газрын дарга	
8	Э.Нинжгарав	БАС-ийн захирал	
9	А.Энхбат	БуХС-ийн захирал	
10	Г.Батгүвшин	БАТС-ийн захирал	
11	Л.Пүрэв	ГУУС-ийн захирал	
12	Б.Соёлсүрэн	ГХС-ийн захирал	
13	Ц.Батбаатар	ДаТС-ийн захирал	
14	Д.Цолмонбаатар	МехТС-ийн захирал	
15	Н.Чулуунбанди	МХТС-ийн захирал	
16	Ж.Туяацэцэг	ҮТС-ийн захирал	
17	Д.Ганхуяг	ХШУС-ийн захирал	
18	Ч.Мангалжалав	ЭХС-ийн захирал	
19	Д.Зоригтхүү	ОрТС-ийн захирал (ЭЦДС-ийн захирал)	
20	С.Дэлгэрмаа	ШУТИС-ийн дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны дарга	
21	С.Болд-Эрдэнэ	ШУТИС-ийн Оюутны холбооны тэргүүн	2019.09.10-ны өдөр хүртэл
	Б.Мягмарренчин		2019.09.10-ны өдрөөс


1.4. ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР ТӨЛӨВЛӨЛТ

ШУТИС-ийн хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн хөтөлбөр төлөвлөлтийн хүрээнд дараах үндсэн ажлыг гүйцэтгэв. Үүнд:


1. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс 2020 оны төсвийн төслийн саналыг хүлээн авч нэгтгэн боловсруулж, Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулах саналыг хүлээн авсан.
2. ШУТИС-ийн УЗ-ийн 2019 оны 12 сарын 05-ны өдрийн 13 тоот тогтоолоор ШУТИС-ийн 2020 оны орлого, зарлагын төсөв, хөрөнгө оруулалт бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг ШУТИС-ийн захирлын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан.
3. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдэд 2020 оны орлого, зарлагын төсөв, хөрөнгө оруулалт бараа ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг батлуулж тараасан.
4. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс батлагдсан төсөвт орлого зарлагын сарын хуваарь авч, нэгтгэн боловсруулж батлуулан тараав.
5. ШУТИС-ийн УЗ-ийн 2020 оны 6 сарын 10-ны өдрийн 10 тоот тогтоолоор 2020 оны батлагдсан орлого, зарлагын төсөвт тодотгол хийгдсэн.
6. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 2020 оны тодотгосон орлого, зарлагын төсвийг баталгаажуулан нэгжүүдэд илгээсэн.
7. ШУТИС-ийн хэмжээнд бүрэлдэхүүн сургуулиудын 2017-2019 оны хичээлийн жилүүдийн үйл ажиллагааны статистик үзүүлэлтүүдийг гаргаж ШУТИС-ийн 33-ийн 2019 оны 10 сарын 24-ний хурлаар хэлэлцүүлэв.
8. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хүлээн авч боловсруулан ШУТИС-ийн 2019-2020 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны нэгтгэсэн төлөвлөгөөг батлуулав.
9. ШУТИС-ийн веб сайтын бүтцийг 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улиралд шинэчлэхэд шаардлагатай статистик тоон мэдээллүүдийг бэлтгэв.
10. Стратеги төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэг байгуулах Захирлын А/192 тушаалын дагуу ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг боловсруулж УЗ-д танилцуулж батлуулсан.

ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг шинээр боловсруулахад гардан оролцож, одоо хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Стратеги төлөвлөгөөний зорилго, зорилтуудад ШУТИС-ийн чанарын бодлого, зарчмуудыг нийцүүлж, нэгтгэн ажилласан. Үүнд:

- Хэрэглэгчид төвлөрөх буюу суралцагч, ажил олгогчдын хэрэгцээ, шаардлагад анхаарч, хангах, төвлөрөх
- Алсын хараатай манлайллыг бий болгох
- Стратеги төлөвлөлтийг хийхдээ багш ажилтан, суралцагчдыг оролцуулах
- Харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох
- Нийгмийн өмнө хариуцлагатай ажиллах зэрэг зарчмуудыг үндэс болгосон.



Зураг 1.1. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөг боловсруулсан үе шат



Зураг 1.2. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө



Зураг 1.3. ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө хураангуй

1.4.1. Төсөв, төлөвлөлтийн талаар

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн санхүүгийн үзүүлэлтийг санхүүгийн жилтэй уялдуулан тооцож тайлагнадаг.

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдэд 2020 оны төсвийн төслийг боловсруулах удирдамжийг хүргүүлэн “ШУТИС-2021” мастер төлөвлөгөөний зорилго, зорилтуудын хүрээнд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг 2020 оны төсөвтэй уялдуулан боловсруулсан. ШУТИС-ийн төсвийн төслийн орлого, зардлын зүйлийн задаргааг Мэдээллийн технологийн төвтэй хамтран програмчлав. Бүрэлдэхүүн сургууль нэгжүүд нь төсвийг дараах <http://203.217.139.9/Budget/#/> линкээр харж болно.

Үзүүлэлт	2021 Нийт дүн	Сургалт /бөм,магд,д/г/	МСУТөв
Шилжих үлдэгдэл	21.00	21.00	0.00
И. Сургалтын төлбөрийн орлого	1,015,688.80	0.00	1,015,688.80
И курс сургалтын төлбөр	1,015,688.80	0.00	1,015,688.80
Бакалаврын сургалтын төлбөр	985,180.00	0.00	985,180.00
Нэг кредитийн үнэлгээ (төг)	90,800.00	0.00	90800.00
Нэг оюутны сонгох кредит	31.00	0	31
Бакалавр оюутны тоо	350.00	30	350.00
Магистрын сургалтын төлбөр	30,508.80	31	30,508.80
II курс сургалтын төлбөр	0.00	32	0.00
III курс сургалтын төлбөр	0.00	33	0.00
YI курс сургалтын төлбөр	0.00	34	0.00
Y курс сургалтын төлбөр	0.00	0.00	0.00

Үзүүлэлт	2019 Төлөв лөгөө	2019 Гүйцэтгэл	2021 Нийт дүн	Сургалт /бөм,магд,д/г/	МСУТөв	Оюутны байр	Ахлах сургууль
Сургалттай холбоотой шууд зардал	0.00	0.00	860.00	860.00	0.00	0.00	0.00
Шууд бус зардал	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Оюутны үйлчилгээний зардал	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Зардал санхүүжилтээ иновацийн үйл ажиллагаа ны зардал	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Хөрөнө оруулалт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
Нийт зардал	0.00	0.00	860.00	860.00	0.00	0.00	0.00

Зураг 1.4. ШУТИС-ийн төсвийн программ хангамж


Орлогын төсвийн төсөл, зарлагын төсвийн төсөл, зардал (сургалтын бичиг хэргийн зардал, захиргааны бичиг, шуудан холбоо.. г.м) байдлаар салбар, нэгжээр төсөвлөгдөхөөр программчлагдсан. Салбар сонгох хэсэгт бусад гэсэн салбарт захиргаа, үйлчилгээний хэсгийг хамруулсан болно.

Орлогын төсвийн төслийг төсөвлөхөд сургалтын төлбөрийн орлогыг курс болгоноор нь төсөвлөхөөр оюутны тоог гараас оруулахаар, кредит сонголт тухайн сургуулийн оюутнууд жилд дунджаар хэдэн кредит сонгогдогос хамааран 30-34 кредитүүдээс сонгогдох байдлаар программчлагдсан.


Цалингийн зардлын хувьд U-Finance 3.0 программ татагдахаар холболт хийж программчилсан болно. 2021 оныг сонгож “цалин татах” дээр дарж цалинг хүн нэг бүрээр татагдахаар хийж өгсөн. Жишээлбэл: сургалтын албаны ажилтны тоо, нэг бүрийн үнэ ээ гараас оруулж өгөхөд сургалтын албаны ажилтны бичиг хэргийн зардлын нормыг программчилсан учраас нийт дүнг бодож төсөвлөөд зардлын төсвийн төслийн нэгтгэл хэсэгт очиж товчоологдоно. Дээр өгөгдсөн тайлбарын дагуу 2021 оны төсвийн төслөө төсвийн программаар хийж гүйцэтгэнэ.

Бүрэлдэхүүн сургууль нэгжүүдээс ирүүлсэн саналыг хянаж боловсруулан төсвийн хэлэлцүүлэг зохион байгуулж ШУТИС-ийн захирлын зөвлөлийн хуралд танилцуулсан. ШУТИС-ийн УЗ-ийн 12 дугаар сарын 05-ны өдрийн 13 тоот тогтоолоор орлогын төсвийг 59,070.0 сая төгрөгөөр, зарлагыг 59,069.9 сая төгрөгөөр, үүнээс 2.7 тэрбум төгрөгөөр хөрөнгө оруулалт худалдан авалт хийхээр баталсан.

Цар тахалтай холбоотойгоор ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, нэгж, захиргаа нь БСШУС-ын Сайдны А/43, А/95 тоот тушаалуудын дагуу 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлаас цахим хэлбэрээр сургалтын үйл ажиллагааг явуулах болсон нь ШУТИС-ийн 2020 оны төсвийн тодотгол хийх үндэслэл болж төсвийн орлогыг 1,150.7 сая төгрөгөөр бууруулж 57,919.3 сая төгрөгөөр зарлагыг 1,272.1 сая төгрөгөөр бууруулж 57,797.8 сая төгрөгөөр баталлаа. Нийт орлогын 59.8 хувь нь сургалтын төлбөрийн орлого байна. Нийт зардлын 60.3 хувь нь сургалттай холбоотой шууд зардал байна.



**Зураг 1.5. ШУТИС-ийн 2020 оны төсөв, орлогын бүтэц
(сая төгрөг)**



**Зураг 1.6. ШУТИС-ийн 2020 оны зардлын бүтэц
(сая төгрөг)**


1.4.2. ТӨВЛӨРСӨН БУС МЭДЭЭЛЛИЙН СТАТИСТИК ТАЙЛАН

ШУТИС-ийн захирал, дэд захирлууд, 21 газар, албад, 10 бүрэлдэхүүн сургууль, төв, нэгжүүдэд шаардлагатай байгаа тоон мэдээ мэдээллийг цаг алдалгүй гаргаж өгөх ажлыг хийж гүйцэтгэж байна.


БСШУСЯ-ы Сайдын 2003 оны №221 тушаалын дагуу 2019-2020 оны хичээлийн жилийн Төвлөрсөн бус мэдээллийн ДБ1-ДБ13 хүртэлх маягтуудыг нэгтгэн хянаж БСШУЯ-нд хүргүүлсэн.

ДБ-1 Суралцагчид /мэргэжил, анги, хүйсээр/, ДБ-2 Суралцагчдын сургалтын зардал, хангамж /ангиар/, ДБ-3 Суралцагчид /дотоод, гадаад, нас хүйсээр/, ДБ-5 Удирдах ажилтан багш, ДБ-7 Суралцагчдын орон нутгийн харьяалал, ДБ-8 Суралцагчдын шилжилт хөдөлгөөн /гадаад, дотоод, ангиар/, ДБ-9 Ажиллагсад, ДБ-10 Үндсэн багшийн хөдөлгөөн, ДБ-12 Хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, ДБ-13 Гадаад суралцагчид.

2017-2018 оны хичээлийн жилд 19145 оюутан, 2018-2019 оны хичээлийн жилд 18057 оюутан суралцсан, 2019-2020 оны хичээлийн жилд оюутны тоо 15414 буюу 14,1%-иар буурсан байна. Нэг багшид ноогдох оюутны тоо: 2018-2019 оны хичээлийн жилд 19 байсан бол 2019-2020 оны хичээлийн жилд 16 болсон байна.




Зураг 1.7. ШУТИС-д бакалавр, магистр, докторын сургалтад суралцаж буй оюутны тоо (сүүлийн 3-н жилээр)



Зураг 1.8.Бакалаврт сурч буй суралцагчдын тоо (сүүлийн 3 жилээр)


2019-2020 оны хичээлийн жилд бакалаврын түвшинд суралцагчдын тоо 2204 оюутнаар буурсан (зураг 1.7).




	1-р курс	2-р курс	3-р курс	4-р курс	5-р курс
■ 2017-2018 оны хичээлийн жил намар 17,068	4,261	3,239	2,237	3,602	3,729
■ 2018-2019 оны хичээлийн жил намар 16,016	4,271	3,694	2,873	1,914	3,264
■ 2019-2020 оны хичээлийн жил намар 15,414	2,624	4,378	3,430	2,575	2,407

Зураг 1.9. Бакалаврт суралцагчдыг курсээр ангилсан байдал (сүүлийн 3 жилээр)

2-р курст хамгийн олон оюутан суралцаж байна. (3239-өөс 4378 хүртэл 1139 оюутнаар өссөн)



Зураг 1.10. Магистрт суралцагчдыг курсээр ангилсан байдал (сүүлийн 3 жилээр)



Зураг 1.11. Докторт суралцагчдыг курсээр ангилсан байдал (сүүлийн 3 жилээр)
Нийт суралцагчдын тоо /насны ангиллаар/

Хүснэгт 1.5

Насны ангилал	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил	2019-2020 оны хичээлийн жил
16 хүртэл	6	13	54
16 настай	113	120	44
17 настай	1091	1330	318
18 настай	3264	3239	2896
19 настай	3576	2968	2992
20 настай	3226	3132	2668
21 настай	2383	2285	2079
22 настай	1430	1324	1114
23 настай	797	699	567
24 настай	576	443	358
25 настай	387	360	224
26 настай	362	279	187
27 настай	283	241	172
28 настай	235	235	193
29 настай	182	171	170
30-34 настай	708	653	794
35-39 настай	288	365	358
40-өөс дээш	238	200	226
Бүгд	19145	18057	15414


Нийт суралцагчдын тоо /орон нутгаар/

Хүснэгт 1.6

Орон нутгийн харьяалал	2017-2018 оны хичээлийн жил	2018-2019 оны хичээлийн жил	2019-2020 оны хичээлийн жил
Архангай	1689	1557	1162
Баян-Өлгий	290	278	177


Баянхонгор	393	403	333
Булган	449	430	347
Говь-Алтай	479	433	394
Дорноговь	308	279	248
Дорнод	440	424	368
Дундговь	334	310	285
Завхан	706	685	587
Өвөрхангай	909	868	771
Өмнөговь	288	292	281
Сүхбаатар	271	290	252
Сэлэнгэ	514	475	500
Төв	542	525	368
Увс	814	728	655
Ховд	669	594	436
Хөвсгөл	895	817	658
Хэнтий	474	436	378
Дархан-Уул	622	573	774
Улаанбаатар	6516	6269	5349
Орхон	1349	1180	961
Говь-Сүмбэр	86	104	78
Гадаад	8	7	52
Бүгд	19145	18057	15414

ШУТИС-д суралцаж буй гадаад оюутны тоо




Зураг 1.12. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутан (сургууль тус бүрээр)

ШУТИС-ийн гадаад оюутны тоо нь өнгөрсөн хичээлийн жилээс 48 хувиар өссөн ба нийт суралцагчдын 0.3 хувийг эзэлж байна. Улсаар нь авч үзвэл БНХАУ-ын суралцагч хамгийн олон байна. Гадаад оюутны тоо нь нийт суралцагчдын тоонд орсон болно.



Зураг 1.13. ШУТИС-д суралцаж буй гадаад оюутан (орон бүрээр)


2019-2020 оны хичээлийн жилд шинээр элсэгч оюутны мэдээлэл




Зураг 1.14. ШУТИС-ийн бакалаврын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)

Сүүлийн 3-н жилийн байдлаар ШУТИС-д дунджаар 3483 бакалавр, 528 магистр, 79 доктор оюутан элссэн байна.


ШУТИС-КООСЭН ТК




ШУТАС



Зураг 1.15. ШУТИС-КООСЭН” ТК болон Ахлах сургуульд шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)



Зураг 1.16. ШУТИС-ийн магистрын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)




Зураг 1.17. ШУТИС-ийн докторын сургалтад шинээр элсэгчид (сүүлийн 3-н жилээр)

ШУТИС-ийг төгсөгчдийн мэдээлэл (сүүлийн 3 хичээлийн жилээр)


Хүснэгт 1.7

Д/д	Төрөл	2017-2018 хичээлийн жил	2018-2019 хичээлийн жил	2019-2020 хичээлийн жил
1	Бакалавр	3484	2519	2394
2	С Диплом /Бакалавр/	122	133	131
3	Магистрын төгсөлт	551	668	658
4	Докторын төгсөлт	27	59	22
5	ШУТАС	57	27	57
6	“ШУТИС-КООСЭН” ТК	0	24	22
БҮГД		4241	3430	3284



Зураг 1.18. ШУТИС-ийг бакалавр мэргэжлээр төгсөгчид (сүүлийн 3-н жилээр)

Сүүлийн 3-н жилд дунджаар ШУТИС-ийн бакалаврын сургалтыг 2799 оюутан төгссөн байна. Сүүлийн жилүүдийн дунджаас харахад нийт элссэн оюутны 80,4 хувь нь төгссөн байна.



- Удирдах ажилтан 4.4%
- Сургалтын ажилтан 11.6%
- Аж ахуй үйлчилгээ 16%
- Үндсэн багш 53%
- Захиргааны ажилтан 15%


Зураг 1.19. ШУТИС-ийн нийт багш, ажилтан, ажилчид (2020 оны 03 сарын байдлаар)

Нийт багш ажилтны тоо

Хүснэгт 1.7

Төлөв	Бүрэлдэхүүн сургууль	Ахлах сургууль	МСҮТ	Хүрээлэн	Төв ШУТИС	БҮГД
Удирдах ажилтан	43	1	3	4	33	84
Үндсэн багш	950	28	30	0	0	1008
<i>Доктор зэрэг цолтой</i>	359	1	2	0	28	390
Сургалтын ажилтан	199	3	3	0	16	221
Захиргааны ажилтан	123	3	4	21	137	288
Аж ахуй үйлчилгээ	205	2	5	12	79	303
Нийт	1520	37	45	37	265	1904

Багшийн тоо бүрэлдэхүүн сургуулиар




Зураг 1.20. ШУТИС-ийн нийт профессор багш нарын тоо (бүрэлдэхүүн сургуулиар)

Нийт 13 бүрэлдэхүүн сургуулийн үндсэн багш нараас гадна 3 ахлах сургууль, МСҮТ-ийн 3 салбарын багш нарын тоог нэмээд 1008 үндсэн багштай байна.

2020 оны 3 сарын байдлаар багшийн тоо

Хүснэгт 1.8.

Бүрэлдэхүүн сургууль		Үндсэн багш	Дадлагажигч багш
1	БАС	100	3
2	БУХС	99	1
3	БАТС	11	
4	ГУУС	96	
5	ДТС	71	
6	МехТС	73	1
7	МХТС	108	1
8	ҮТС	70	2
9	ХШУС	104	2
10	ЭХС	59	5
11	ГХС	91	
12	ОрТС	34	3
13	“ШУТИС-Коосэн” ТК	16	
14	ШУТАС	16	
15	Дархан АС	7	
16	Орхон АС	5	
17	МСҮТ-3 салбар	30	
БҮГД		990	18




Зураг 1.21. ШУТИС-ийн доктор цолтой профессор багш нарын тоо

(бүрэлдэхүүн сургуулиар)

ШУТИС-ийн профессор багш нарын ангилал


Хүснэгт 1.9

Он	Салбар, тэнхимийн эрхлэгч	Зөвлөх профессор	Проф	Дэд проф	Ахлах багш	Багш	Дад.жигч багш	Нийт багш
2019	45	23	43	82	402	372	23	990
2020	46	20	36	84	380	366	18	950




Зураг 1.22. ШУТИС-ийн нийт ахлах багшийн тоо (2020 оны 03 сарын байдлаар)

2019 оны 1 сарын байдлаар 13 бүрэлдэхүүн сургуулийн 967 үндсэн багш, дадлагажигч 23, нийт 990 багшийн 40,6% нь буюу 402 нь ахлах багш үүнээс 141 буюу 35.07% нь доктор зэрэгтэй байна.



Зураг 1.23. ШУТИС-ийн доктор цолтой ахлах багшийн хувь (2020 оны 03 сарын байдлаар)

2020 оны 3 сарын байдлаар 13 бүрэлдэхүүн сургуулийн 932 үндсэн багш, 18 дадлагажигч нийт 950 багшийн 380 буюу нийт багшийн 40% нь ахлах багш, тэдгээрийн 149 багш (39.2%) нь докторын зэрэгтэй байна.



Зураг 1.24. ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургуулиудын салбар тэнхимийн тоо

2019-2020 оны хичээлийн жилд 13 бүрэлдэхүүн сургуулийн 47 салбар тэнхимтэй үйл ажиллагаа явуулав.

ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтан, оюутны тооны харьцаа (бүрэлдэхүүн сургуулиар)

Хүснэгт 1.10


Д/Д	Бүрэлдэхүүн сургууль	Удирдах ажилтны тоо	Захираганы ажилтны тоо	Сургалтын ажилтны тоо	Үйлчилгээний ажилтны тоо	Багшийн тоо	НИЙТ Оюутан тоо	нэг багшид ноогдох оюутны тоо
1	БАС	3	8	15	25	103	2,370	23.0
2	БУХС	3	11	13	20	100	1,130	11.3
3	БАТС	3	4	2	1	11	439	39.9
4	ГУУС	3	9	24	18	96	1,682	17.5
5	ДаТС	3	12	14	17	71	1,223	17.2
6	МехТС	3	10	21	28	74	1,487	20.1
7	МХТС	4	11	20	23	109	1,675	15.4
8	ҮТС	3	9	23	22	72	1,874	26.0
9	ХШУС	3	5	21	13	106	343	3.2
10	ЭХС	3	7	22	14	64	2,247	35.1
11	ГХС	4	5	6	1	91	195	2.1
12	ОртС	4	24	15	22	37	495	13.4
13	НБТ	2	5	2			89	
14	“ШУТИС-КООСЭН” ТК	2	3	1	1	16	165	10.3
	нийт	43	123	199	205	950	15,414	16.2
1	Ахлах Сургууль	1	3	3	2	28	385	
	• ШУТАС	1	3	1	2	16		
	• ДарАС			2		7		
	• ОрАС					5		
2	МСҮТ	3	4	3	5	30	773	
3	Хүрээлэн	4	21	-	12	-		
4	Төв ШУТИС	33	137	16	79			
	нийт	45	173	25	99	74	1,412	
	БҮГД	84	288	221	303	1,008	16,572	16.4

1.4.3. МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ЧИГЛЭЛЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

Мэдээлэл технологийн төв нь ШУТИС-2030 стратеги төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл 5 хариуцлагатай, хурдацтай өөрчлөлтөд нийцэх өндөр бүтээмжийн төлөө ухаалаг менежментээр ажиллах, суралцах судалгаа хийхэд тохиромжтой орчин дэд бүтцийг бүрдүүлж хэвийн байлгах зорилтын хүрээнд үндсэн 3 зорилгыг боловсруулан болгон ажиллаж байна. Үүнд:


- Их дээд сургуулийн удирдлагын мэдээллийн системийг процессын реинженерингтэй уялдуулан загварыг тодорхойлж боловсруулах;
- Бусад мэдээллийн системүүдийг улам боловсронгуй болгох;
- Мэдээллийн аюулгүй байдал хамгааллыг хангах;

Их, дээд сургуулийн удирдлагын мэдээллийн систем нь дараах үндсэн болон дэд модулиас бүрдэн ажиллаж байна.



Зураг 1.25. ШУТИС-ийн удирдлагын мэдээллийн систем

2019-2020 оны хичээлийн жилийн зорилтын хүрээнд Мэдээллийн технологийн чиглэлээр дараах 10-н багц ажил, программ хангамжуудыг хийж гүйцэтгэлээ.



Зураг 1.26. 2019-2020 оны хичээлийн жилийн зорилтын хүрээнд Мэдээллийн технологийн чиглэлээр гүйцэтгэсэн багц ажлууд

Мэдээллийн технологийн хүрээнд шинээр хэрэгжүүлсэн, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ

○ ШУТИС-ийн цахим хуудас

ШУТИС-ийн шинэ цахим хуудас буюу <https://www.must.edu.mn> нь захиргаа засаглал, сургалт, эрдэм шинжилгээ, инноваци, оюутан хамтын ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа, стратеги төлөвлөгөө зэрэг олон салбарын мэдээ мэдээлэл, үйл ажиллагааг нэгтгэн профессор, эрдэмтэн судлаач, багш, оюутан болон нийтэд хүргэдэг цахим хуудас юм.




ЗОХИОН БАЙГУУЛАГДАЖ БҮЙ АРГА ХЭМЖЭЭ
Сургуулийн хэмжээнд зохих байгуулагдаж буй арга хэмжээ



ШУТИС-ийн дүрэм, журмын шинэчлэлд санал авч байна

ШУТИС-ийн 2020-2021 оны хөгжлийн жилийн цагийн үннээг сургалтын элсэлтийн бүртгэл дүгээр сарын 16 нөхц 10 дугаар сарын 21-ний хооронд явагдана

Мэргэжлээ



Зураг 1.27. ШУТИС-ийн цахим хуудас

Сургуулийн цахим хуудас нь өдөрт дунджаар 3000 – 5000, сард 30000 – 90000, хандалттай байдаг. Хандалтын 40-50% нь ШУТИС-ийн эрдэмтэн судлаач, багш, ажилчид байна. ШУТИС цахим хуудасны хандалтын статистикаас харахад 60-70% нь гар утаснаас үлдсэн нь бусад төрлийн төхөөрөмжөөс ханддаг бөгөөд цахим хуудас нь гар утсанд тохиромжтой технологийн шийдэл дээр хийгдсэн.




Зураг 1.28. ШУТИС-ийн цахим хуудас дахь статистик үзүүлэлт

○ **Элсэлтийн цахим хуудас, синхрон технологи**

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2020-2021 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт суралцагчдыг элсүүлэх, бүртгэх, баталгаажуулах, мэргэжил сонголт хийх, суралцах гэрээ байгуулах, сургалтын албаны систем рүү шинэ элсэгчдийг автоматаар бүртгэх үйл явц, мөн ахлах сургууль, Коосен, бакалавр, магистр, докторын хөтөлбөрт элсэгчдийг бүртгэх үйл ажиллагааг удирддаг программчлалын шинэ технологи дээр хийгдсэн веб юм.



Энэхүү цахим хуудас нь зураг дээр харуулсан элсэлтийн бүртгэлээс эхлээд ШУТИС-ийн оюутан болох хүртэл бүхий л үйл ажиллагааг цахимаар явуулдаг давуу талтай юм. Элсэлтийн бүртгэлийг цахимаар явуулснаар элсэгчийн талаарх мэдээллийн сан үүсгэх бөгөөд удирдлагын түвшинд шаардлагатай төрөл бүрийн өгөгдлийн анализ хийх боломжийг бий болгодог.



Зураг 1.29. Элсэлтийн цахим хуудас, синхрон технологи

○ Цахим сургалтын веб /админ, статистик, багш, оюутан/

Хөтөлбөр баталгаажуулах


№	Бүлэг	Мэргэжил	Хөтөлбөр баталгаажуулах хугацаа	Хөтөлбөр баталгаажсан ЭСХ
1	3	Үйлдвэрлэлийн дизайн	2020/06/20 19:18:45	1 Хөтөлбөр баталгаажаагүй

Баталгаажуулах төлбөр: 270000 2
Хамгийн багадаа 270 000Т төлнө.

Төлбөр төлөх банк сонгох: Худалдаа хөгжлийн банк 3
Та төлбөр төлөх банк аа сонгоно уу?

4 Төлбөр төлөх БУЦАХ 5

Зураг 1.30. Цахим сургалтын веб /админ, багш, оюутан/



Зураг 1.31. Цахим сургалтын веб /статистик, багш /


Нийгмийн хөгжил, технологийн дэвшилтэй уялдан мэдээллийн хэмжээ асар их болж тэр хэрээр сургалтын процесс шинэчлэгдэн цахим хэлбэрт шилжиж байна. ШУТИС-ийн цахим сургалтын системийг шинэчлэн хөгжүүлж профессор багш,

оюутнуудын хэрэглээнд бүрэн нэвтрүүлээд байна. Цахим сургалтын системийг хяналтын удирдлагын системтэй болгож бүх төрлийн файл, онлайн мессенжерээс үзэх болсон.

Цахим сургалтын системийн давуу талуудыг дурдвал:

- Бүх төрлийн файл хүлээж авах, илгээх
- Багш, оюутнууд хоорондоо харилцах онлайн чат
- Багш оюутнуудын ирц, идэвхийг үнэлэх
- 24/7 хичээлийн материал үзэх
- Хичээлийн хуваарь харах
- Санал асуулга явуулах
- Сэтгэгдэл бичих
- Хяналтын удирдлагын систем
- Гар утас, компьютер, ipad, tablet зэрэг төрөл бүрийн төхөөрөмжид тохирсон технологи дээр хөгжүүлсэн

ЦАХИМ СУРГАЛТ



ИДЭВХТЭЙ ТӨЛӨВ: ӨДӨР

Барилга, Архитектурын сургууль
Архитектурын салбар
А.ЕД44 Ц.ОТГОНБАЯР /Багш/

Төлөв сонгох

ЭЧНЭЭ

ОРОЙ

Хичээлүүд

Архитектурын хар зураг /А.АР103/

Хотын экстерьерийн зураг /А.АР341/

Дүрслэх геометр /S.ED101/

A.AR103 хичээлийг үзэж байгаа оюутнууд

Show 10 rows Print Copy PDF Excel Search:

№	Сургууль	Оюутны код	Оюутны нэр	Утас	Нэгтгэсэн тоо	Нийт хугацаа /мин/	Дундаж хугацаа	7 хоногт дундажаар
1	БАС	B161320007	Э.БААТАРХҮҮ	99173717	30	700.8	23.4	87.6
2	БАС	B171320005	М.НЯМЦОГ	90404454	0	0.0	0.0	0.0
3	БАС	B171320125	ГИДЭРСАЙХАН	97199110	22	675.4	30.7	84.4
4	БАС	B161320085	А.МӨНХБАТ	99788527	23	682.8	29.7	85.3
5	БАС	B181320143	М.МӨНХИШИГТ	88059280	69	2,334.3	33.8	291.8
6	БАС	B181320149	С.МАРГАД-ЭРДЭНЭ	89699925	16	339.1	21.2	42.4
7	БАС	B191320011	Н.АНУЖИН	99530373	49	2,856.3	58.3	357.0
8	БАС	B191320048	Г.МӨНХТҮШИГ	88778966	57	448.6	7.9	56.1
9	БАС	B191320056	Т.НАНДИНЗҮЛ	90343485	42	5,864.7	134.9	708.1
10	БАС	B191320103	Г.ЧУЛУУНЦЭЦЭГ	80700235	20	701.2	35.1	87.6

Showing 1 to 10 of 62 entries Previous 1 2 3 4 5 6 7 Next

© 2020 Мэдээллийн технологийн төв


Зураг 1.32. Цахим сургалтын веб /оюутан/

○ Гар утасны аппликейшн /оюутан, багш/

Өнөө үед ухаалаг утас хэрэглэгч ихээр нэмэгдсэнээр төрийн болон бизнесийн бүхий л үйлчилгээ гар утсанд шилжиж байна. Оюутнуудын вэб хэрэглээ гар утас руу нэвтэрч, хэрэглээг боловсронгуй болгох, хялбарчлахын тулд гар утасны аппликейшныг хөгжүүлэн нэвтрүүлээд байна.




Гар утасны аппликейшн нь android болон IOS–д зориулагдсан сүүлийн үеийн технологи дээр суурилж, цахим сургалтын хэсгийг багтааснаараа давуу талтай болсон.



Зураг 1.33. Гар утасны аппликейшн /оюутан, багш/

○ Оюутны мэйл хаяг



Зураг 1.34. Оюутны мэйл хаяг

Онлайн сургалтын орчинд багш, оюутнууд холбогдож ажиллахад мэйл хаяг зайлшгүй шаардлагатай юм. ШУТИС-ийн бүх оюутанд зориулсан must.edu.mn мэйл хаягийг Google –ийн GSuite багцаар үүсгэсэн. Google цахим сургалтын багц болох GSuite for Education нь боловсролын систем дэх мэдээллийн технологийн дэвшил, боловсролын тогтолцоог хөгжүүлэх, багшийг чадавхжуулж ажлын ачааллыг нь хөнгөвчлөх, сурагчдын цахим хэрэглээг эрүүлжүүлэх зорилготой багц юм. GSuite давуу тал нь их дээд сургуулиудад үнэ төлбөргүй ашиглах боломжтой.

○ Мэдээллийн аюулгүй байдал, сүлжээ

Сүлжээний орчинд хамгаалах төхөөрөмжийг суурилуулж, тохиргоо үүсгэж, дэд сүлжээний gateway-г бүрдүүлж менежмент хийсэн бөгөөд гол үүрэг нь сүлжээний урсгал дээр хяналт тавих (ACL-access control lists), шүүлт хийх үйлчилгээг балансалсан ба мөн бусад тохиргоо, төхөөрөмжүүдийг суурилуулж гүйцэтгэсэн.

- CISCO ISR 4461 Router
- Cisco ASA-5585X Firewall
- SSL
- Encryption
- Various type of Encryption tools

○ Logstash

Log stash бол олон төрлийн эх сурвалжаас өгөгдлийг авч, хөрвүүлэн боловсруулалт хийж систем болон программ руу илгээдэг. Log stash нь серверийн талын өгөгдөл боловсруулах, дамжуулах систем бөгөөд өгөгдлийн төрөл бүрийн эх сурвалжаас задалж хадгалах, өгөгдлийг боловсруулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх зориулалт бүхий систем юм. Өгөгдлийн бүтцээс үл хамааран задалж дүн шинжилгээ хийх, их өгөгдлийг боловсруулах, боломжтой судалгааны ажлыг хийж сервер болон өгөгдөл дамжуулалтыг туршилтын кодчиллыг зарим системүүд дээр туршсан.


○ Google analytics API ашиглах

Их сургуулийн цахим хуудаст хандах хэрэглэгчдийн үйл ажиллагааг тодорхойлох зорилгоор google analytics-ийн API-ийг ашиглан цахим хуудаст нэвтэрсэн хандалтыг дараах байдлаар нэгтгэж, аюулгүй байдлыг хангах талаар туршилт хийсэн.

- Audience - хандалтуудыг хаанаас, аль улсаас, ямар хэлтэй, нас, хүйс, сонирхол гэх мэт үзүүлэлтүүд;
- Technology - хандалтууд ямар интернэт хөтөч ашигладаг, үйлдлийн систем нь юу болох, суурин компьютер, гар утасны алийг нь голлон ашигладаг талаар;
- Behavior - хандалтын аль хуудас хамгийн өндөр үзүүлэлттэй, хэр хугацааг вебд өнгөрөөж байгаа талаар;
- Behavior Flow - хандалт вебийн аль хуудаснаас эхлэн ямар хуудсаар дамжин хаана хүрч байгаа зам зэрэг үзүүлэлтүүдээр;

Page	Pageviews	Unique Pageviews	Avg. Time on Page	Entrances	Bounce Rate	% Exit	Page Value
	33,500 % of Total: 100.00% (33,500)	27,399 % of Total: 100.00% (27,399)	00:02:21 Avg for View: 00:02:21 (0.00%)	19,991 % of Total: 100.00% (19,991)	76.94% Avg for View: 76.94% (0.00%)	59.67% Avg for View: 59.67% (0.00%)	\$0.00 % of Total: 0.00% (\$0.00)
1. /mn/	19,809 (59.13%)	16,380 (59.78%)	00:03:53	16,105 (80.56%)	78.16%	74.48%	\$0.00 (0.00%)
2. /mn/event/9268	355 (1.06%)	328 (1.20%)	00:05:08	68 (0.34%)	72.06%	47.32%	\$0.00 (0.00%)
3. /mn/content/show/id/9004	309 (0.92%)	286 (1.04%)	00:02:37	210 (1.05%)	82.38%	79.61%	\$0.00 (0.00%)
4. /mn/content/show/id/9049	303 (0.90%)	266 (0.97%)	00:02:42	187 (0.94%)	75.40%	70.30%	\$0.00 (0.00%)
5. /mn/news/9270	274 (0.82%)	207 (0.76%)	00:02:26	75 (0.38%)	80.00%	44.53%	\$0.00 (0.00%)
6. /mn/page/209	242 (0.72%)	181 (0.66%)	00:02:28	50 (0.25%)	86.00%	50.83%	\$0.00 (0.00%)
7. /mn/page/479	237 (0.71%)	203 (0.74%)	00:02:55	78 (0.39%)	64.10%	59.92%	\$0.00 (0.00%)
8. /mn/page/342	232 (0.69%)	146 (0.53%)	00:00:24	22 (0.11%)	13.64%	4.31%	\$0.00 (0.00%)
9. /en/	217 (0.65%)	161 (0.59%)	00:01:37	71 (0.36%)	50.70%	39.17%	\$0.00 (0.00%)
10. /mn/annlist	214 (0.64%)	156 (0.57%)	00:00:38	19 (0.10%)	57.89%	13.08%	\$0.00 (0.00%)

Зураг 1.35. Хандалт өндөр хуудасны үзүүлэлт



Зураг 1.36. Хандалтын хэлбэр

○ ШУТ-ийн төв номын сангийн динамик цахим хуудас /захялга, цахим номын хөрвүүлэлт, e-баримт/

ШУТ-ийн төв номын сан нь профессор багш, оюутан эрдэм шинжилгээний ажилтнууд, нийт уншигчдад шинжлэх ухаан технологийн чиглэлээр мэдлэг

боловсролоо хөгжүүлэх, боловсрол эзэмших электрон мэдээллийн нээлттэй үйлчилгээ, сургалтын үйл ажиллагааг дэмжинэ.




Зураг 1.37. ШУТ-ийн төв номын сангийн динамик цахим хуудас

Электрон мэдээллийн нээлттэй үйлчилгээ Шинжлэх ухаан технологийн их сургуулийн оюутнуудад мэргэжлийн ном, хэвлэл, багшийн бүтээл, судалгааны материал унших, танилцах хичээлээс бусад цагийг үр ашигтай зарцуулах эрэлт хэрэгцээг хангана.

○ EDX Нээлттэй боловсрол

MIT, Harvard, University of California, Boston University, Cornell зэрэг топ их сургуулиас гадна Microsoft, IMF, MongoDB, Amnesty International зэрэг дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн компани, байгууллагуудын хичээлүүдийг үзэх боломжтой платформ юм. Нийтэд зориулсан онлайн хичээлийг монгол хэлээр бэлтгэн, цахим сургалтын үеэр видео, интерактив агуулгуудыг хаанаас ч үзэх боломжтой нээлттэй системийг нутагшуулав.



Зураг 1.38. EDX Нээлттэй боловсрол

1.5. ШУТИС-ИЙН МУЗЕЙ

ШУТИС-ийн хөгжлийн 60 жилийн ойг тэмдэглэх ажлын хүрээнд их сургуулийн музейг шинэчлэн байгуулж, байнгын үйл ажиллагаатай болгох санаачилгыг ректор Б.Очирбат дэвшүүлж улмаар их сургуулийн Эрдмийн болон Ректорын зөвлөлөөр хэлэлцэн дэмжиж, ШУТИС-ийн ректорын 2019 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/43 тоот тушаалаар “ШУТИС-ийг олон нийтэд танилцуулах, сурталчлах, Монгол Улсын дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи, нийгэм соёлын хөгжилд ШУТИС-ийн оруулсан хувь нэмэр, дэвшилтэт техник технологийг гадаад, дотоодын зочид, багш, ажилтан, оюутан, суралцагч, олон нийтэд үзүүлж таниулах” зорилгоор ШУТИС-ийн Музейг шинэчлэн байгуулах шийдвэр гаргаж улмаар ШУТИС-ийн 60 жилийн ойг тохиолдуулан 2019 оны 12 дугаар сарын 27-ны өдөр тус музейн нээлтийн арга хэмжээ зохион байгуулагдаж албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн юм.



Зураг 1.39. ШУТИС-ийн музейн нээлтийн үйл ажиллагаа

ШУТИС-ийн Музей байгуулсан асуудлыг сургуулийн удирдах зөвлөлийн 2020 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн хурлаар хэлэлцээд захиргааны бүтцэд “ШУТИС-ийн Музей”-г 2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн байнгын ажиллагаатай болгох, музейн эрхлэгч, мэргэжилтэн, ажилтны албан тушаалын орон тоог баталсан болно.

ШУТИС-ийн Музей нь байнгын үзмэрийн дөрвөн танхимтай. Үүнд:

1. ШУТИС-ийн хөгжлийн түүхэн замнал
2. “Монголын эртний нүүдэлчдийн өв” археологийн олдвор
3. Шинжлэх ухаан, технологи ба инноваци
4. Шинжлэх ухааны танин мэдэхүй

Музейн хамт олон 2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд музейн хөгжлийн бодлого, хэтийн төлөв, сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инноваци, сурталчилгааны орчин бүрдүүлэх гэсэн хөгжлийн тэргүүлэх чиглэл, стратегийн зорилтын хүрээнд үйл ажиллагааны үндсэн гурван чиглэлд дүгнэж болох 30 шалгуур үзүүлэлт тусган ажиллаж байна.

Музейн бүтэц, зохион байгуулалтыг стандартын дагуу сургуулийн удирдах зөвлөлөөр батлуулан албан тушаалын 3 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.



Зураг 1.40. ШУТИС-ийн Музей нь байнгын үзмэрийн 4 танхим

Музейн эрхлэгч, мэргэжилтэн, ажилтан нарын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолт, ажлын байрны үйл ажиллагааны хуваарь, албан тушаалын гүйцэтгэх чиг, үүрэг, музейн дотоод журам, сан хөмрөгийн мэдээлэл ашиглах заавар зэргийг стандартын дагуу боловсруулан сургуулийн удирдлага, захиргаа, хүний нөөцийн газраар батлуулав.

Удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн “ШУТИС-ийн музей байгуулах тухай” 02 тоот тогтоол, Удирдах зөвлөлийн мөн өдрийн хурлын шийдвэр, музейн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ШУТИС-ийн музейн үзмэрийн бүртгэл, тооллого явуулж, үзмэрүүдийг тодорхойлох, үнэлэх ажлын хэсгийг ректорын 2020 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/78 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан юм. Тушаалын дагуу музейн үндсэн хөрөнгө, эд материал, үзмэр, дурсгалын эд зүйлийн тооллого хийлээ.

- Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албатай 2020.03.02-ны өдрийн 03/04 тоот хамтран ажиллах гэрээг байгуулав. Энэхүү гэрээний хүрээнд Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлээр хамтран ажиллахдаа хоёр тал хамтарсан сургалт, семинар, эрдэм шинжилгээний хурал зэргийг зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох, туршлага судлах, хамтарсан судалгаа хийх, үндэсний аюулгүй байдлын бодлого боловсруулахад тус их сургуулийн профессор, багш, судлаачдын судалгааны ажлын үр дүнг тусгах зэргийг заасан.

- Түүнчлэн Эрдэнэс-Тавантолгой ХК-тай хамтран ажиллах гэрээ хэлэлцээр хийгдэхээр бэлтгэл ажлыг хангаж байна.


ШУТИС-ийн Бүрэлдэхүүн сургуулиуд 2019-2020 онд байгуулсан гэрээ, санамж бичиг: Бүрэлдэхүүн сургуулиуд эрдэм шинжилгээ, туршилт судалгаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлд 12 гэрээ, санамж бичгүүдийг байгуулан ажиллаж байна. Эдгээрээс 3 гадаад, 9 дотоодын байгууллагатай гэрээ байгуулсан байна.



Зураг 3.20. Бүрэлдэхүүн сургуулиудын байгуулсан гэрээ, санамж бичиг

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА


Эрдэм шинжилгээ, судалгааны төвүүдийн үндсэн үйл ажиллагаа, ажилласан байдал 2019-2020 оны хичээлийн жилд нийт 41 судалгааны төв үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явууллаа. Хэрэглээний шинжлэх ухааны сургуулийг түшиглэн суурь судалгааг хөгжүүлэх, шинэ мэдлэгийг бий болгох, нийгэм эдийн засгийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх судалгаа, төсөл хэрэгжүүлэх зорилго бүхий “Суурь судалгааны төв”-ийг шинээр байгуулж ажиллуулж эхлэлээ.



Зураг 3.21. Судалгааны төвүүдийн гүйцэтгэсэн ажлууд

3.9.ОЮУНЫ ӨМЧИЙН ЭРХИЙН ХАМГААЛАЛТ (АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРААР)

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн багш, судлаачид нийт 159 оюуны бүтээлд эрхийн хамгаалалт хийлгэсэн нь сүүлийн 5 жилийн хамгийн өндөр үзүүлэлт болов. Нийт хамгаалагдсан оюуны бүтээлийн 126 нь зохиогчийн эрхийн салбар, 33 нь аж үйлдвэрийн салбарын өмчид хамаарах патент, ашигтай загвар, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэгтийн гэрчилгээ бүхий хамгаалалт байна.



Зураг 3.22. Аж үйлдвэрийн өмчийн салбарын эрхийн хамгаалалт (2019-2020 оны хичээлийн жилд)



Зураг 3.23. 2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн багш, судлаачдын оюуны өмчийн эрхийн хамгаалалт



2019-2020 оны хичээлийн жилд эрхийн хамгаалалт хийгдсэн бүтээлийн жагсаалт
Хүснэгт 3.36

ПАТЕНТ			
д/д	Улсын бүртгэлийн дугаар	Шинэ бүтээлийн нэр	Зохиогч
1	10-0004677	Инженерийн байгууламжийн шугам хоолойд үүссэн хагарал, цууралтыг битүүмжлэх наалт, түүнийг хэрэглэх арга	Б.Мөнхтогтуур С.Чулуунхуяг, Х.Баатарсүрэн
2	10-0004821	Бал чулууны хүдрээс бал чулуу гарган авах арга	Т.Баттөмөр
3	10-0004822	х-Аl2O3 зөөгч бүхий никель суурьтай катализатор гарган авах арга	Э.Энхцэцэг, Б.Тунгалагтамир
4	10-0004813	Зэсийн баяжмалын автоклавын аргаар боловсруулж зэс гарган авах арга	П.Бат-Оч, А.Доржготов, Б.Энхболд
5	10-0004831	Роторын тэнцвэргүй байдлыг судлах туршилтын стенд	П.Ариунболор
6	10-0004843	Олон функцт дээж авагч өрмийн хошууны бүтээц	Л.Дүгэржав, Л.Цэвэрравдан
7	10-0004734	Өдөр тутмын эрүүл мэндийн хяналтын зүүдэг төхөөрөмж	Д.Эрдэнэчимэг Н.Чулуунбаатар Т.Энхбаатар Т.Амартүвшин
8	10-0004767	Том нүх сүвтэй керамзит үйлдвэрлэх арга	Ж.Амгалан М.Атарцэцэг
9	10-0004855	Сур элдэх хүндийн хүчний төхөөрөмж	Я.Ренчинванжил
10	10-0004853	Жишүү хүрдэт шигших төхөөрөмж	Я.Ренчинванжил, Г.Ганбаатар
11	10-0004795	Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодис үйлдвэрлэх шугам	О.Галаа, Б.Батболд, Я.Доржсүрэн

Ашигтай загвар

Хүснэгт 3.37

д/д	Улсын бүртгэлийн дугаар	Ашигтай загварын нэр	Зохиогч, хамтран зохиогч
1	20-0003143	Ноос, ноолуур угаах онгоц	Э.Оюунзаяа, Д.Пүрэвмагнай
2	20-0003132	Хар манжингийн ундаа үйлдвэрлэх арга	Э.Энхцэцэг, Ц.Минжмаа, Л.Энхцэцэг, Э.Лхамсүрэн
3	20-0003053	Зэрэгцээ ажиллаж байгаа зуухны утааны хийг өөр зуухны галлагаанд ашиглах зуухны нэмэлт хийц	Д.Балдандорж
4	20-0002952	Цахилгаан бойлерын бүтээц	Ч.Мангалжалав, Ц.Эрдэнэтуяа, З.Цэрэндорж, О.Чимэд
5	20-0003041	ЭШ-10/70 алхагч экскаваторын шанаганы сэнжийг хийх арга	Ц.Нанзад, Л.Баяраа, Г.Нарантуяа
6	20-0003039	ЭКГ5А экскаваторын явахын редукторын чангалах дугуйны гильз хийх арга	Ц.Нанзад, Л.Баяраа, Г.Нарантуяа
7	20-0003038	ЭКГ5А экскаваторын шанаганы ишний төгсгөлийн хязгаарлагчийг орлуулан хийх арга	Ц.Нанзад, Л.Баяраа, Г.Нарантуяа

8	20-0003150	Зөөврийн кабин шүршүүр	Н.Төмөрбаатар
9	20-0003122	Резин дугуйг халаах,хөргөх болон даралтын нөлөөнд турших битүүмжлэгдсэн төхөөрөмж	Н.Мөнхзул, Н.Пүрэвдорж, Ш.Далхжав, И.Базаррагчаа, Ц.Цэвэгжав
10	20-0003121	Дугуйн резин материалын хий нэвчилтийн хэмжээг тогтоох төхөөрөмж	Н.Мөнхзул, Н.Пүрэвдорж, Ш.Далхжав, И.Базаррагчаа, Ц.Цэвэгжав
11	20-0003076	Нисгэгчгүй нисэх аппаратын цахилгаан тэжээлийг дотоод шаталтын хөдөлгүүрээр хангах арга	Б.Эрдэнэбат, Б.Даваадалай, С.Батзориг, Х.Ганбаатар
12	20-0003079	Цэнэглэгдэх аккумуляторт нарны зайн хүчдэл тохируулагч электрон аппарат	Б.Эрдэнэбат, Г.Амармэнд, Н.Цогжавхлан, Х.Ганбаатар
13	20-0003120	Резин дугуйг дүүргэх хүчилтөрөгчийн хэмжээг тогтоох бага оврын төхөөрөмж	Н.Мөнхзул, Н.Пүрэвдорж, Ш.Далхжав, Ц.Дэлгэр, И.Базаррагчаа
14	20-0003075	Агаарын даралт тодорхойлогч төхөөрөмж	Г.Амармэнд, Ү.Жамсран, С.Чүлтэмсүрэн
15	20-0003077	Хавхалгагүй лугшилтат тийрэлтэт хөдөлгүүр	Б.Эрдэнэбат, Г.Шижир, Б.Цэнд-Аюуш, Т.Энхболд, Х.Ганбаатар, Б.Баасандорж
16	20-0003078	Задгай аэродинамик хоолой	Г.Амармэнд, Б.Эрдэнэбат, С.Чүлтэмсүрэн, Т.Энхболд
17	20-0003063	WC суурьтай хатуу хайлш	М.Дэлгэрмаа, Л.Тэлмэнбаяр
18	20-0003055	Баргилтын төмрийн хүдрийн баяжмалын хорголжийн найрлага болон хорголжлох арга	М.Дэлгэрмаа, А.Пүрэвдорж
19	20-0003105	Авто машины тоормосны наклад бэлтгэх арга болон хольцын найрлага	З.Баатар, Ч.Бямбацэрэн
20	20-0002954	“Борлонгийн ноолууран ээрмэл үйлдвэрлэх арга”	Г.Надмид, Г.Амарболд, А.Батсайхан, Б.Хонгорзул, Ж.Анхбаяр
21	20-0002997	“Ноос ноолуурыг ургамлын био бэлдмэлээр боловсруулах арга”	С.Цэрэндулам, Г.Надмид, Х.Соёл-Ундрах, Ч.Батсүрэн, Г.Батчимэг
22	20-0003062	Сур элдэх машин	Н.Өлзийбямба, Г.Бодьсайхан, С.Дамчаабадгар




ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГАА

ДӨРӨВ. ГАДААД ХАРИЛЦАА, ХАМТЫН АЖИЛЛАГАА

4.1. ШУТИС-ИЙН БАГШ, АЖИЛТНЫ ГАДААД ТОМИЛОЛТ, МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛЭЛТ

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн хэмжээнд нийт 22 багш, ажилтан гадаадад томилогдон явж ажилласнаас
 ШУТИС-ийн зардлаар 12 хүн,
 хүлээн авагч талын зардлаар 2 хүн,
 төслийн зардлаар 3 хүн,
 хувийн зардлаар 1 хүн,
 ЗГ, гадны байгууллагын зардлаар 1 хүн,
 ШУТИС, хүлээн авагч тал, төсөл, хувь хүн хамтарсан зардлаар 2 хүн тус тус явсан байна.



Зураг 4.1. ШУТИС-ийн гадаад томилолтыг чиглэлээр ангилан авч үзвэл:

Дээрх багш, ажилтнаас 8 хүн хамтын ажиллагааг хөгжүүлэх, хамтарсан хөтөлбөр, 12 хүн ЭШ судалгаа, төслийн ажилд оролцох ажлаар, 258 хүн ОУ-ын хурал, сургалт семинарт оролцох ажлаар, 2 хүн ОУ-ын үзэсгэлэн, уралдаан тэмцээнд оролцох ажлаар тус тус гадаадад томилогдон ажилласан байна.

Гадаадын хамтын ажиллагаатай их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад тухайн улсын тэтгэлэгт хөтөлбөрөөр магистр, докторын ахисан түвшний сургалтад хамруулан сургахаар төлөвлөгдсөн нийт 6 багш, ажилтны сургалт “Шинэ төрлийн Корона вирус COVID19”-ийн дэгдэлт, тархалтын нөхцөл байдлын улмаас цуцлагдсан болно.

Үүнд:

- ОХУ-д магистрантурын сургалтад хамрагдан сурах 2 хүн,
- Польш улсад докторантурын сургалтад хамрагдах 1 хүн,
- Япон улсад докторантурын сургалтад хамрагдах 1 хүн, магистрантурын сургалтад хамрагдан сурах 2 хүний сургалт цуцлагдсан.

4.2. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ, САНАМЖ БИЧИГ

2019-2020 оны хичээлийн жилд гадаад, дотоодын нийт 14 их дээд сургууль, эрдэм судалгааны байгууллагатай хамтын ажиллагааны гэрээг сунгаж, шинээр байгууллаа.

Шинээр хамтын ажиллагааны гэрээ, санамж бичиг байгуулсан гадаад, дотоодын их дээд сургууль, байгууллагууд

Хүснэгт 4.1

д/д	Сургууль, байгууллага	Улс	Гэрээний ангилал	Огноо
1	ОХУ-ын Эрчим хүчний их сургууль, Монгол-ОХУ-ын их сургуулиудын консорциум	ОХУ	гэрээ	2019.10.22
2	Намсүүл их сургууль	БНСУ	санамж бичиг	2019.09.16
3	Кванвүүн их сургууль	БНСУ	санамж бичиг	2019.10.19
4	Үндэсний бүтээмжийн төв	БНСУ	гэрээ	2019.09.02
5	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Монгол	гэрээ	2019.12.11
6	Брестийн Техникийн улсын их сургууль	Беларус	санамж бичиг	2019.09.13
7	Беларусын техникийн улсын их сургууль	Беларус	санамж бичиг	2019.09.13
8	Свас Кункуриент их сургууль ERASMUS+ төсөл	Турк улс	гэрээ	2019.09.06
9	Хонгконгийн UBTECH Robotics limited	БНХАУ	гэрээ	2019.10.15
10	“The Belt and Road Initiative” of Mining University	БНХАУ	гэрээ	2019.11.12
11	“Реко Азия” төслийн гэрээ	Итали	санамж бичиг	2020.07.08
12	Монгол КООСЭН технологийн коллеж	Монгол	санамж бичиг	2020.06.25
13	Таван толгой төмөр зам ХХК	Монгол	гэрээ	2020.07.10
14	Ерөнхий боловсролын Эрин Эверэст интернэйшнл сургууль	Монгол	гэрээ	2020.06.18
	Нийт 11 Үүнд: Монгол БНСУ БНХАУ ОХУ Беларус Турк Итали	4 3 2 1 2 1 1	Гэрээ-8 Санамж бичиг-6	

Мөн дээр дурдсанаас гадна Монгол дахь гадаадын ОУ-ын байгууллагууд, төлөөлөгчийн газруудтай идэвхтэй хамтран ажиллаж байна. Тухайлбал: Дээд боловсролыг хөгжүүлэх “1000 инженер” төслийн хүрээнд Японы ОУ-ын ЖАЙКА байгууллага, Мэдээллийн технологийн сургалт, судалгааны ажлыг хөгжүүлэхэд БНСУ-ын ОУ-ын КОЙКА байгууллагатай хамтран ажиллаж сургалт судалгааны чиглэлээр олон төслийг хэрэгжүүлж байна.

4.3. ГАДААДЫН МЭРГЭЖИЛТЭН, БАГШ ЗОЧИН ПРОФЕССОР

2019-2020 оны хичээлийн жилд гадаадын их дээд сургууль, сайн дурын болон олон улсын байгууллагаас 17 багш, мэргэжилтэн ШУТИС-д 6 сар, түүнээс урт хугацаагаар ирж ажиллав.


ШУТИС-ийн гадаадын мэргэжилтэн, багш нар

Хүснэгт 4.2


Харьяалагдах гадаадын байгууллага, төсөл	Ажиллаж буй сургууль	Тоо
БНСУ-ын WITH байгууллагын мэргэжилтэн	ҮТС	2
БНХАУ-ын Шандуны ШУТИС-ийн мэргэжилтэн багш	ГУУС	1
БНСУ-ын КОИСА байгууллагын мэргэжилтэн	ДаТС	3
Хамтарсан төслийн гэрээгээр ирсэн герман мэргэжилтэн	МХТС	1
АНУ-ын Төрийн департаментын мэргэжилтэн багш	ГХС	1
Япон-Монголын хамтарсан МJEED төслийн мэргэжилтэн	1000 инженер төсөл	7
ОХУ Буриадын улсын их сургуулийн мэргэжилтэн багш /Гэрээгээр /	ЭХС	1
Японы КООСЭН-ийг дэмжих нийгэмлэгийн мэргэжилтэн багш	КООСЭН Технологийн коллеж	1
Нийт		17

4.4. ОЮУТАН СОЛИЛЦОО, ГАДААДЫН ТЭТГЭЛЭГ

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-д нийт 60 гадаад оюутан суралцаж байна. Үүнээс бакалавр оюутан 4, магистрант 13, докторант 28, хэлний бэлтгэлд 14 оюутан, оюутан солилцооны хөтөлбөрөөр 1 оюутан тус тус суралцаж байна.



Зураг 4.2. Гадаад оюутан улс орноор




Зураг 4.3. Гадаад оюутны тоо (бүрэлдэхүүн сургуулиар)

ШУТИС-д суралцаж буй гадаад оюутнууд зардлын хэлбэрээр


- Засгийн газрын тэтгэлгээр 5 хүн
- Оюутан солилцоогоор 1 хүн
- Хувийн зардлаар 54 хүн

4.5. ГАДААДЫН ТЭТГЭЛГҮҮД

Японы Санко-Сеики групп, Японы Сүмитомо корпораци, Японы Мицүбиши корпораци, Тоёота-ШУТИС сан зэрэг гадаадын байгууллага, сангийн 37 сая 800 мянган төгрөг, 7000 ам.долларын тэтгэлгийг ШУТИС-ийн 49 оюутанд олгоод байна.



Зураг 4.4. Тэтгэлэгт хамрагдсан оюутнууд



Зураг 4.5. Тэтгэлэгт хамрагдсан оюутны тоо бүрэлдэхүүн сургуулиар

2019-2020 оны хичээлийн жилийн 2-р улиралд гадаад харилцаа хамтын ажиллагааны хүрээнд хийгдэхээр төлөвлөгдсөн зарим ажил, төсөл хөтөлбөрүүд, шинэ төрлийн Корона вирус “COVID19”-ийн дэгдэлт, тархалтын нөхцөл байдлын улмаас цуцлагдсан болно.



ТАВДУГААР БҮЛЭГ

ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

ТАВ. ОЮУТНЫ ХӨГЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.1. ХУВЬ ХҮНИЙ ХӨГЖИЛ, ТӨЛӨШИЛД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ШУТИС-ийн 2019-2020 оны хичээлийн жилд үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөө, Оюутны үйлчилгээний нэгдсэн хуанлид тусган зохион байгууллаа.

Сургалт, семинар, аян

Хүснэгт 5.1

д/д	Сургалтын нэр	Илтгэгч	Оролцсон оюутны тоо
1	Танд тусалъя аян	ОСҮА, клубүүд, шинэ элсэгчид	Шинээр элсэгч 1000 гаруй оюутанд зөвлөгөө өгөв.
2	Амжилттай суралцах нь	Бүрэлдэхүүн сургуулиудын эрдэмтэн багш нар	648 оюутанд 8 эрдэмтэн багш лекц оров.
3	Хотын соёл аяны хүрээнд (Гэмт хэрэг, хэв журмын зөрчил, Хар тамхи мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх лекц,)	Монголын түүхийн багш нар НЗЦГ, НЦГ, НПП-ын албан хаагчид болон мэргэжилтэн	1350 оюутан 12 багш, ЗЦГ-ын 16 албан хаагч, НЦГ-ын 3 албан хаагч, НПП-ын 7 албан хаагч
4	“Эрүүл зөв, зохистой хооллолт” болон “Харилцаа ёс зүйн сургалт”	Оюутнуудад ГХС, ҮТС-ийн багш, клубийн оюутнуудтай хамтран зохион байгуулав.	919 оюутан

Танд тусалъя аян /Чиглүүлэгч оюутан/

Энэхүү үйл ажиллагааны хувьд шинээр оюутан болж буй I дамжааны оюутнуудад клубүүд сайн дураараа тусламж үзүүлэх, заавар зөвлөгөө өгөх зорилготой. Шинээр оюутан болоход олон асуудал, эргэлзээ, өрөө байршил, төлбөр гээд л наад захын асууж лавламаар зүйлс цөөнгүй байдаг тэр бүгдэд тус дэм болж 8 клубийн 49 оюутан 2019.08.20-23-ны өдрүүдэд нийт 1000 гаруй оюутан мэдээлэл өгсөн.



Чиглүүлэгч оюутнаас дараах чиглэлийн мэдээллийг ихээр асууж байлаа.

- ✓ Оюутны хөгжлийн зээл
- ✓ Хичээлийн хасалт, нэмэлт
- ✓ Хичээл сонголт хийгээгүй болон хоцорсон оюутны торгууль
- ✓ Оюутны автобусны картын мэдээлэл
- ✓ Оюутны веб хэрхэн ашиглах
- ✓ Хичээл сонголт хэрхэн хийх
- ✓ Анги танхим, багш нарын өрөөний байршил
- ✓ Оюутны шилжилт хөдөлгөөн, жилийн чөлөө



- ✓ Шинэ оюутны элсэлт
- ✓ Эрүүл мэндийг үзлэгт хамрагдах
- ✓ Төлбөр төлөх зааварчилгаа гэх мэт асуултууд чиглүүлэгч оюутнуудаас асуусан ба чиглүүлэгч оюутнууд зааврын дагуу бүрэн мэдээллийг зааварлан өгсөн болно.

ШУТИС-ийн элсэгч оюутанд чиглэсэн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд бүрэлдэхүүн сургууль тус бүр Нэгдсэн уулзалт, “Амжилттай суралцах нь” лекцийг ОСУА-наас гаргасан хуваарийн дагуу зохион байгуулсан.


Хүснэгт 5.2

Д/д	Үйл ажиллагаа	Цаг хугацаа	Хаана болох	Лекц унших багш нарын нэр
1	ЭХС	IX/02-нд 16:00-17:30 цагт		Б.Бат-Эрдэнэ /ЭХС-ийн Цахилгаан техникийн салбарын эрхлэгч доктор (Ph.D), профессор/
2	ҮТС	IX/7-нд 16:00-17:30 цагт		Д.Түмэнболд /ҮТС-ийн Дизайны салбарын эрхлэгч доктор (Ph.D), дэд профессор/
3	ХШУС, ГХС, 1000 инженер	IX/04-нд 16:00-17:30 цагт		Ч.Оюунгэрэл /ГХС-ийн Ази судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)/
4	БАС	IX/05-нд 16:00-17:30 цагт		Ч.Оюунгэрэл /ГХС-ийн Ази судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)/
5	ГУУС	IX/09 нд 16:00-17:30 цагт		Б.Улаанбаатар /ГУУС-ийн Уурхайн технологийн салбарын ахлах багш/
6	БуХС	IX/02 нд 16:00-17:30 цагт	Хичээлийн V байр 205 тоот танхим	Я.Төгөлдөр /БуХС-ийн Хүмүүнлэгийн салбарын эрхлэгч доктор (Ph.D), дэд профессор/
7	МехТС	IX/03 нд 16:00-17:30 цагт	Хичээлийн VII байр хурлын танхим	С.Дэлгэрмаа /МехТС-ийн Техник механикийн тэнхимийн ахлах багш доктор (Ph.D)/
8	МХТС	IX/04 нд 16:00-17:30 цагт	Хичээлийн VIII байр лекцийн танхим	Т.Уранчимэг /МХТС-ийн Холбооны салбарын багш/

Сургуулиудын нэгдсэн уулзалтадууд

Хүснэгт 5.3

Д/д	Сургууль	Оюутны тоо
1	БАС	140
2	ЭХС	53
3	ҮТС	176
4	ХШУС	10
5	ГХС	37
6	БуХС	76
7	МехТС	89
8	МХТС	67
	Нийт	648



Зураг 5.1. МехТС-ийн нэгдсэн уулзалт



Зураг 5.2. БУХС-ийн нэгдсэн уулзалт



Зураг 5.3. МХТС-ийн нэгдсэн уулзалт



Зураг 5.3. БУХС-ийн нэгдсэн уулзалт

“Амжилттай суралцах нь” лекцэд хамрагдсан оюутны тоо сургуулиар
Хүснэгт 5.4

Д/Д	Бүрэлдэхүүн сургууль	Оюутны тоо
1	ҮТС	45
2	ХШУС	10
3	ГХС	30
4	БАС	130
5	БуХС	65
6	МехТС	73
7	МХТС	75
Нийт		428

“Хотын соёл” аян

Хотын соёл аяны зохион байгуулалтыг намрын улиралд Монголын түүхийн хичээлийн нэгдсэн хуваарийн дагуу зохион байгуулсан бол хаврын улиралд цахим сургалт хэлбэрээр зохион байгуулсан.

Намрын улиралд албан бичгийн НЦУГ-т хүргэснээр дараах хуваарийн дагуу сургалт явагдсан болно.

Хүснэгт 5.5


Д/Д	Багшийн нэр	Он сар өдөр	Гараг-цаг	Хичээлийн танхим	Оюутны тоо
1	Н.Галиймаа	2019 оны 9 сарын 16	Даваа -1 цаг 7:40-09:10	V байр-205 тоот	21
2	Ю.Болдбаатар	2019 оны 9 сарын 16	Даваа-2 цаг	II байр тв заал	145
3	Л.Эрдэнэболд	2019 оны 9 сарын 16	Даваа-5 цаг 14:40-16:10	V байр- 205 тоот	70
4	Д.Сэрдарам	2019 оны 9 сарын 19	Пүрэв-2цаг 9:20-10:50	I байр- 102 тоот	130
5	О.Болормаа	2019 оны 9 сарын 17	Мягмар-5 цаг 14:40-16:10	II байр- 205 тоот	80
6	М.Жавзансүрэн	2019 оны 9 сарын 16	Даваа -1 цаг 8:00-9:30	VI байр-402 тоот	96
7	Ч.Ванчигдаш	2019 оны 9 сарын 16	Даваа- 3 цаг 11:00-12:30	IV байр-111 тоот	145
8	С.Болормаа	2019 оны 9 сарын 16	Даваа-4 цаг 13:00-14:30	II байр Тв заал	192
		2019 оны 9 сарын 18	Лхагва- 3 цаг 11:00-12:30	I байр 306 тоот	
9	Ц.Бямба-Очир	2019 оны 9 сарын 16	Даваа-5 цаг 14:40-16:10	V байр-205 тоот	132
10	С.Бат-Эрдэнэ	2019 оны 9 сарын 19	Пүрэв-1цаг 7:40-9:10	II байр тв заал	215
11	А.Ариунболд	2019 оны 9 сарын 18	Лхагва -5 цаг 14:40-16:10	II байр ТВ заал	80
Нийт оюутны тоо					1306



Зураг 5.4. Хотын соёл аян

Тус аяны хүрээнд баруун гарын дүрэм хэрэгжүүлэх шторк тавьж нийтийн хэв журам сахиулах үйл ажиллагааг хэрэгжүүлэв. Их сургуулийн дотоод дэг журам сахиулах үүднээс “Соёл” клубийн багш оюутны хийж бүтээсэн “Баруун гарын дүрэм” шторкийг хичээлийн байруудын телевиз болон веб, фэйс группүүдээр сурталчлан таниулав. 2019.09.16-19-ний хооронд 4 клуб тус арга хэмжээнд хамтран ажилласан.

Хаврын улиралд "Хотын соёл" аяны сургалтаа "Covid-19" хорио цээрийн үед цахимаар зохион байгуулж НЦУГ-ын урьдчилан сэргийлэх хэлтэс, ШУТИС- Нээлттэй боловсролын төвтэй хамтран бэлтгэж, БУХС-ийн ХУС-ийн багш нарын “Монголын түүх”-ийн хичээл судалж буй оюутнууддаа хүргэсэн. Тус сургалтыг 12 багшийн лекцээр 1350 оюутанд хүргэсэн. Энэхүү ажлыг маань НЦУГ-аас үнэлэн ОСУА-ны ахлах мэргэжилтэн Д.Цогзолмааг Талархал, Цагдаагийн хүндэт одон тэмдгээр урамшуулсан болно.



Зураг 5.5. Харилцаа ёс зүйн сургалтыг намар хаврын улиралд зарлан хүргэсэн. Тус сургалтыг 760 гаруй оюутан сонирхон судалсан байна.

“Эрүүл зөв хооллолт” сургалт

Энэхүү үйл ажиллагааг ҮТС-ийн “Зөв, зохистой хооллолт” клубийн багш оюутнуудтай хамтран зохион байгуулж байна. Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн болно. Оюутны байранд амьдарч байгаа оюутнуудад хуваарийн дагуу сургалтыг 2019 оны 10 дугаар 22-29-нд зохион байгуулав. Сургалт явуулах явцдаа өглөөний цай ба зөв хооллолтын талаар судалгаа авсан.



Зураг 5.6. Сургалт, судалгаанд УТС, БУХС, МХТС, МехТС зэрэг 4 оюутны байрны 18-22 насны нийт 159 оюутан хамрагдав.



Зураг 5.7. УТС- 45 оюутан оролцов, БУХС- 30 оюутан оролцов, МХТС- 34 оюутан оролцов, МехТС- 36 оюутан оролцов.

Судалгааны дүнг танилцуулахад судалгаанд оюутны байранд амьдарч байгаа 145 оюутнаас судалгааг авсан. Судалгаанаас харахад оюутан зөв хооллолтыг хэрэгтэй гэж боддог боловч түүнийгээ хэрэгжүүлэх боломж бололцоогүй хичээлийн цаг болон өөрсдийн амьдралын хэв маягаас шалтгаалан өглөөний цайг бараг уудаггүй байна.

Мөн өдрийн хоолыг ихэвчлэн цайны газар, болон гадуур хооллох нь буруу бөгөөд байнга шарсан хуурсан хоол иддэг байна.

Оройн хоолыг ихэнх оюутнууд 20:00 цагаас хойш иддэг нь харагдаж байна. Хоол хүнсэндээ төдийлөн олон нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүн хэрэглэдэггүй, хоол хүнсний хэрэгцээнд дунджаар 40.000 зарцуулдаг байна.

Судалгааны үр дүн:

1-р курс- **40**

2-р курс- **60**

3-р курс- **28**

4-р курс- **17**

Хүйс 1.Эр- **83** 2. Эм- **62**

Бид оюутны хооллолтыг зөв зохистой болгох асуудлыг шийдвэрлэж “Эрүүл зохистой хооллолт” онлайн сургалт, хоол хийх арга ажиллагааны бичлэгийг бэлтгэн ШУТИС-ийн вебд тогтмол байрлуулан ажиллаж байна.

Нэгдүгээр курсийн зөвлөх багш нарт нэгдсэн семинар зохион байгуулав

2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр, 2020 оны 01 сарын 22-ны өдрүүдэд тус сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг ШУТИС-ийн сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, Академич, доктор (Sc.D), профессор Х.Энхжаргал нээж үг хэлсэн.

Тэрээр зөвлөх багш нар ялангуяа нэгдүгээр курсийн зөвлөх багш та бүхэн энэ их сургуулийн шинэ оюутнуудтай хамгийн түрүүнд нүүр тулж аав, ээжээс нь өөрцгүй ойр ажилладаг хүмүүс. Тиймээс шинэ оюуганд бүх зүйл нь шинэ соргог байгаа цаг үед нь ангийн багш, өөрийн хүүхдээс ялгаагүй хандаж сайн суралцахад нь туслах ажлыг олон талаас нь хэлж, ойлгуулах нь чухал шаардлагатай байгаа талаар хэлж, зөвлөх багш нар саналаа чөлөөтэй илэрхийлэхийг хүслээ. СБЗГ-аас дарга доктор(Ph.D), дэд профессор Т.Гэрэлт-Од, Бүртгэлийн нэгдсэн албаны дарга Д.Батдорж, ОСУА-ны ахлах мэргэжилтэн, доктор (Ph.D) Д.Цогзолмаа нар өөр өөрийн мэдээлэл хийх сэдвийн хүрээнд мэдээллүүдийг дэлгэрэнгүй хүргэлээ.



МХТС-ийн Электроникийн салбарын ахлах багш, доктор (Ph.D) Ц. Хүрэлбаатар, БСШУСЯ-ны харъяа “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн япон хэлний ахлах багш Ямамото Канако нар зөвлөх багшийн ажлын туршлагаасаа хуваалцсан.



Сургалт, семинарын төгсгөлд багш нараас санал хүсэлтийг сонсож тодорхой асуултад хариулт өгөв. Багш нараас тавьсан санал хүсэлтийг сургуулийн удирдлага, алба нэгжүүдэд хүргүүлж анхааран ажиллахаар боллоо.

Сургалтад БАС-10 багш, БуХС-6 багш, ГУУС-12 багш, МехТС-5 багш, МХТС-5 багш, ҮТС-8 багш, ХШУС-2 багш, ЭХС-11 багш, ГХС-1 багш, БАС, ГУУС, ГХС, ҮТС, ДаТС-ийн дэд захирлууд ирсэн байв.

5.1.1. ШУТИС-ийн оюутны клубүүдийн үйл ажиллагаа

ШУТИС-ийн оюутны мэргэжлийн болон сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг их сургуулийн хувьд бодлогоор дэмжин хөгжүүлэх нь үр дүнтэй байна.

Клубийн гишүүн оюутнууд хүсэл, сонирхлоороо нэгдэн баг хамт олон болж, хамтдаа хөгжиж, их сургуулийн оюутанд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд бодит хувь нэмэр оруулж байгаа нь клубүүдийн тайланд тусгагдсан үйл ажиллагаанаас харагдаж байна.

2019-2020 оны намрын улиралд клубүүдийн тайлан хэлэлцэх хуралд оролцсон 33 клубийн тайланг эмхэтгэн 2 дахь удаагаа хэвлүүлэн нийтийн хүртээл болгосон.

2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн түүхт 60 жилийн ойн арга хэмжээний томоохон нэг үйл ажиллагаа болох “Хөгжлөөр түүчээлсэн 60 жил” нэгдсэн арга хэмжээн дээр шилдэг клуб, шилдэг гишүүдээ тодруулан урамшуулснаас ШУТИС-ийн түүх 60 жилийн шилдэг клубээр ҮТДС-ийн график дизайн мэргэжлийн “WIZZ” клуб шалгарсан.

2019-2020 оны хичээлийн жилийн хувьд оны шилдэг мэргэжлийн клубээр МХТС-ийн Электроник мэргэжлийн “Sys&CoTech” клуб, Сайн дурын шилдэг клубээр “AIESEC” клуб, Шилдэг клубийн ахлагчаар “Inspiration” клубийн ахлагч Ж.Мөнхчимэг, “Багшийн туслах оюутан” клубийн ахлагч Б.Бат-Ирээдүй нар шалгарсан.

Оюутны шилдэг бүтээлч клубийг дэмжин урамшуулах саналыг ШУТИС-ийн Сургалт, оюутны асуудал эрхэлсэн дэд захирал, Академич, ШУ-ны доктор (Sc.D) Х.Энхжаргал оюутнуудаа дэвшүүлсэн нь тэдний хамтын үйл ажиллагаа, цаашдын их амжилтыг дэмжсэн томоохон дэмжлэг болсон. Энэхүү Академич Х.Энхжаргалын нэрэмжит анхны шагналаар ҮТС-ийн Үйлдвэр дизайн мэргэжлийн “FINDE” клуб шалгарч шагналыг гардан авсан.


2019-2020 оны Клубийн шилдэг зөвлөх багшаар Хятад хэлний клубийн зөвлөх багш Ц.Эрдэнэзаяа шалгарч ШУТИС-ийн захирлын гарын үсэгтэй батламж, үнэ бүхий зүйлээр шагнуулсан.

2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлаас эхлэн ШУТИС-ийн Клубүүдийн нэгдсэн зөвлөлийн даргаар шилдэг ахлагчаар шалгарсан “Багшийн туслах оюутан” клубийн ахлагч Б.Бат-Ирээдүй ажиллахаар тодроод байна.

Одоогийн байдлаар ШУТИС-д нийт 56 клуб бүртгэлтэй байгаагаас 30 орчим клуб үйл ажиллагаагаа эрчимтэй явуулж 1408 оюутныг хамруулан ажиллаж байна. Үүнээс мэргэжлийн клубүүд 777 гишүүн буюу 55.2 хувийг, сайн дурын клубүүд 567 гишүүн буюу 40.2 хувийг, харин урлагийн клубүүдийн хувьд 68 гишүүн буюу 4.6 хувийг эзэлж байна. Мөн графикаас ажиглахад II дамжааны оюутнууд клубт илүү идэвхтэй хамрагдаж байгаа бол төгсөх дамжааны оюутнуудын хувьд хамгийн бага оролцоотой байгаа нь харагдаж байна. Бүх клубийн хувьд гишүүд гэдэг амин сүнс нь байдаг бөгөөд ихэнх клубүүдийн хувьд шинээр орж ирж буй I дамжааны оюутнуудад чиглэсэн үйл ажиллагаа явууллаа.

Клуб тус бүр өөр өөрсдийн онцлогтой байдаг бөгөөд үүнээсээ хамаарч гишүүн элсүүлэх болон ажлын төлөвлөгөө нь хавар, намрын улиралдаа өөр өөр байдаг. Аливаа нэг клубийн ахлагчийн чадвараас тухайн клубийн үйл ажиллагаа ихээхэн хамааралтай төдийгүй хичээлийнхээ сургалтын хажуугаар гишүүдээ идэвхжүүлэх, өдөр тутам клубийн дотоод үйл ажиллагаагаа зохион байгуулах, төлөвлөгөө, төсөв, тайлан бичих, КНЗ-өөс болон ШУТИС-ээс зохион байгуулж буй үйл ажиллагаанд гишүүдээ оролцуулах, сайн үйлсийн аян гээд л чамгүй ачааг нуруун дээрээ үүрч явдаг.






Зураг 5.8. Клубийн үйл ажиллагаа

Ахлагч бүрийн энэхүү нөр их хичээл зүтгэлийн үндсэн дээр ШУТИС-ийн клубүүдийн нэгдсэн зөвлөл бүрэлдэн тогтож клубүүдийн нэгдсэн зөвлөлийн хувьд нэг хүн даргаар томилогдохоос илүүтэйгээр клубээрээ нэгдэж клубүүдийн нэгдсэн зөвлөлийн удирдах зөвлөлөөр ажиллах болсон энэхүү үйл ажиллагаа 2017 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Хятад хэлний клуб хоёр дахь удирдах зөвлөлөөр 2018-2019 оны хаврын улирлаас эхлүүлэн 2 улирал буюу 1 жилийн хугацаанд ажилласан. Энэ ажиллах хугацаанд дараах үйл ажиллагааг зохион байгуулсан.

Клубүүдийн нээлттэй өдөрлөг

Клубүүдийн нээлттэй өдөрлөгт оролцож шинээр гишүүн элсүүлж авсан клубүүдийн тоог сүүлийн 4 улирлаар харуулбал ихэнх клуб намрын улиралд илүүтэйгээр шинэ гишүүд элсүүлэн авах хандлага харагдаж байна. Энэ нь тухайн клубүүд улирал бүрд бус жилд нэг удаа гишүүнчлэлийн тоогоо нэмдэг болсон гэсэн үг юм. Ингэснээр бүтэн жилийн туршид гишүүдтэйгээ ажиллах төлөвлөгөө боловсруулж гишүүн бүртэй тулж ажиллах, бие биеэсээ суралцах, баг хамтын ажиллагааны чадвараа сайжруулах, илүү ойр дотно баг хамт олон болох гэх мэт маш олон давуу талтай юм.



Зураг 5.9. Шинээр элсэлт авсан клубүүдийн сүүлийн 4 улирлын харьцаа

Энэ улирлын Нээлттэй өдөрлөгийн хувьд 2019 оны 09 дугаар сарын 25-27-ны хооронд БУХС, ҮТС, МХТС, МИС, Хичээлийн I,II байруудад зохион байгуулж 19 клуб шинээр 264 гишүүн элсүүлэн авсан.



Зураг 5.10. Нээлттэй өдөрлөг

Тайлбар	Давхаа	Мягсар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба
2-р өдөр 09:25-10:30	Хөгжсөн Хөгжсөн клуб	Хөгжсөн Хөгжсөн клуб	Хөгжсөн Хөгжсөн клуб	Хөгжсөн Хөгжсөн клуб	Хөгжсөн Хөгжсөн клуб	Хөгжсөн Хөгжсөн клуб
3-р өдөр 11:00-12:30	БУХС Бичигч 1	Солонгос хэлний клуб	Герман хэлний клуб	Ангел хэл орчуулгын клуб	Ангел хэлний клуб	Ангел хэлний клуб
4-р өдөр 13:00-14:30	БУХС Ерөнхий талын клуб	БУХС Физикч 1	БУХС Математикч 1	БУХС Математикч 1	Нийслэл Илэн хэлний клуб	Нийслэл Илэн хэлний клуб
5-р өдөр 14:40-16:10	БУХС Дүрсэл хөгжлийн клуб	БУХС Ерөнхий талын клуб	Монголч хэлний клуб	"АБЭС-МЭНТ" клуб	Хөнд хэлний клуб	Залуучууд Улам хөгжлийн клуб
6-р өдөр 16:20-17:50	Хөнд хэлний клуб	Нийслэл Илэн хэлний клуб	Залуучууд Улам хөгжлийн клуб	Герман хэлний клуб	Солонгос хэлний клуб	Хөнд хэлний клуб
7-р өдөр 18:00-19:30	"Тэгшлэл өгөгдөл өгөгдөл" клуб (БУХС)	МЭНТ Санаач	Ангел хэл орчуулгын клуб	Бергелийн нийслэлний клуб	Солонгос хэлний клуб	Хөнд хэлний клуб
8-р өдөр 19:40-21:10						

1. 327 оны "Оюутны бэлтгэл" ангийн танилцаж хичээллэх клубүүдийн үйлдлийн хувиар. 2019 оны 09 сарын 25-27 өдөрний 09 сарын 01 өдөр

Зураг 5.11. Клубүүдийн хичээллэх хувиар

Клубүүдийн “Ахлагч нарыг чадваржуулах” сургалт

2019 оны 11 сарын 28-ны өдөр “Ахлагч нарыг чадваржуулах сургалт”-ыг зохион байгуулсан бөгөөд сургалтад нийт 21 клубийн ахлагч нар оролцсон. Клубийн ахлагч нарыг чадваржуулахад чиглэсэн сургалтыг “Хятад хэлний клуб”-ийн зөвлөх багш, Доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа “Биеэ засаад гэрээ зас Гэрээ засаад төрөө зас” үндсэн ойлголтын дагуу бидний оюутан насны эхлэлээс энэхүү 4 жилийн хугацаанд бид юуг хэзээ нь сурч авах ёстой байдаг хийгээд өөрт ногдох орон зайг эзэгнэж, хувь хүнээс бие хүний төлөвшил, үргэлжлээд төлөвшсөн хүн бусдыгаа манлайлах буюу нөлөөлөх үр чадварт суралцах гэх мэт багаас нь эхлээд их рүү нь чиглэсэн маш олон үнэтэй

мэдээллийг өгч клубийн ахлагч нарт зөвлөн тайлбарласан бол ШУТИС-ийн КНЗ-ийн өмнөх тэргүүн Goldman Project LLC-ийн төслийн инженер Б.Мөнх-Эрдэнэ "Их сургуулийн 4 жил гэдэг бүх л зүйлийн бэлтгэл" гэх ерөнхий ойлголтын дагуу Клуб гэдэг зүйл нь оюутанд ямар чухал чадвар, хүмүүжлийг олгодог болон клубт элсэхээс аваад ахлагчийн ажлыг эрхлэх хүртэл ямар давуу талуудыг өөртөө суулгаж болох, клубийн хүрээлээс суралцсан чадвар, түүний үр шим их сургуулиа төгссөний дараа ажлын байранд тавигдах шаардлагыг хангахад ямар их дэм болсон, одоо ажилд нь ямаршуу боломжуудыг олгодог гээд маш их үнэ цэнтэй зөвлөгөөнүүдийг өглөө.

Клубүүдийн нэгдсэн арга хэмжээ

2019.12.15-ны өдөр MYGO клубт мэргэжлийн болон сайн дурын нийт 20 клубийг хамарсан клубүүдийн нэгдсэн шинэ жил, шилдэг клуб, шилдэг ахлагч нарын шагнал гардуулах ёслолын үйл ажиллагааг амжилттай зохион байгуулсан. 2019-2020 оны хичээлийн жилд идэвх санаачилгатай байж, үйлс бүтээлээрээ бусдыгаа манлайлсан шилдэг клуб болон шилдэг ахлагч нарыг дурдвал:

Шилдэг мэргэжлийн клуб: **“Sys&CoTech” клуб**

Шилдэг мэргэжлийн клубийн ахлагч: **Ж.Мөнхчимэг /Inspiration клуб /**

Шилдэг сайн дурын клуб : **“AIESEC- ШУТИС” клуб**

Шилдэг сайн дурын клубийн ахлагч: **Б.Бат-Ирээдүй /БТОК-ийн ахлагч/**



Шилдэг зөвлөх багшаар Хятад хэл клубийн зөвлөх багш, ГХС-ийн ахлах багш, доктор (Ph.D) Ц.Эрдэнэзаяа нар тодорч ШУТИС-ийн 60 жилийн ойн клубүүдийн түүхийн хуудаснаа өөрсдийн амжилтаа мөнхөллөө.

Түүнчлэн энэхүү үйл ажиллагаанд КНЗ-ийн анхны тэргүүнүүд болох Э.Энхмандах, Б.Мөнх-Эрдэнэ нар хүрэлцэн ирж мэндчилгээ дэвшүүлсэн бол удаах тэргүүн У.Анударь арлын япон орноос бичлэгээр мэндчилгээ хүргэлээ. Мөн урлагийн клубүүдийг төлөөлж Дуулаач, Хос уянга, Анарваан клубүүд нийт клубүүддээ зориулж урлагийн тоглолтоор бэлэг барьж ШУТИС-ийн КНЗ амжилт бүтээлээр дүүрэн 2019 оноо үдэж 2020 оноо угтан авлаа.

5.2. ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, УРАМШУУЛАЛ, ХӨНГӨЛӨЛТ

Төр болон нийгмийн үйлчилгээ, Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээлд хамруулсан байдал:

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 46 дугаар тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам”, 2014 оны 71 дүгээр тогтоолоор баталсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн тэтгэлэг олгох журам”, Боловсролын зээлийн сангийн захирлын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А-23 тоот тушаалаар батлагдсан “Оюутны хөгжлийн зээл”-ийг даатгалд хамруулах хамтын үйл ажиллагааны удирдамж”-ийн дагуу Боловсролын зээлийн сантай тооцоо хийх ажлыг зохион байгуулав.

**Боловсролын зээлийн сангийн буцалтгүй тусламжид хамрагдсан байдал**

2019-2020 оны хичээлийн намрын улиралд өнгөрсөн хаврын улиралд 2.00 дээш ҮГД-тэй суралцсан 424 оюутны тооцоог хийж 417 сая 940 мянга 139 төгрөгийн санхүүжилтийн тооцоог Боловсролын зээлийн сантай хийх ажлыг зохион байгуулж ажиллав.

Буцалтгүй тусламжийн санхүүжилтийн тайлан
/2019 он 09-12 сар/ мянган төгрөгөөр


Хүснэгт 5.6

№	Сургууль	Хөдөлмөрийн чадвараа алдсан орх		Хөгжлийн бэрхшээлтэй		Бүтэн өнчин		Хөгжлийн бэрхшээлтэй эцэг, эх		Нэг өрхийн 3 болон түүнээс дээш		Нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	БАС	42	41427.24	5	4843.08	18	17646.96	2	2078.28	2	2053.2	69	68048.76
2	БУХС	53	54401.88	6	6434.408	18	18453.96	6	6048.6	4	4086.72	87	89425.568
3	ГХС	0	0	1	844.8	2	1710.72	0	0	0	0	3	2555.52
4	ГУУС	21	20638.08	5	4896.44	11	11027.76	2	1977.36	1	963.6	40	39503.24
5	ДАТС	10	6050.92	4	3501.96	11	9799.44	0	0	0	0	25	19352.32
6	МЕХТС	14	13943.64	2	1927.2	5	5095.08	6	5932.68	0	0	27	26898.6
7	МХТС	19	19839.24	4	4187.64	8	8322.48	1	1015.08	1	1089.6	33	34454.04
8	ОРТС	6	3892	1	770	4	3360	0	0	0	0	11	8022
9	ҮТС	22	21652.44	8	7758.96	10	9711.24	5	4843.08	2	2053.2	47	46018.92
10	ХШУС	2	1818.96	2	1838.64	2	1796.52	2	1796.52	0	0	8	7250.64
11	ЭХС	40	40586.88	2	1998.48	23	23353.08	2	2102.04	2	2102.04	69	70142.52
12	НБТ	0	0	1	1148.59	0	0	0	0	0	0	1	1148.59
13	БАТС	1	1247.038	3	3872.382	0	0	0	0	0	0	4	5119.421
		230	225,498.318	44	44,022.580	112	110,277.240	26	25,793.640	12	12,348.360	424	417,940.139


Оюутны хөгжлийн зээл

2019-2020 оны намрын улиралд БСШУСЯ-аас 800 оюутны хяналтын тоо батлагдаж, “Оюутны хөгжлийн зээл”-ийн дараах шаардлагыг хангасан бакалавр 2.80 болон түүнээс дээш, магистр болон доктор ҮГД 3.20 болон түүнээс дээш дүнтэй суралцаж буй 699 оюутны мэдээллийг Боловсролын зээлийн сангийн www.zeel.elf.mn сайтад цахим архивт оруулж 699 оюутны 1 тэрбум 66 сая 664 мянга 903 төгрөгийн зээл олгох ажлыг зохион байгуулав.

Мөн Боловсролын зээлийн сангийн Захирлын 2018 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А-23 тоот тушаалаар батлагдсан “Оюутны хөгжлийн зээл”-ийг даатгалд хамруулах хамтын үйл ажиллагааны удирдамжийн дагуу Хаан даатгал ХХК-д 699 оюутны 10 сая 666 мянга 649 төгрөгийн эрсдэлийн даатгалд хамруулав. Мөн төгсөх оюутны зээл эргэн төлөлтийн гэрээг байгуулах ажлыг БЗС-тай хамтран зохион байгуулав.



Зураг 5.12. Оюутны хөгжлийн зээлийн санхүүжилтэд хамрагдсан оюутны тоо (курсээр)



Зураг 5.13. Оюутны хөгжлийн зээлийн санхүүжилтэд хамрагдсан оюутны төлбөр (мянган. төгрөг)

Хоёр улсын Засгийн газрын гэрээгээр суралцагч оюутны төлбөрийн санхүүжилт

Засгийн газрын гэрээгээр суралцагч гадаад 3 оюутанд 2019-2020 оны намрын улиралд 3439 мянга 62 төгрөгийн сургалтын төлбөр, амьжиргааны зардал 2160 мянган төгрөгийн тооцоог Боловсролын зээлийн сантай хийж, нийт 5599 мянга 62 төгрөгийн тооцоог хийв.

Хоёр улсын Засгийн газрын гэрээгээр суралцагч оюутны сургалтын төлбөрийн санхүүжилт /мянган төгрөг/ 2019 оны 09-12 сар/
Хүснэгт 5.7

д/д	Сургууль	Казахстан		БНХАУ		Нийт	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	МХТС	1	1268.85			1	1268.85
2	ҮТС			1	1927.2	1	1927.2
3	БАТС			1	243.012	1	243.012
	Дүн	1	1268.85	2	2170.212	3	3439.062

Сан, тэтгэлэг хөтөлбөрт хамрагдсан байдал
Хүснэгт 5.8

д/д	Тэтгэлгийн нэр	Тэтгэлэг авсан оюутны тоо	Нийт тэтгэлгийн хэмжээ /төгрөг/
1	Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг	1	1200000
2	Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг	2	2000000
3	Ректорын нэрэмжит тэтгэлэг	12	31653000
4	Робокон 2019	18	35324850
5	Мицубиши Корпорац нэрэмжит тэтгэлэг	4	7920000
6	ЖИ СИ АР МОНГОЛИА ХХК-ийн нэрэмжит тэтгэлэг	4	10000000
7	ИЭК-МОНГОЛ ХХК-ийн нэрэмжит тэтгэлэг	3	5370420
8	АВВ групп	4	9700200
9	Blue sky aviation ХХК	1	2966040
10	MONGOLIAN AZRICH төрийн бус байгууллага	1	3295600
11	Southgobi Sands Өмнийн говийн элс	1	3460380
12	Tugi SesakuSyo Coltd	2	6719200
13	Дэлхийн зөн ОУБ	3	1842400
14	Кристина Нобел	1	1500000
15	Өмнөговь аймгийн Гурвантэс сумын ЗДТГ	2	7332710
16	Өмнөговь аймгийн ЗДТГ	2	5798030
17	Степ Голд ХХК	1	3295600
18	Тайваний Хүүхэд гэр бүлийг дэмжих сан	1	800000
19	Тоёото Моторс ХХК тэтгэлэг	3	7503150
20	УБ Төмөр замын дээд сургууль	5	6455592
21	Хятадын банкны нэрэмжит тэтгэлэг	2	3456000
22	Цэцэглэх ирээдүй холбоо	1	1525700
23	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	1	1284800
	нийт	75	160403672

Ректорын нэрэмжит тэтгэлэг

“Ректорын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ын дагуу оюутны амжилт, амьдралын боломж бололцоо буюу санхүүгийн дэмжлэг зайлшгүй авах шаардлагатай 2019-2020 оны хичээлийн жилд шинээр элсэгч 12 оюутанд 30 хүртэлх кредитийн хөнгөлөлт буюу 31 сая 653 мянган төгрөгийн хөнгөлөлтийг олгов.

**“ШУТИС-ийн Ректорын нэрэмжит тэтгэлэг”-т хамрагдсан
шинээр элсэгч оюутны нэрс**


Хүснэгт 5.9

Д/д	Овог нэр	Сургууль	Мэргэжил	Хөнгөлөлт /кредит/
1	Мягмарсүрэн Чинзориг	Барилга, Архитектурын сургууль	Архитектур	30
2	Онолбаатар Билэгсайхан	Геологи, уул уурхайн сургууль	Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт	30
3	Баатаржалбуу Ариунзаяа	Барилга, Архитектурын сургууль	Архитектур	30
4	Шинэбаатар Лхам-Осоржин	Гадаад хэлний сургууль	Техник, технологийн орчуулга /англи хэл/	30
5	Хишигпүрэв Энхжин	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	Дулааны инженер	30
6	Нямдорж Даваасамбуу	Механик, тээврийн сургууль	Үйлдвэрлэлийн механикжуулалт	30
7	Золзаяа Гантүшиг	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Системийн аюулгүй байдал (хамтарсан)	30
8	Өлзийсайхан Энхжин	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологи	30
9	Мягмардорж Оргилноров	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Инженерийн бэлтгэл /герман хэл/	30
10	Оч-Эрдэнэ Лхамжав	Эрчим хүчний сургууль	Цахилгаан системийн автоматжуулалт	30
11	Адилбиш Алтанжаргал	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Системийн аюулгүй байдал (хамтарсан)	30
12	Чулуун Онон	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	График дизайн	30

Эрүүл мэндийн даатгалд оюутнуудыг хамруулсан байдал

Монгол Улсын “Иргэний даатгалын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1-т заасны дагуу Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байгаа Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн бүрэлдэхүүн сургуульд суралцаж байгаа өдрийн ангийн суралцагчдын иргэний эрүүл мэндийн даатгалд хамруулах тухай гэрээг 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 30 тоот гэрээний дагуу 2019-2020 оны намрын улиралд Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт байрлаж буй бүрэлдэхүүн сургуулийн суралцагч 7546 оюутнаас 19 нас хүрээгүй 2799, 19 нас болон түүнээс дээш 4747 оюутны судалгааг Сүхбаатар дүүргийн

Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтэст гаргаж өгөв. Мөн Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын 2018.10.09-ний өдрийн А-1/857 тоот албан бичгийн дагуу Эрүүл мэндийн даатгалын /health.gov.mn/ сайтаас шалгаж даатгуулагч бүртгэлтэй тохиолдолд эрүүл мэндийн даатгалын дэвтэр шаардахгүй үйлчилгээ үзүүлэх болсон бөгөөд энэхүү сайтаар эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхийг оюутан бүрээр шалгаж 4890 оюутныг эрүүл мэндийн даатгалд хамруулав.



Зураг 5.14. 2019 оны Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан оюутны тоо Нийтийн тээвэр зорчих хөнгөлөлтөд хамруулсан байдал

Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/740 дүгээр захирамж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2015 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 6/21 тогтоолоор батлагдсан “Цахим карт олгох, цэнэглэх, ашиглахад баримтлах журам”, Нийслэлийн Боловсролын газрын даргын 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Их, дээд сургуулийн оюутанд нийтийн тээврийн цахим төлбөрийн карт олгох, сунгах ажлыг зохион байгуулах удирдамж”-ийн дагуу 2019-2020 оны намрын улиралд 4898 оюутан, захиалгаас хоцорсон 65 оюутан нийт 4963 оюутны автобусны хөнгөлөлттэй картаар зорчиж байна.

2019-2020 оны хичээлийн жилийн намрын улиралд автобусны карт захиалсан оюутны тоо


Хүснэгт 5.10

№	Сургууль	Шинээр карт захиалсан оюутны тоо	Карт сунгуулсан оюутны тоо	Карт дахин захиалсан оюутны тоо	Нийт
1	БАС	260	248	407	915
2	БүХС	143	100	241	484
3	ГУУС	115	107	231	453
4	МехТС	107	167	331	605
5	МХТС	188	145	400	733
6	ҮТС	156	128	365	649
7	ХШУС	48	34	49	131
8	ЭХС	266	180	399	845
9	ГХС	32	10	41	83
ДҮН		1315	1119	2464	4898

Оюутны цахим карт

ШУТИС-ийн Удирдах Зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 15, 16, 17 дугаар тогтоолын дагуу ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль, алба нэгжийн нэрийн өөрчлөлтийг картын бүртгэлийн програмд МХТС-ийн багш Г.Мөнхбат багшаар хийлгэж бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтан, оюутны цахим картын захиалгыг бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанаас авч нийт 844 цахим карт хэвлэв.

Цахим үнэмлэх хэвлэсэн тоо



Зураг. 5.15. 2019-2020 оны намрын улиралд цахим үнэмлэх авсан багш, ажилтан, оюутны тоо

Төгсөгч оюутны анкет


Төгсөгч оюутан залуусыг ажил олгогч аж ахуйн нэгжтэй холбож өгөх, зуучлах зорилгоор 2019-2020 оны намрын улиралд төгсөх 2019.12.15-ны байдлаар 293 оюутнаар төгсөгч оюутны анкетыг бөглүүлэх ажлыг зохион байгуулав.

5.3. НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭ

Хичээлийн жилийн нээлтийн ёслолын ажиллагаа



“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-т Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019-2020 оны шинэ хичээлийн жилийн нээлт 8 дугаар сарын 28-ны өдөр ШУТИС-ийн задгай талбайд боллоо. Нээлтийн ёслолын ажиллагаанд Монгол Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, БСШУС-ын Сайд Ё.Баатарбилэг, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дарга Д.Бадарч, ШУТИС-ийн захирал Б.Очирбат, холбогдох удирдлагууд, бүрэлдэхүүн сургуулийн захирлууд, “ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” олон улсын роботын тэмцээний Аваргаар тодорсон Хонконгийн баг тамирчид, тэмцээнд дэд байр эзэлсэн МХТС-ийн “Mongolia-I”, “Mongolia – II” багийн оюутан залуус оролцов. Нээлтийн үйл ажиллагааны эхэнд “Оюутан цэрэг” сургалтад амжилттай суралцсан “Онц



буудагч”, “Онц сурлагатан”, “Тамирчин дайчин” цол тэмдэгтэй оюутан цэргүүд Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн тугийг заллаа.

Нээлтийн ёслолын ажиллагааны үеэр ШУТИС-ийн Захирлын нэрэмжит тэтгэлэг, Япон улсын TUGI SEISAKUSHO компани, FUJI TOSOU

KOUGYO компанийн тэтгэлгийг оюутнуудад олгов. Барилга, архитектурын сургуульд “Архитектур” хөтөлбөрөөр элссэн М.Чинзориг элсэгчдийг төлөөлөн үг хэлж, шинээр элсэн орсон нийт оюутнууд “Оюутны тангараг”-аа өргөж, хичээлийн жилийн анхны хонх дуугаргаж ШУТИС-ийн шинэ хичээлийн жилийн нээлт ёслолын ажиллагааг зохион байгуулав.

“Манлайлал-Оролцоо-Хөгжлөөр түүчээлсэн 60 жил” 1000 оюутны чуулган уулзалт



ШУТИС-ийн тэргүүлэх 1000 оюутны “Манлайлал оролцоо хөгжлөөр түүчээлсэн 60 жил зөвлөгөөн 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр Соёлын төв өргөөнд боллоо.


Уг оюутны зөвлөгөөнд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүх, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг, ШУТИС-ийн Ректор Б.Очирбат болон бусад албаны хүмүүс оролцлоо. Уг зөвлөгөөнд МУ-ын ерөнхий сайд У.Хүрэлсүх болон

ШУТИС-ийн манлайлагч 1000 оюутнууд оролцон санал хүсэлтээ солилцлоо.

МУ-ын Ерөнхий сайд У.Хүрэлсүх зөвлөгөөнийг нээж хэлсэн үгэндээ “Улсын хөгжил инженерүүдээс шууд хамааралтай бөгөөд өөртөө итгэлтэй мэргэжлийн боловсон хүчинтэй байх нь улсын хөгжлийн үндэс. Монгол улс хүн ам цөөхөн ч хүн ам ихтэй хоёр хөрштэй тул, бараа бүтээгдэхүүнээ энэ том зах зээлд гаргаж өөрсдийн бүтээн байгуулалт, бүтээгдэхүүнүүдээ таниулах хэрэгтэй. Монгол брэнд, Монгол инженерүүд дэлхийд бүрэн хүлээн зөвшөөрөгдсөн, бидэнд асар их боломж байна гэв.

Ерөнхий сайд илтгэл тавих үеэрээ Монголд хийгдэж байгаа томоохон бүтээн байгуулалтууд болох Нефтийн үйлдвэр, төмөр зам зэргийг танилцуулж инженерүүд залхууралгүй суралцаж ирээдүйг бүтээх нь чухал хэмээж байлаа. Монголд Нефтийн үйлдвэр баригдаж байгаатай холбогдуулан энэ чиглэлийн оюутан залуусын боловсролд анхаарлаа хандуулж, үйлдвэрийн ажилчдын 90 болон түүнээс дээш хувь нь монгол залуус байлгахыг зорин ажиллаж байна” гэлээ.

Мөн зөвлөгөөний үеэр ШУТИС-ийн оюутнууд өөрсдийн бүтээл болон ирээдүйн зорилгоо Ерөнхий сайдад танилцууллаа.



ШУТИС-ийн Оюутны Холбооны хяналтын зөвлөлийн дарга С.Болд-Эрдэнэ “Оюутны өөрөө удирдлагын байгууллага ба оюутны оролцоо”, Барилга, архитектурын сургуулийн Иргэний ба үйлдвэрийн барилгын 4 курсийн оюутан Б.Билгүүнзаяа “ШУТИС-д суралцсанаар надад олдсон боломжууд” сэдвээр илтгэл тавилаа.

Мөн ШУТИС-ийн Нээлттэй боловсролын төвийн захирал доктор Д.Ганбат “ШУТИС-ийн Нээлттэй технологийн талаар Боловсрол 4.0”

боловсролын төвийн сургалтын шинэ танилцуулгыг оюутнуудад хийлээ.

Уг зөвлөгөөний үеэр ШУТИС-ийн үүсч байгуулагдсаны түүхт 60 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлэх баярын арга хэмжээнд зориулсан ШУТИС-ийн багш, оюутнуудын хүндэтгэлийг урлагийн тоглолтыг амжилттай бэлтгэн зохион байгуулсан эрхэм хүндэт багш нартаа ШУТИС-ийн Эрдмийн хамт олны нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал гардуулав.



Манлайлал-оролцоо-хөгжлөөр түүчээлсэн 60 жил зөвлөгөөний үеэр сурлага, хөдөлмөр, урлаг спорт, нийгэм олон нийтийн ажилд идэвх санаачилгатай оролцож амжилт гаргасан дараах нэр бүхий оюутнуудад “Тэргүүний оюутан өргөмжлөл” гардуулав.

ШУТИС-ийн Оюутны Холбооны “Шилдэг оюутан” тэмдэг, батламжийг гардуулж өгөв.

Уг үйл ажиллагаанд бүрэлдэхүүн сургуулийн захирал, дэд захирал, эрдэмтэн нарийн бичгийн дарга нар хүрэлцэн очиж “Бүрэлдэхүүн сургуулийн захирлын нэрэмжит шагнал”-аар 15 оюутныг шагнав.

Тэргүүний оюутан өргөмжлөл

Хүснэгт 5.11

Д/д	Сургууль	Оюутны овог, нэр	Мэргэжил
1	БУХС	Батцэцэгийн Сумъяа	Маркетингийн менежмент
2	ГУУС	Бямбадорж Жигжиддорж	Маркшейдер
3	ГУУС	Төмөрцоожийн Тулгабат	Гидрогеологи
4	МХТС	Батнасангийн Ганзориг	Автоматжуулалтын систем
5	ЭХС	Төмөрбатын Алтанбагана	Цахилгаан системийн автоматжуулалт

ШУТИС-ийн Оюутны Холбооны “Шилдэг оюутан” тэмдэг, батламжийг гардуулж өгөв

“Шилдэг оюутан” тэмдэг, батламж хүртсэн оюутнууд

Хүснэгт 5.12

Д/д	Сургууль	Оюутны овог, нэр	Мэргэжил
1	БАС	Батбаярын Билгүүнзаяа	Иргэний ба үйлдвэрийн барилга
2	БУХС	Баттулгын Өнөрзул	Нийгмийн ажил
3	БУХС	Отгонбаатарын Энххүслэн	Бизнесийн удирдлага
4	ГУУС	Батмөнхийн Базарваань	Уул уурхайн машин тоног төхөөрөмж
5	ҮТС	Батболдын Идэрмөнх	Үйлдвэрлэлийн дизайн
6	ЭХС	Сэргэлэнгийн Гончигсүрэн	Цахилгаан хангамж
7	БАС	Батбаатарын Солонго	Халаалт, агаар сэлгэлт
8	МХТС	Загарын Итгэлтбаяр	Нисэх техникийн механик
9	БАС	Ганболдын Лхагвацэнд	Ус хангамж, ус цэвэрлэгээ
10	ГУУС	Энхтөрийн Хилчинбаяр	Өрөмдлөгийн техник, технологи
11	ҮТС	Батбаатар Нарнаа	Хүнсний чанар, аюулгүй байдал

2019-2020 оны намрын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн намрын улирлын бакалаврын 83, магистрын 45 дахь удаагийн төгсөлт 2020 оны 1 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд болж байна. Энэ удаагийн төгсөлтөөр 6 доктор, 278 магистрын зэргийн диплом, 788 бакалаврын зэргийн дипломтой төгссөнөөс онцлох дипломтой 34, дипломын зэрэгтэй 61 оюутан төгсөн гарч байна. Түүнчлэн Эрчим, хүчний сургуулийн Хойд Хятадын Эрчим хүчний сургуультай хамтарсан Цахилгаан хангамж 2+2 хөтөлбөрөөр 6, БНХАУ-ын Шанхайн ШУТИС-тай хамтарсан Био инженерчлэл 2+2 хөтөлбөрөөр 2 төгсөгч тус тус төглөө.

Төгсөлтийн ёслолын ажиллагаанд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын газрын дарга Т.Амаржаргалан, ШУТИС-ийн Захирал



Б.Очирбат болон дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, эрдэмтэн багш нар төгсөгчид оролцлоо. Төгсөлтийн ёслолын ажиллагааг нээж ШУТИС-ийн Захирал Б.Очирбат үг хэлж, Монгол Улсын Гавьяат багш, ЭХС-ийн Дулааны инженерийн салбарын доктор, профессор Ч.Даваасамбуу, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Дээд боловсролын газрын дарга Т.Амаржаргалан нар төгсөгч оюутнуудад баяр хүргэн сургаал үгээ хайрлав.

Төгсөгчдөд диплом олгох ШУТИС-ийн Захирлын тушаалыг Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга, доктор, дэд профессор Д.Гэрэлт-Од уншиж танилцуулснаар ШУТИС-ийн төгсөгчдөд диплом гардуулах ёслолын үйл ажиллагаа эхэлсэн.

Нийт төгсөгчдийг төлөөлж Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн Автоматжуулалтын систем мэргэжлээр бакалаврын зэрэг хүртсэн Даваахүү овогтой Даваадэлгэр эрдэмтэн багш, төгсөгчид болон зочид төлөөлөгчдөдөө хандан талархлын үг хэллээ.

2019-2020 оны хаврын улирлын төгсөлтийн үйл ажиллагаа



Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улирлын бакалаврын 84, магистрын 46 дахь удаагийн төгсөлт 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдөр болж байна. Энэ удаагийн төгсөлтөөр 8 доктор, 367 магистрын зэргийн диплом, 1606 бакалаврын зэргийн дипломтой төгссөнөөс онцлох дипломтой 39, дипломын зэрэгтэй 67 оюутан төгсөв. Түүнчлэн Барилга, архитектурын сургуулийн Япон улсын их, дээд сургуулиудтай хамтарсан Иргэний ба үйлдвэрийн барилга 2+2 хөтөлбөрөөр 20, Архитектур 2+2 хөтөлбөрөөр 6, Механик тээврийн сургуулийн Япон улсын их, дээд сургуулиудтай хамтарсан Механик инженер 2+2 хөтөлбөрөөр 24 төгсөгч тус тус төгсөн гарлаа.

Төгсөлтийн ёслолын ажиллагаанд ШУТИС-ийн Захирал Б.Очирбат болон дэд захирал, бүрэлдэхүүн сургуулийн захирал, эрдэмтэн багш нар, төгсөгчид цахимаар оролцлоо. Төгсөлтийн ёслолын ажиллагааг нээж ШУТИС-ийн Захирал Б.Очирбат үг хэлж, төгсөгчдөд диплом олгох ШУТИС-ийн Захирлын тушаалыг Сургалтын бодлого, зохицуулалтын газрын дарга, доктор, дэд профессор Д.Гэрэлт-Од уншиж танилцуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй оюутны анхдугаар сургалт зөвлөгөөн

Хөгжлийн бэрхшээлтэй Иргэдийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллыг дэмжих Арга билэг холбооноос 2019 оны 11 дүгээр 01-ний өдөр зохион байгуулсан Хөгжлийн бэрхшээлтэй оюутны анхдугаар сургалт зөвлөгөөнд 23 багш, оюутнууд оролцож үг хэлэлцүүлэгт оров.

ШУТИС-ийн 60 жилийн ойн хүндэтгэлийн тоглолт

ШУТИС-ийн түүхт 60 жилийн ойн хүндэтгэлийн тоглолтод “ШУТИС-ийн Залуус” чуулга, бүрэлдэхүүн сургуулиудын багш, оюутнууд хамтран бүрэн хэмжээний урлагийн тоглолт зохион байгуулсан. Ардын хөгжим, ардын бүжиг, цэнгээнт бүжиг, чөлөөт бүжиг, гоцлол болон найрал дуучдаас бүрдсэн 270 гаруй авьяаслаг оюутан хамрагдаж, тоглолтын ерөнхий найруулагчаар Монгол улсын консерваторын багш СТА Б.Сүхээ, туслах найруулагчаар ШУТИС-ийн ОСУА-ны урлаг, соёл хариуцсан мэргэжилтэн Ц.Болдбаатар нар ажилласан. Ардын хөгжмийг МУГЖ М.Булган, ардын бүжгийг МУГЖ Ц.Алтангэрэл, чөлөөт бүжгийг СТА А.Хосбаяр, Цэнгээнт бүжгийг СТА Б.Мөнх-Очир, найрал дууг СУИС-ийн багш СТА Д.Оюунхишиг, концертмейстр СТА О.Лхагвасүрэн нар удирдан оролцсон. Мөн тоглолтын лед дэлгэцийн дүрсийг Инээлтэй төв, Fine-D клуб хамтран гүйцэтгэсэн бөгөөд дуулаачийн клубийн гишүүн БУХС-ийн оюутан Б.Өнөрзул, ГУУС-ийн оюутан Г.Тулгабат нар “ШУТИС-ийн шилдэг” оюутан, ардын бүжгийн клубийн ахлагч БУХС-ийн оюутан Б.Сумьяа “ШУТИС-ийн авьяаслаг” оюутнаар тус тус шалгарч өргөмжлөл дурсгалын зүйлээр шагнууллаа. Мөн амьд хөгжмийн иж бүрэн тоног төхөөрөмж, морин хуур хөгжмийн зэмсгүүдтэй болж бэлтгэл хийх боломжтой болоод байна.



“Манлайлал-Оролцоо-хөгжлөөр түүчээлсэн 60 жил”

ШУТИС-ийн түүхт 60 жилийн ойн хүрээнд сүүлийн 1 жил гаруй хугацаанд ШУТИС-ийн 20 гаруй мянган оюутан залуусын дунд сургалт, эрдэм шинжилгээ, урлаг, спортын олон уралдаан тэмцээнд амжилт гаргасан оюутан залуусыг шагнаан урамшуулах,



тэднийг алдаршуулах зорилготой “МАНЛАЙЛАЛ – ОРОЛЦОО - ХӨГЖЛӨӨР ТҮҮЧЭЭСЭН 60 ЖИЛ” арга хэмжээг 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд нийт 60 шилдэг оюутан, сурагчийг тодруулж, 260 оюутанд гарын бэлэг гардуулан, “Шилдэг анги”, “Шилдэг клуб”, “Шилдэг оюутны зөвлөл”-ийг тодруулан, шагнаж урамшуулсан юм.

“ШИЛДЭГ ЗОХИОН БҮТЭЭГЧ ОЮУТАН”-аар шалгарсан оюутнууд:

“ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” олон улсын роботын тэмцээнд 1-р байр эзэлсэн ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн ахлах багш, доктор Ц. Хүрэлбаатар удирдагчтай, М. Өсөхбаяр ахлагчтай “Mongolia-I” багийн гишүүд, “ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” олон улсын роботын тэмцээний тусгай байр /Toyota Award/ шагналт ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн ахлах багш, доктор Б. Дорж удирдагчтай, Х. Лодоншарав ахлагчтай “Mongolia –II” багийн гишүүд, Механик тээврийн сургууль, Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн оюутнууд.

**“ABU ROBOCON 2019 ULAANBAATAR” олон улсын
роботын тэмцээнд оролцсон баг**

Хүснэгт 5.13

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил
1	Мөнгөншагай	Өсөхбаяр	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
2	Бирваа	Цагаан	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Эмбэддэд Систем
3	Дансран	Баярсайхан	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
4	Энхтүвшин	Шаравдорж	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Эмбэддэд Систем
5	Дэндэв	Насандэлгэр	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
6	Эрдэнэ-Очир	Сосорбарам	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
7	Чинтогтох	Хандсүрэн	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
8	Төмөрзориг	Энэрэл	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
9	Гантулга	Мандухай	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
10	Хоролдорж	Лодоншарав	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
11	Ганбат	Мөнх-Эрдэнэ	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
12	Эрдэнэбаяр	Оргил	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
13	Баттогтох	Хас-Очир	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Электроник
14	Чинзориг	Сайханбилэг	Механик, тээврийн сургууль	Авионик

15	Отгонбаяр	Намуун	Механик, тээврийн сургууль	Авионик
16	Бямбасүрэн	Санжидсүрэн	Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	Үйлдвэрлэлийн Механикжуулалт
17	Мөнхбаатар	Идэрбат	Механик, тээврийн сургууль	Авионик
18	Батсуурь	Билгүүн	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
19	Баасандорж	Энхболд	Механик, тээврийн сургууль	Хөнгөн Үйлдвэрийн Автоматжуулалт

“Шилдэг судлаач оюутан”-аар шалгарсан оюутнууд
Хүснэгт 5.14

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил
1	Нямдаваа	Даваасүрэн	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
2	Батнасан	Ганзориг	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
3	Даваахүү	Даваадэлгэр	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Автоматжуулалтын Систем
4	Батбаатар	Энх-Амгалан	Барилга, Архитектурын сургууль	Архитектур
5	Батмөнх	Дэлгэрбаяр	Механик, тээврийн сургууль	Машин Үйлдвэрлэлийн Технологи

“МАНЛАЙЛАГЧ ОЮУТАН”-аар шалгарсан оюутнууд:
Хүснэгт 5.15

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил
1	Батдэлгэрэх	Ангирмаа	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Компьютерын График Дизайн
2	Ундрах	Очирболд	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Санхүүгийн Менежмент
3	Гэрэлчулуун	Ган-Эрдэнэ	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Мэдээллийн Системийн Аюулгүй Байдал
4	Эрдэнэбат	Отгонбаяр	Гадаад хэлний сургууль	Техник, Технологийн Орчуулга /Хятад Хэл/
5	Загар	Итгэлтбаяр	Механик, тээврийн сургууль	Авионик
6	Буяндэлгэр	Энхпүрэв	Барилга, Архитектурын сургууль	Иргэний Ба Үйлдвэрийн Барилга
7	Доржготов	Цэрэндорж	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	Химийн Технологи
8	Норжмаа	Баяраа	Геологи, уул уурхайн сургууль	Геодези
9	Даржаа	Лхагвадорж	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	Програм Хангамж
10	Батболд	Пагма	Эрчим хүчний сургууль	Цахилгаан Систем

11	Батсүрэн	Мядагхорол	Механик, тээврийн сургууль	Хөнгөн Үйлдвэрийн Автоматжуулалт
12	Сүмбэрэлдалай	Болд-Эрдэнэ	Геологи, уул уурхайн сургууль	Уул Уурхайн Машин Тоног Төхөөрөмж
13	Пүрэвдорж	Болдсайхан	Эрчим хүчний сургууль	Цахилгаан Систем

“Үлгэр жишээ оюутан цэрэг”-ээр шалгарсан оюутнууд:

Хүснэгт 5.16

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил
1	Ганбаяр	Эрдэнэ-Очир	Механик, тээврийн сургууль	Авионик
2	Батбаяр	Бүтэнбаяр	Барилга, Архитектурын сургууль	Халаалт, Агаар Сэлгэлт
3	Батжаргал	Бат-Ирээдүй	Барилга, Архитектурын сургууль	Барилгын Инженер

“Спортын салбарын шилдэг оюутан” -аар шалгарсан оюутнууд

Хүснэгт 5.17

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил
1	Мөнхбат	Цэлмэг	Эрчим хүчний сургууль	Сэргээгдэх Эрчим Хүч
2	Пүрэвсүрэн	Мөнх-Оргил	Геологи, уул уурхайн сургууль	Уул Уурхайн Ашиглалтын Технологи
3	Ганхуяг	Төрмандах	Эрчим хүчний сургууль	Дулааны Инженер
4	ЭРДЭНЭБАТ	БУМБАЯР	Эрчим хүчний сургууль	Үйлдвэр, Хотын Дулаан Хангамж
5	Гивапил	Юндэндорж	Геологи, уул уурхайн сургууль	Гидрогеологи, Инженер Геологи
6	Сүхбаатар	Будсүрэн	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Интерьер Дизайн
7	Мягмарбат	Сарантуяа	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	Бизнесийн Удирдлага
8	Пүрэвням	Билэгжаргал	Механик, тээврийн сургууль	Авто Инженер

“Урлаг, соёлын салбарын шилдэг оюутан”-аар шалгарсан оюутнууд

Хүснэгт 5.18

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил
1	Болдоо	Шагай	Барилга, Архитектурын сургууль	Архитектур
2	Жамбалсүрэн	Эрмүүнбилиг	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	Хүнсний Үйлдвэрлэлийн Машин Аппарат

3	Төрсайхан	Ганжаргал	Эрчим хүчний сургууль	Цахилгаан Систем
4	Батцэнгэл	Лувсанжамба	Барилга, Архитектурын сургууль	Архитектур
5	Баярбат	Янжинлхам	Гадаад хэлний сургууль	Техник, Технологийн Орчуулга /Хятад Хэл/
6	Пүрэвдорж	Маргад	Барилга, Архитектурын сургууль	Иргэний Ба Үйлдвэрийн Барилга
7	Цогтбаатар	Балжинням	Эрчим хүчний сургууль	Дулааны Цахилгаан Станц
8	Эрдэнэхишиг	Мэнд-Амар	Эрчим хүчний сургууль	Сэргээгдэх Эрчим Хүч
9	Зоригтбаатар	Бат-Эрдэнэ	Барилга, Архитектурын сургууль	Архитектур

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль, ШУТИС-Коосэн технологийн коллежоос шалгарсан “Шилдэг сурагч”-д.

“Шилдэг сурагч”

Хүснэгт 5.19

Д/д	Эцэг/эхийн нэр	Нэр	Сургууль	Мэргэжил, анги
1	Ганбаатар	Бат-эрдэнэ	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа ерөнхий боловсролын ахлах сургууль	12Б анги
2	Энхтүвшин	Төгөлдөр	ШУТИС-Коосэн Технологийн коллеж	Цахилгаан электроник
3	Цогоо	Буянбат	ШУТИС-ийн Дархан-Уул аймаг дахь Технологийн сургуулийн харьяа Ерөнхий боловсролын ахлах сургууль	10А анги

Тус арга хэмжээний үеэр мөн “Шилдэг анги”, “Шилдэг клуб”, “Шилдэг оюутны зөвлөл”-ийг тодруулан, шагнаж урамшуулсан юм.

“Шилдэг анги”-Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн “Электрон системийн автоматжуулалт”-ын 4-р дамжааны анги, хамт олон.

“Шилдэг клуб”- Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн “WHIZZ КЛУБ”-ийн хамт олон.

“Шилдэг Оюутны зөвлөл” – 2018, 2019 оны “Оюутны Урлагийн их наадам”-ын тэргүүн байр, 2018 оны “Оюутны спортын их наадам”-ын тэргүүн байр зэрэг олон амжилтыг үзүүлсэн Барилга, архитектурын сургуулийн оюутны зөвлөл шалгарчээ.



“Чиний боловсрол, Монголын ирээдүй”

Монголын оюутны холбоо, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яам хамтран зохион байгуулсан Монгол улсын ерөнхий сайд У.Хүрэлсүхийн оюутан залуучуудтай уулзах “Чиний боловсрол, Монголын ирээдүй” уулзалт Соёлын төв өргөөнд 2019 оны 10 дугаар сарын 31-нд болж өнгөрөв. Мөн Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамны сайд Ё.Баатарбилэг, Дээд боловсролын бодлогын газрын дарга Т.Амаржаргал болон Их дээд сургуулийн удирдлагууд оролцлоо. Тус арга хэмжээний үеэр Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан, Спортын яамнаас засгийн газар хоорондын 24 тэтгэлгийн талаарх мэдээлэл өгч, Боловсролын зээлийн сангийн талаарх мэдээллийг 500 орчим оюутан авч, үүнээс боловсролын зээлийн сангаас зээл авах хүсэлтэй 189 оюутнуудад зээл олгосон. Тус уулзалтад 50 орчим их дээд сургуулийн төлөөлөл болсон шилдэг 1200 оюутан оролцож үүнээс ШУТИС-ийн 100 гаруй оюутнууд оролцож Оюутны эрүүл мэндийн даатгалын асуудал, Их дээд сургуулиудыг “Кампус” хэлбэрээр хөгжүүлэх талаар мэдээлэл авч, Оюутны автобусанд хөнгөлөлттэй зорчих эрхийн 22 удаагийн тоог нэмэгдүүлэх, “Оюутан цэрэг” хөтөлбөрт хамрагддаг 1000 оюутны тоог нэмэгдүүлэх зэрэг асуудлуудыг дэвшүүлэв.

Элсэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019-2020 оны элсэгчдийн аварга шалгаруулах сагсан бөмбөгийн тэмцээн нь 2019 оны 10 сарын 25-28-ны өдрүүдэд ШУТИС-ийн II байрны зааланд амжилттай болж өндөрлөв. Тэмцээнд эрэгтэй 7, эмэгтэй 5 багийн тамирчид оролцсон бөгөөд аваргуудыг тодруулсан юм.

Тус тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд ХШУС-ийн БТСТ-ийн эрхлэгч О. Баатарзоригт, Оюутны холбооны тэргүүн Б. Мягмарренчин нар оролцлоо.



Байр эзэлсэн сургуулиуд:

Эрэгтэй баг тамирчдаас:

I байр: Эрчим Хүчний Сургууль

II байр: Геологи, Уул Уурхайн Сургууль

III байр: Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль

Эмэгтэй баг тамирчдаас:

I байр: Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль

II байр: Барилга, Архитектурын Сургууль



Зураг 5.16. Элсэгчдийн аваргын Цомын эзэд

Оюутны спортын V их наадам

Шинжлэх Ухаан, Технологийн Их Сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын хооронд жил болгон зохион байгуулагддаг Спортын V их наадам зургаан төрөлт тэмцээн нь 5 дахь жилдээ 2019 оны 11 сарын 04-18-ны хооронд амжилттай болж өндөрлөлөө. Тус тэмцээнийг БТСТ, ОСҮА, Оюутны холбоо хамтран зохион байгуулсан юм. Төрөл:

Сагсан бөмбөг- эрэгтэй, эмэгтэй
11.11-15 II байрны заал

1. Волейбол- эрэгтэй, эмэгтэй 11.04-11.08 II байрны заал
2. Үндэсний бөх 11.08-нд II байрны заал
3. Ширээний теннис- ганцаарчилсан, багаар 11.11-нд V байрны заал
4. Шатар- ганцаарчилсан, багаар 11.09-нд II-505 ангид
5. Илтгэл 11.11-нд I байрны хурлын танхимд

Шагналт байранд орсон сургуулиуд:

Сагсан бөмбөг

Эрэгтэй

I байр: Барилга, Архитектурын Сургууль

II байр: Механик Тээврийн Сургууль

III байр: Эрчим Хүчний Сургууль

Эмэгтэй

I байр: Эрчим Хүчний Сургууль

II байр: Дарханы Технологийн Сургууль

III байр: Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль

Волейбол

Эрэгтэй

I байр: Эрчим Хүчний Сургууль

II байр: Барилга, Архитектурын Сургууль



III байр: Геологи, Уул Уурхайн Сургууль

Эмэгтэй

I байр: Бизнесийн удирдлага, Хүмүүнлэгийн Сургууль

II байр: Эрчим Хүчний Сургууль

III байр: Барилга, Архитектурын Сургууль

Эмэгтэй шилдэг тоглогч: БАС-ийн Б.Марал

Эрэгтэй шилдэг тоглогч: ЭХС-ийн Г.Өнөрбаяр

Үндэсний бөх:

I байр: ГУУС Г. Мөнхтулга

II байр: ГУУС Л. Адъяа

III байр: БАС Э. Буянхишиг, ГУУС Э.Мянганбаяр

Ширээний теннис:

Ганцаарчилсан төрөлд:

I байр: БУХС Р.Мөнхнаран

II байр: ЭХС Б.Болортуул

III байр: БУХС Т.Энхжаргал

Багийн төрөлд:

I байр: Эрчим Хүчний Сургууль

II байр: Механик Тээврийн Сургууль

III байр: Барилга, Архитектурын Сургууль

Шатар

Ганцаарчилсан төрөлд:

I байр: МХТС У.Гэрэлт

II байр: БАС Б.Балжинням

III байр: ЭХС Б.Баяртулга

Багийн төрөлд:

I байр: Мэдээлэл Холбооны Технологийн Сургууль

II байр: Эрчим Хүчний Сургууль

III байр: Барилга, Архитектурын Сургууль

5.4. ОЛОН НИЙТ НИЙГЭМД ЧИГЛЭСЭН АЖИЛ

“Нийгмийн сүлжээнд зөв байцгаая” аян

Нийслэлийн ЦЕГ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албанаас зохион байгуулсан аянд Соёмбо клубийн оюутнуудтай хамтран оролцов. Аяны хүрээнд Сэтгэл судлаач Х.Наранбаатар, Ub comedy клубийн Х.Идэр-Од нарийн лекцийг сонсов.

“Ойлгоё хүндэлье” аян

Нийслэлийн ЦЕГ, Гэмт хэргээс арай урьдчилан сэргийлэх албанаас зохион байгуулсан аянд Соёмбо клубийн гишүүдийг оролцуулав.

5.5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ



Төгсөх курсийн оюутнуудад ажлын байранд тавигдах шаардлага түүнийг ханган биелүүлэхэд чиглэсэн “Ажлын байрны чиг баримжаа олгох” цуврал сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтыг намар танхимаар, хаврын улиралд цахим хэлбэрээр зохион байгуулав.

2019-2020 оны хичээлийн жилийн намрын улиралд:

Сургалтад нийт 105 оюутан хамрагдсан сургалт 8 удаагийн цувралаар танхимд явагдсан. ШУТИС-ийн Оюутны соёл, үйлчилгээний алба, БСШУСЯ-ны харьяа Боловсролын хүрээлэнгийн Дээд боловсрол болон мэргэжлийн боловсролын судалгааны сектор, БуХС-ийн багш нарын “Алтангадас” клуб, MSDI-Олон улсын хүний нөөцийн хөгжлийн академитай хамтран 2019-2020 оны намрын улиралд төгсөх курсийн оюутнуудад зориулан “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” 8 удаагийн цуврал сургалтыг 2019 оны 10 дугаар сарын 15-наас 12 дугаар сарын 10-ны хооронд зохион байгуулав.

Тус сургалтад хамрагдсан оюутнууд болон нийт төгсөгч оюутнууддаа зориулан ажил олгогч байгууллагуудыг урьж “MUST-NETWORKING BREAKFAST” арга хэмжээг 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдөр ШУТИС-ийн хичээлийн I байр “Хурлын танхим”-ын үүдний талбайд зохион байгуулж тус арга хэмжээн дээр цуврал сургалтад хамрагдсан оюутнууддаа сертификат гардуулав.



2019-2020 оны хичээлийн жилийн хаврын улиралд:

Хаврын улиралд төгсөх курсийн оюутнуудад “Ажил эрхлэлтэд чиглүүлэх” сургалтыг цахим хэлбэрээр хүргэж буй үйл явцыг зургаар илэрхийлэн харуулав. Тус сургалтыг явуулах цахим сүлжээний групп нээсэн ба группт нийт 778 оюутан бүртгэгдсэнээс 454 оюутан сургалтад хамрагдсан. Сургалтаас өгсөн даалгаврыг бүрэн гүйцэтгэж шаардлага хангасан нийт 109 оюутанд БАТЛАМЖ олголоо. Батламж олгосон оюутнуудад ажлын байрны онлайн ярилцлагад орох эрхийг бидэнтэй хамтран ажилласан MSDI-HR консалтинг компани хариуцан зохион байгуулах үйл ажиллагаа явагдаж байна.

Бид батламжаа оюутанд дипломын хамт хүргэхэд бэлэн болгож бүрэлдэхүүн сургуулиудад тарааж өгсөн.

Их сургуулийн оюутныг судалгаа шинжилгээний ажилд чиглүүлэх үйл ажиллагаа

ШУТИС-ийн оюутны судалгаа шинжилгээний ажлыг дэмжихэд чиглэсэн цуврал лекцүүдийг онлайнаар, 3 удаа цуврал сургалтыг онлайн хүргэсэн. Үүнд 1-р сургалтыг МХТС-ийн Электроникийн салбарын ахлах багш Ц. Тэнгис “Шилдэг бүтээлийн уралдаанд хэрхэн бэлтгэж, оролцох вэ?”, БуХС-ийн технологийн менежментийн зөвлөх профессор, доктор (Ph.D), профессор Л.Оюунцэцэг “Эдийн засгийн тооцоо, борлуулалт, чанарын асуудал” сэдвээр,

2-р цуврал сургалтыг ГУУС-ийн Геологи, гидрогеологийн салбарын профессор, доктор (Ph.D), 2016 оны шилдэг судлаач багш С.Жаргалан “Судалгааны ажлыг хэрхэн бичиж, илтгэх вэ?”, Уул уурхайн менежментийн профессор, доктор (Ph.D) Б.Оюунчимэг “Эдийн засгийн тооцоолол, судалгааны арга аргачлал” сэдвээр 3-р цуврал сургалтыг ГХИ-ийн Ази судлалын тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), “эрдмийн хv чуулган”-нд оюутнуудаа амжилттай удирдаж оролцсон “шилдэг багш”, Хятад хэлний клубийн зөвлөх багш Ц.Эрдэнэзаяа “Судалгааны ажлыг хэрхэн бичиж, илтгэх вэ?”, YTC-ийн дизайны салбарын дэд профессор, доктор (Ph.D), D-Art клубийн зөвлөх багш Б.Сэргэлэн Бүтээлийн уралдаанд оролцох боломж” сэдвээр тус тус хүргэсэн.


ШУТИС-ийн оюутны 2019 оны шилдэг бүтээлүүдийн бичлэгийг хийж нэгтгэн must.edu.mn сайтын оюутан линкэнд байршуулав.

“ОЮУТАН ЦЭРЭГ” мэргэжил олгох сургалт

“Оюутан цэрэг” мэргэжил олгох сургалтын 2019-2020 оны хичээлийн жилийн бүртгэлийг цахим хэлбэрээр явуулав. Курс, голч дүнгээр нь жагсаан 120 оюутны нэрсийг Сүхбаатар дүүргийн цэргийн штабт хүргүүлэв.

Хурлын танхимын үйл ажиллагаа


Хурлын танхимд хурал зөвлөгөөн, лекц семинар, урлагийн тоглолт, сургалт гэх мэт 375 удаагийн 1402 цагийн арга хэмжээ зохион байгуулагдсан.




Зураг 5.17. Арга хэмжээний харьцуулсан график

5.6. ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР

Амбулаторийн үзлэгийн мэдээ



Зураг 5.18. 2019 -2020 хичээлийн жилийн амбулаторийн үзлэгийн мэдээний тайлан /ЭМТ, БүХС, МТС, МХТС/




Зураг 5.19. Амбулаторийн үзлэг

5.6.1 Шинээр элсэгчдийн үзлэгийн мэдээ


Шинээр элсэгчдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 1857 оюутныг 7 өртөгөөр үзэж, зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 5.20. Шинээр элсэгчдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байдал



Зураг 5.21. Үзлэгийн төрлөөр хамгийн их оношлогдсон байдал



Зураг 5.22. Үзлэгийн төрөл хяналтын хэлбэрээр

Хүчилтөрөгчийн коктейлоор үйлчлүүлсэн үйлчлүүлэгчдийн тоо

Хүснэгт 5.20

Д/д	Сар өдөр	11 сар														НИЙТ 11 сар			
		7	8	9	10	13	14	15	16	17	21	22	23	24	27		28	29	30
1	Хүний тоо	21	52	11	18	20	21	8	19	13	9	12	16	7	16	14	13	11	281
2	Аяганы тоо	31	60	21	25	32	43	9	33	18	16	22	24	11	19	19	19	16	418
Д/д	Сар өдөр	12 сар														НИЙТ 12 сар			
		1	4	5	6	7	8	11	12	13	14	15	18	19	20		21	22	25
1	Хүний тоо	42	8	9	8	10	6	8	9	7	11	6	6	4	5	6	6	3	154
2	Аяганы тоо	59	13	18	13	16	13	17	16	11	20	11	10	8	9	12	14	3	263
Д/д	Сар өдөр	01 сар														НИЙТ 12 сар			
		2	3	4	5	8	9	10	11	12	15	16	17	18	19		23	22	
1	Хүний тоо	7	8	7	8	4	2	4	5	4	14	17	7	13	13	5	6		124
2	Аяганы тоо	12	13	11	21	6	4	7	10	8	20	30	13	25	18	13	14		225

Эмнэлгийн тусламж үйлчилгээ

Хүснэгт 5.21

д/д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамрагдсан хүний тоо	Үр дүн
1	Шүдний кабинетаар үйлчлүүлсэн үйлчлүүлэгчид	08 дугаар сарын 12-ноос 2020 оны 01 дүгээр сарын 30	ЭМСТ Шүдний кабинет	ЭМСТ	1670	Нийт 1244 хүнд тусламж үзүүлснээс 617 буюу 49,5% нь эрэгтэй, 627 буюу 50,5% нь эмэгтэй. Үүнээс 967 буюу 77,7% нь оюутан, 275 буюу 22,3% нь багш, ажилчдад үйлчилсэн байна. Мөн 434 буюу 35% нь шүдний үзлэг, оношилгоо, эмчилгээ, 319 буюу 25% нь дотрын эмчийн үзлэг, оношилгоо, 197 буюу 16% нь артерийн даралт хэмжилт, хяналт, 37 буюу 3% тариа, 7 буюу 1% боолт тус тус тусламж үзүүлж ажилласан. Эмнэлгийн тусламж авсан нийт үйлчлүүлэгчийн 1019 буюу 82% анх удаа, 225 буюу 18% нь давтан үзлэгт хамрагдсан байна.
2	Шинээр элсэгч оюутнуудын Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Шүд, Лор өртөө	08 дугаар сарын 19-нөөс 09 дүгээр сарын 13-н хүртэл	II-р байр Спорт заал ЭМСТ Шүдний кабинет	ЭМСТ	1857	Шүд, лорын өртөөнд нийт 1857 оюутан хамрагдсанаас дараагийн шатлалд 543, эмчилгээнд 868, хяналтад 710 оюутан, 185 оюутныг Шүдний X-Ray авхуулахаар илгээв. Буйлны үрэвсэлтэй 407 оюутан, цооролтой шүд 430, ломботой шүд 596, авхуулсан шүд 358 тус тус байв. Шинээр элсэгч оюутнуудын цоорлын эрчим 4,6 буюу дунд эрсдэлтэй шүд амны хөндийн эрүүл ахуйн мэдлэг дутмаг, эрүүл мэндийн боловсрол хангалтгүй.
3	Хичээлийн шинэ жилийн нээлтийн арга хэмжээ	08 дугаар сарын 25-нд	Төв задгай талбай	ШУТИС захиргаа	16	Артерийн даралт 16 хүнд, үүнээс 7 эрэгтэй, 9 эмэгтэй байв. Мөн 11 багш, ажилтан даралт хянах зорилгоор үзүүлэв.
4	КООСЕН сурагчдын Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Шүд, Лор өртөө	08 дугаар сарын 30, 09 дүгээр сарын 02	ЭМСТ Шүдний кабинет	ЭМСТ, КООСЕН	51	Шүд, лорын өртөөнд нийт 51 сурагч хамрагдсанаас 10 эмэгтэй, 41 эрэгтэй сурагч байв. Мөн 13 сурагч буюу 25,5% нь эрүүл, 38 сурагч буюу 74,5% нь өвчлөлтэй. Үүнээс буйлны үрэвсэлтэй 36 сурагч, цооролтой 91 шүд, ломботой 39 шүд, авхуулсан 4 шүд буюу цоорлын эрчим 3,5 буюу дунд эрсдэлтэй байна. Сурагчдын шүд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй.
5	ШУТАС сурагчдын Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт Шүд, Лор өртөө	09 дүгээр сарын 02	ЭМСТ Шүдний кабинет	ЭМСТ, ШУТАС	51	Шүд, лорын өртөөнд нийт 51 сурагч хамрагдсанаас 9 эмэгтэй, 42 эрэгтэй сурагч байв. Мөн 12 сурагч буюу 23,5% нь эрүүл, 39 сурагч буюу 76,5% нь өвчлөлтэй. Үүнээс буйлны үрэвсэлтэй 39 сурагч, цооролтой 120 шүд, ломботой 20 шүд, авхуулсан 2 шүд буюу цоорлын эрчим 3,6 буюу дунд эрсдэлтэй байна. Сурагчдын шүд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол хангалтгүй.
6	“MUST CUP-2019” ШУТИС-	09 дүгээр сарын 7,8-нд	Дэрэнгийн хөл	ШУТИС Захиргаа,	БУХС, ГУУС,	Нийт 8 баг тэмцээнд оролцсоноос 18 хүнд анхны тусламж үзүүлэв.

	ийн багш, ажилчдын хөл бөмбөгийн тэмцээнд эмчээр ажиллаж анхны тусламж үзүүлсэн		бөмбөгийн талбайд	ХШУС БТСТ	МехТС, МХТС, ХШУС, ЭХС, Захиргаа, ОрТС 8 баг	
7	2019-2020 оны хичээлийн жилийн намрын I-р ээлжийн эмэгтэй спорт явган аяллын хичээл	09 дүгээр сарын 14-нд	Буянт ухаа спорт ордоноос Жаргалантын ам	ХШУС БТСТ	248	Үүнээс 4 эмэгтэй оюутанд анхны тусламж үзүүлэв
8	“Элэг бүтэн монгол” Үндэсний хөтөлбөрийн дагуу	09 дугаар сарын 16-наас 18-ны өдрүүдэд	ЭМТ физик эмчилгээний өрөө	БГД-ийн Угтахуй өрхийн эрүүл мэндийн төв	369	369 хүн В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, тодорхой хувь нь дархлаажуулалтад орлоо
9	2019-2020 оны хичээлийн жилийн намрын II ээлжийн эрэгтэй спорт явган аяллын хичээл	09 дүгээр сарын 21-нд	Буянт ухаа спорт ордоноос Жаргалантын ам	ХШУС БТСТ	650	Үүнээс 10 эрэгтэй оюутанд анхны тусламж үзүүлэв.
10	Дотуур байрны эрүүл ахуйн хяналт, зөвлөгөө, зөвлөмж	09 дүгээр сарын 22-нд	Оюутны дотуур 1-р байр	ЭМСТ БОЗ	1, 2, 3, 4 тус тус давхрын бүх өрөө болон эр, эм ОО, Гал тогоо, шүршүүрийн өрөө	Давхар тус бүрд 4-5 өрөөний ариун цэвэр, хангалттай, 2-3 өрөөнд тамхи татдаг болохыг илрүүлж байрны багшид мэдэгдсэн. Мөн хогоо хаяагүй, өрөөний агааржуулалт муу, угаалтуураас ус гоожиж байсан зэргийг илрүүллээ.
11	Дотуур байрны оюутнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ	09 дүгээр сарын 15, 22, 23-нд	Оюутны дотуур 1-р байр	ЭМСТ БОЗ	303	Нийт 303 оюутан хамрагдсанаас 142 эрэгтэй, 161 эмэгтэй оюутан байв. Үүнээс эрүүл 10 оюутан, Хеликобактерийн шинжилгээнд 10 оюутан, мазокийн шинжилгээ өгөх оюутан, Сарын тэмдэг ирсэн 10 оюутан, тамхи татдаг 39 оюутан, буйлны үрэвсэлтэй оюутан, хоолойн үрэвсэлтэй оюутан, цоорсон шүд, ломботой шүд, авхуулсан шүд, гадна эм бэлэг эрхтний үрэвсэлтэй оюутан, эрэгтэй, эмэгтэй бэлэг эрхтний ариун цэвэр муу оюутан тус тус байлаа.
12	Дотуур байрны оюутнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ	09 дүгээр сарын 09-17 хүртэл	Оюутны дотуур 5-р байр	МТС-ийн эмч Отгонхи шиг	160	160 оюутан үзлэг, шинжилгээнд хамрагдаж, хяналтад орлоо.

13	Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд элэгний В, С вирус илрүүлэх шинжилгээ	09 дугаар сарын 26-нд	МТС	МТС-ийн эмч Д.Отгонх ишиг БГД-ийн Угтахуй ӨЭМТ-тэй хамтран	163 хүн	163 хүн В, С вирус илрүүлэх шинжилгээнд хамрагдаж, тодорхой хувь нь дархлаажуулалтад орлоо
14	Дотуур байрны оюутнуудын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ	09 дүгээр сарын 11-11 дүгээр сарын 01 хүртэл	Оюутны дотуур 3-р байр	БуХС-ийн эмч Б.Энхтуя, ЭМТ сувилагч Ч.Доржпалам	356	Зүрх судасны эмгэг өвчтэй 21, Чих хамар хоолойн өвчтэй 32, Үе холбоосны өвчин 18, Хоол боловсруулах замын эмгэг 42, Арьс харшлын өвчтэй 35, Бөөр шээсний замын өвчтэй 6, Амьсгалын замын өвчтэй 15, Цус багадалт 11, Мэдрэлийн тогтолцооны өвчтэй 17,
15	ШУТАС, КООСЕН эрүүл мэндийн үзлэгийн карт шивж, тайлан гаргах	09 дүгээр сарын 26, 27, 29	ЭМСТ шүдний кабинет		102	ШУТАС, КООСЕН оюутнуудын картыг шивж, 7 төрлийн мэргэжлийн үзлэгийн дагуу дүн шинжилгээ өгч ажилласан.
16	Сүрьеэ өвчин, Тамхины хор хөнөөл, БЗДХалдварт өвчний талаар сургалт хийж, шинжилгээ авсан.	10 дугаар сарын 9-10нд	МТС	МТС-ийн эмч Д.Отгонх ишиг ХУД-ийн ЭМТ-ийн Сүрьеэ, Сэтгэц, Өсвөр үеийн эмч нартай хамтран	240	МСҮТ-ийн 1-р ангийн нийт 240 сурагчдад сургалт хийж, шинжилгээ авч, зөвлөгөө өгч ажилласан /Дох, Тэмбүү, В, С вирус илрүүлэх /
17	Эрүүл шүд-Эрүүл хүүхэд хөтөлбөрийн хүрээнд холимог зуулттай сурагчдын шүд амны хөндийн үрэвслийн талаар мэдээ, мэдээлэл өгөв.	10 дугаар сарын 11-нд	45 сургуулийн 3Д анги	Шүдний кабинет	44	Нийт оношлогдсон 44 сурагчийн 53% нь эрэгтэй 47% нь эмэгтэй хүүхэд байв. Нийт оношлогдсон сурагчийн 11,4% буюу 5 сурагч эрүүл, 88,6% буюу 39 сурагч шүд цоорох өвчлөлтэй байв. Үүнээс шүд угаалт 88,6%, араа бүлгийн шүд үүдэн бүлгийн шүднээс илүү цооролтой 88,6%, холимог зуулттай 98% байв. Цоорлын эрчим 5,5 буюу дунд зэргийн эрсдэлтэй байлаа.
18	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн сургалт	10 дугаар сарын 13-нд	Оюутны 3-р байр	ЭМ-ийн 10-р төвөөс их эмч А. Цэнгэлмаа	108 оюутан	ОМД-байрны оюутнуудад үзлэг оношилгоо зөвлөгөө өглөө.
19	Тулгуур эдийн үрэвсэл, шүд амны хөндийн арчилгааны талаар сургалт	10 дугаар сарын 16	1 байр 301 тоот лекцийн танхим	ГУУС IV	35	Төгсөгч оюутнуудын шүд амны хөндийн эрүүл мэндийн талаарх сургалт явууллаа.
20	Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд БуХС-ийн багш	10 дугаар сарын 20, 21-ний өдрүүдэд	БуХС-ийн багш, ажилтан, оюутан		216	В вирустэй 15, С вирустэй-8 хүн илэрсэн. Элэгний В вирусгүй 170 багш, ажилтан, оюутнуудыг 2019-10-11, 2019-11-11-ний өдрүүдэд

	ажилтан, оюутан элэгний В,С вирус тодорхойлох шинжилгээнд					ХӨСҮТ-тэй хамтран В вирусийн дархлаажуулалтын 2 тунг хийлээ.
21	Оюутны спортын VI их наадамд 3 төрөлд эмчээр ажилласан	11 дүгээр сарын 4-нөөс 18 хүртэл	Хичээлийн 2-р байр спорт заал			Гар бөмбөгийн тэмцээнд 12 тамирчинд, Сагсан бөмбөгийн тэмцээнд 31 тамирчин, Бөхийн тэмцээнд 5 тамирчинд анхны тусламж үзүүлээ.
22	ШУТИС-ийн багш ажилчдын спортын 6 төрөлт тэмцээнд эмч шүүгчээр ажиллаж	2020 оны 01 дүгээр сарын 10-наас 18-ны өдрүүдэд	Хичээлийн 2-байр спорт заал	ЗАА		нийт 46 багш, ажилчдад анхны тусламж үзүүллээ

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ /Эрүүл мэндийн өдөрлөг/
Хүснэгт 5.22

Д/Д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамраг дсан хүний тоо	Үр дүн
1	“Цусаа бэлэглэж амьдрал хайрлая”	9 дүгээр сарын 20-нд	Оюутны дотуур 1-р байр	ЭМСТ, ЦССҮТ	50	Нийт 50 оюутан цусаа бэлэглэж 150 хүнд амьдрал хайрлалаа. Тус өдөрлөгийн үеэр сургалт, сурталчилгаа явуулж, мөн ханиад томуу, гүйлсэн булчирхайн үрэвсэл, харшилтай нийт 4 оюутанд үзлэг хийж, зөвлөгөө өгч ажилласан
2	Цусны донорын өдөрлөг	09 дүгээр сарын 16-нд	МТС	МТС-ийн эмч Отгонхишиг УЗН, ХУДийн УЗН ийн ажилтан О.Ариунболд	61	61 хүн цусаа бэлэглэлээ
3	Эрүүл мэндийн өдөрлөг зохион байгуулсан	10 дугаар сарын 23-нд	МТС	МТС-ийн эмч Д.Отгонхишиг Вевер компанийн эмч төлөөлөгч, Ази Фарм ХХК тай хамтран		Багш, ажилчид оюутнуудын ясны сийрэгжилтийг тодорхойлж, хямдралтай үнээр эм худалдав.
4	“Цусаа бэлэглэж амьдрал хайрлая”	10 дүгээр сарын 24, 25-нд	Хичээлийн 1-р байрны 3 давхар Хурлын заалны задгай талбай	ЭМСТ, ЦССҮТ	200	Нийт 200 оюутан цусаа бэлэглэж 600 хүнд амьдрал хайрлалаа.
5	Цахиур төмөр ХХК-тай хамтран витаминжуулалтын аян	11 дүгээр сарын 11-нд	1 байр Хурлын танхим	ЭМСТ, Цахиур төмөр ХХК		Тус өдөрлөгийн үеэр нийт багш, ажилчдад Таниа аппаратаар ясны сийрэгжилт, холестерин, усны хэмжээ, дотор өөхлөлт, биологийн нас зэргийг тодорхойлж, зөвлөгөө өгч ажилласан. Мөн Цахиур төмөр ХХК-ийн бүтээгдэхүүнийг 30%-ийн хөнгөлөлттэй үнээр борлуулсан.
6	“Чихрийн шижин” өдөрлөг	11 дүгээр сарын 13-нд	1 байр Хурлын танхим	Ази фарм ХХК, ЭМСТ, ЗУЗК		Тухайн өдөрлөгт давхардсан тоогоор 100 хүн хүчилтөрөгчийн коктейлиор үйлчлүүлж, 60 хүн чихрийн

					шижингийн эрдэлийг үнэлэх багц үзлэг, шинжилгээ, 56 хүн биоэнергийн аппаратаар бүтэн биеийн оношилгоонд тус тус хамрагдсан.
7	“Цусаа хандивлаж хүний амь аварцгаая” өдөрлөг	11 дүгээр сарын 22-нд	БуХС байр	Цус сэлбэлтийн үндэсний төв БуХС-ийн хүний нөөцийн 4 курсийн оюутнууд	87 Нийт 261 хүний амь нас оюутан аварсан
8	ДОХ/ХДХВ-той тэмцэх дэлхийн өдрийг угтсан үйл ажиллагаа	11 дүгээр сарын 29-нд	1 байр Хурлын танхим	ОСҮА, ОХ, ОЗ, ЗУЗК	Сурталчилгааны материал 150 ш, хамгаалах хэрэгсэл 10 хайрцаг тараасан. Мөн 11 дүгээр сарын 22-ноос 28-ны хооронд оюутан залуусын дунд бүтээлийн уралдаан зарлаж, өдөрлөгийн үеэр 2 бүтээлийг шалгарууллаа. ХДХВ/ДОХ, тэмбүүгийн түргэвчилсэн тестээр 50 оюутан үнэ төлбөргүйгээр оношлуулж, зөвлөгөө авсан. Хүчилтөрөгчийн коктейлиор 49 хүнд үйлчилж ажилласан. АХА тэмцээнд 50 гаруй оюутан оролцож эхний 6 байр шалгаруулж бэлэг, дурсгалын зүйл гардуулав. Хичээлийн анги, танхим, задгай талбай, номын сангаар ЗУЗК, ЭМТ хамтран богино хэмжээний мэдээллийг 200 гаруй оюутанд хүргэж, 6 оюутанд гарын бэлэг гардуулсан.
9	Цус бэлэглэх өдөрлөгт	12 дугаар сарын 03-нд	Цус сэлбэлт судлалын үндэсний төв	ОХ, ЗУЗК, ЭМТ	Өдөрлөгт Донорын холбооны өвлийн өвгөний бэлгээр шагнаж, ЗУЗК-ын ОЗ-ийн 2 гишүүн цусаа хандивлаж донорын эгнээг өргөжүүллээ.
10	Витаминжуулалтын аян	12 дугаар сарын 11-нд	1,2-р байр	“Ач үр” ХХК	Оюутан, багш, ажилчдад хэрэгцээтэй витамин, дархлаа дэмжих бүтээгдэхүүнийг сурталчилж, бүтээгдэхүүнээр үйлчиллээ.
11	Ханиад томуунаас урьдчилан сэргийлэх зорилгоор томуугийн эсрэг вакцин	09 дүгээр сарын 01-нээс 12 дугаар сарын 01 хүртэлх	БуХС-ийн эмчийн өрөөнд	Жи Ди Би-ХХК – тай гэрээ хийн	105 105 хүнд томуугийн эсрэг вакцин хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авлаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ /Сургалт/

Хүснэгт 5.23

д/д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамрагдсан хүний тоо	Үр дүн
1	ISO чанарын менежмент сургалт	10 дугаар сарын 14, 21	1 байр 203 тоот		2	Сургалтад хамрагдсанаар үйл явцын талаар мэдээлэлтэй болсон
2	Анхан шатны тусламжийн сургалт	10 сарын 22 нд	МТС	МТС-ийн эмч Д.Отгонхишиг ХУД-ийн УЗН-ийн арга зүйч Б.Наранхуу,		Чанарын менежментийн 7 хоногийн хүрээнд Номын санч, сургалтын мастерууд, үйлчлэгч нар хамрагдсан.

				сургагч багш О.Ариунболд		
3	Хөгжлийн бэрхшээлтэй оюутны анхдугаар сургалт зөвлөгөө	11 дүгээр сарын 1-нд	Соёл урлагийн их сургууль	Арга билиг холбоо	ОСҮА-1, ЭМСТ-1, ЗУЗК-8, ХБО-7, ИТ-3	Хөгжлийн бэрхшээлтэй оюутны анхдугаар сургалт зөвлөгөөнд оролцож, хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудын эрхзүй, тэдний суралцах орчинд тайлбар өгч ажиллаа.
4	Хичээлийн байруудад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисыг зөв найруулж хэрэглэх тухай сургалт	11 дүгээр сарын 7-нд	1-р байр 203 тоот	БАА, ЭМСТ	15	Хичээлийн 8-р байрны үйлчилгээний ажилчдад цэвэрлэгээ, халдваргүйжүүлэх бодисыг зөв найруулж хэрэглэх тухай заавар, зөвлөмж өглөө.
5	Амь тэнссэн үеийн амилуулах тусламж сургалт	11 дүгээр сарын 14-нд	ЭХЭМҮТ-ийн хурлын зааланд	Шүдний кабинет		Хөдөө орон нутаг, Улаанбаатар хот болон дүүрэг хувийн шүдний эмнэлгийн эмч, ажилчдад зориулсан бүтэн өдрийн сургалтад хамрагдсан.
6	Сүрьеэ өвчин, БЗДХ, ДОХ өвчний талаар сургалт	11 сарын 22-нд	МСҮТ	МТС-ийн эмч Д.Отгонхишиг	30	МСҮТ-ийн 3-р ангийн сурагч хамрагдсан.
7	Анхны тусламжийн сургалтыг зохион байгуулсан	11 дүгээр сарын 18, 20-нд	8-р байр 4-402, 302, 307	ЭМСТ	80	КООСЕН ТК-ийн 11,12-р ангийн сурагчдад Анхны тусламжийн хичээлийг заасан
8	Ажлын байрны эрүүл ахуй, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн бодисыг зөв найруулж хэрэглэх нь сэдэвт сургалт	12 дугаар сарын 05-нд	Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газар Хангарьд 14 давхарт В заал	ЭМТ	45	Халдваргүйтгэлд хэрэглэх багаж хэрэгсэл, халдваргүйжүүлэгч бодис, халдваргүйтгэх уусмал бэлтгэх, хэрэглэх зарчим, түүнийг хадгалах горим, хордсон үед авах арга хэмжээний талаар мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллаа.
9	Шавж устгал хийсэн	10 сарын 26-нд	МТС	МТС-ийн эмч Д.Отгонхишиг		ЖИЛЮ-5%-ийн уусмалаар сургуулийн болон дотуур байрны нийт талбайд

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ /Вакцинжуулалт/
Хүснэгт 5.24

Д/Д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамрагдсан хүний тоо	Үр дүн
1	Дархлаажуулалтын төлөвлөлтийн дагуу 15 насны сурагчдад сахуу татрангийн эсрэг вакцинжуулалт	9 сарын 28-нд		МТС-ийн эмч Д.Отгонхишиг Энх-Титэм ӨЭМТ-ийн эмч сувилагч нартай хамтран	167	МехТС-ийн МСҮТ-ийн 167 сурагч хамрагдсан.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ /Бусад/

Хүснэгт 5.25

Д/Д	Үйл ажиллагааны нэр	Хугацаа	Хаана	Зохион байгуулагч	Хамрагдсан хүний тоо	Үр дүн
1	ШУТИС түүхт 60 жилийн ойг угтан ЭМСТ эрүүл мэндийн өдөрлөг	9 дүгээр сарын 16-20-нд	Номын сан 604 тоот өрөөнд	ШУТИС захиргаа ЭМСТ ЭХС	80	Тус өдөрлөгт ШУТИС-ийн удирдлагууд, НЭМГ, СБДЭМН, ЭМЯ, БСПШУСЯ-ны төлөөлөгчид, мөн ШУТИС-ийн ЭМСТ-ын түүхийг бичилцсэн хүмүүс, боловсролын байгууллагад ажилладаг эмнэлгийн ажилчид оролцлоо.
2	Шилдэг багш шалгаруулалт	09 дүгээр сарын 17-нд		Шүдний кабинет	4	ҮТС-ийн Х.Мөнхзаяа, Ц.Минжмаа, ЭХС-ийн О.Чимэд, ГУУС-ийн Б.Наранцэцэг нарын хариуцсан оюутнууд нь эрүүл мэндийн төвөөс зохион байгуулагдсан үйл ажиллагаанд хэр идэвхтэй оролцсон талаар шүүж, тодорхойлолт гаргаж ажилласан.
3	ЭМСТ-ийн захирлын судалгаа	09 дүгээр сарын 27	ЭМСТ шүдний кабинет	ЭМСТ		Шүдний кабинетын эмч, сувилагчийн мэдээлэл болон ашиглаж байгаа /үндсэн хөрөнгө/ тоног төхөөрөмжийн судалгааг гаргаж mail хаягаар илгээв.
4	Эм тарианы хугацаа	09 дүгээр сарын 27	ЭМСТ Дотрын кабинет	ЭМСТ		Дотрын кабинетын яаралтай тусламжийн шүүгээ болон эмчийн 2 бикс цэнэглэж, хугацаа дууссан эм тариаг ялган ангилав.
5	“Эрүүл сургууль-Цэвэр орчин” сэдэвт гадна талбайн цэвэрлэгээ	10 дугаар сарын 19-нд	Хичээлийн 1,2,3-р байр номын сангийн задгай талбай	ЗУЗК, ОХ, ЭМСТ	19	Хичээлийн 1-р байр, номын сангийн гадна талбайн цэвэрлэгээг ШУТИС ЗУЗ Клубийн Гэрэлчимэг, Урангоо, Лүмсүрэн, Долгорсүрэн, Эльмира гишүүдтэй хамтран цэвэрлэж нийт 11 шуудай хог хаягдлыг нийтийн хогийн саванд хийж цэвэрлэсэн, Хичээлийн 2-р байр Т байрыг ШУТИС Оюутны холбооны О.Бадрах, Б.Тэмүүлэн, Б.Пүрэвбат, Б.Эрдэнэбүрэн, Т.Тулгабат, А.Энхжин, Ш.Өнөболд, Э.Үүрцайх гишүүдтэй хамтран цэвэрлэсэн.
6	Цаас бол хаягдал	10 дугаар сарын 22,23-нд	ЭМСТ		248,5кг	Багш, ажилчдын хэрэглэж дууссан цаасыг цаасны үйлдвэрт хүргэж ахин боловсруулалтад оруулж өндөгний сав болгохоор өгсөн билээ.
7	“Эрүүл сургууль-Цэвэр орчин” сэдэвт анги, танхимын цэвэрлэгээ	10 дүгээр сарын 26-нд	Хичээлийн 1-р байрны 4 давхрын задгай талбай	ЗУЗК	5	Хичээлийн 1-р байр, номын сангийн гадна талбайн цэвэрлэгээг ШУТИС ЗУЗ Клубийн Урангоо, Лүмсүрэн, Долгорсүрэн, Эльмира гишүүдтэй хамтран цэвэрлэж, задгай талбайн ширээний бохь, бохирдлыг цэвэрлэлээ.

5.6.2 COVID-19 Корона вирусийн халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хяналт тандалт

Дэлхий дахинд COVID-19 халдвар дэгдсэнтэй холбоотойгоор ШУТИС-ийн Захиргаа удирдлага, Эрүүл мэндийн төвөөс хамтран дараах үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн билээ. Үүнд:


- Эрүүл мэндийн яам, Нийслэлийн Эрүүл мэндийн газраас өгсөн чиг үүргийн дагуу хичээлийн байр, дотуур байруудад анхааруулах хуудас, зөвлөмж тарааж байршуулсан.
- Хичээлийн байр, дотуур байруудын ариун цэврийн өрөөнд гар халдваргүйтгэл, гадаргуу халдваргүйжүүлэх уусмал байршуулсан.

- Үйлчилгээний ажилчдад халдваргүйжүүлэх уусмалыг хэрэглэх зааврын талаар сургалт орсон
- Цэвэрлэгээ, үйлчилгээнд хяналт тавьж ажилласан
- Хичээлийн 2, 3, номын сангийн хаалгыг хааж зөвхөн 1-р байрны хаалгаар халуун хэмжиж, тандалт судалгааны тэмдэглэл нэвтрүүлж, маск зүүлгэн, гарыг халдваргүйжүүлэн орууллаа
- Монгол улсад анхны тохиолдол бүртгэгдэхэд хичээлийн 2,3-р байрыг “Улаанбаатар ариутгал” ХХК компаниар халдваргүйжүүлж ажилласан
- Цаашид хөл хорионы дэглэмийн үед хичээлийн байр, дотуур байруудад тодорхой давтамжийн дагуу халдваргүйтгэлийг тогтмол хийж ажилласан.

COVID-19-ийн хөл хорионы үед ШУТИС-д нэвтэрсэн хүмүүсийн бүртгэлийн тоо

Хүснэгт 5.26

№	Салбар сургууль	3 сар	4 сар	5 сар	6 сар	НИЙТ
1	БАС	320	651	1278	1098	3347
2	ГХС	62	162	474	283	981
3	ГУУС	279	568	1035	830	2712
4	ХШУС	235	552	869	622	2278
5	ҮТС	235	779	1077	645	2736
6	ЭХС	272	619	1086	805	2782
7	Захиргаа	956	1792	1986	1495	6229
8	Номын сан	170	322	552	521	1565
9	Хэвлэх	63	156	223	230	672
10	Төсөл	141	292	271	267	971
11	8 байр	234	963	1193	836	3226
12	МХТС	13	34	61	66	174
13	МехТС	29	93	100	75	297
14	БуХС	29	66	163	122	380
15	Гаднаас	164	310	487	486	1447
16	Харуул	97	182	153	81	513
17	КООСЕН	17	20	75	32	144
18	Оюутан	16	247	580	303	1146
19	Боловсролын яам	2	0	0	0	2
20	Сангийн яам	11	44	2	0	57
21	ШУТАС	7	11	15	14	47
22	Дархан ТС	2	0	4	5	11
23	Хүрээлэн	8	3	3	0	14
24	Сурагч	0	0	0	54	54
	НИЙТ	3363	7866	11687	8870	31786



Зураг 5.23. COVID-2019 цар тахлын хөл хорио тогтоосон үед сургууль руу нэвтрүүлсэн ажилчдын тоо

5.6.3 Орчны эрүүл ахуй ариутгал, халдваргүйжүүлэлт

Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба, НМХГ-ын заавар, зөвлөмжийн дагуу Кlorsept бодисыг зааврын дагуу найруулж ШУТИС-ийн хичээлийн байр болон дотуур байруудад тодорхой давтамжтай ариутгал хийв.

Эмнэлгийн тусламж үйлчилгээ





COVID-19 Хөл хорионы үед ажилласан

Нийт багш, ажилчдын халуун хэмжиж, бүртгэн, гар ариутгаж оруулсан



Анх Монгол Улсад COVID-19 бүртгэгдсэн өдөр өндөржүүлсэн бэлэн байдал зарлаж, хичээлийн байруудад өөрсдийн нөөц бололцоогоор халдваргүйтгэл хийж ажилласан



Оюутны 1-р байрнаас оюутнуудын эд зүйлс өгөхөд халуун хэмжиж, гар халдваргүйжүүлж, бүртгэж ажилласан, дотуур байрны ариутгал



Ариутгал, халдваргүйжүүлэх компаниар хичээлийн 2, Т байр ариутгуулахад хяналт тавьж ажилласан




Хичээлийн 4-р байр болон 1,2, 8, Т, Н/сан байрнуудад халдваргүйтгэлийг тогтмол хийж ажилласан.



Модны хүрээлэнд халдваргүйтгэл хийж ажилласан



Бусад байрны халдваргүйтгэл хийж ажилласан байдал



Халдваргүйжүүлэх бодис, хамгаалах хувцас, гар ариутгагч, малгай маск зэргийг холбогдох албадтай хамтран захиалан авч тарааж, цэвэрлэгээ үйлчилгээнд хяналт тавин ажиллаа.





ЗУРГААДУГААР БҮЛЭГ

НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

ЗУРГАА. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

6.1. ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН НОМЫН САН

ШУТИС-ийн Шинжлэх ухаан технологийн номын сан нь 2019-2020 оны хичээлийн жилд цахим номын бүрдүүлэлт, цахим үйлчилгээг уншигчдад хүргэх, олон улсын мэдээллийн санг таниулан сурталчлах, уншигчдад хандсан шинэлэг үйлчилгээг нэвтрүүлэх, номын санч үйлчилгээний ажилчдын мэргэжил, мэдлэгийг дээшлүүлэхэд анхаарч сургуулийн удирдлага, бүрэлдэхүүн сургуулиудтай хамтран ажиллалаа.

ШУТТНС-аас “Нээлттэй хаалганы өдөр”, “Соёл урлагийн ажилтны өдөр”, ШУТИС-ийн 60 жилийн ойн хүрээнд Түүхэн 6 ботийн нээлтэд зориулан “Ном залах ёслол”, “Үндсэн сурах бичиг, профессор багш нарын бүтээлийн номзүйн нээлт”-ийг тус тус зохион байгууллаа.

Дэлхий нийтээр COVID-19 цаг тахал гарсантай холбогдуулан 2020 оны 1 дүгээр сараас сургалтын үйл ажиллагаа цахимаар явагдаж эхэлсэн ба уг ажлын хүрээнд ШУТНС нь СБЗГ-тай хамтран нийт оюутан суралцагчдын хэрэгцээ шаардлагад тулгуурлан шаардлагатай ном, сурах бичиг гарын авлагаар хангах үүрэг хүлээн ажиллалаа.

ШУТИС-ийн Захирлын зөвлөлийн 2019 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/233 тоот тушаал, 2006 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Үндсэн сурах бичгүүдийг ШУТНС-ийн электрон каталогид веб хувилбараар оруулж суралцагсад онлайнгаар судлах боломж бүрдлээ. Үндсэн сурах бичгийг зөвхөн ШУТИС-ийн уншигч /нийт профессор багш, ажилтан, ажилчид, оюутнууд/ өөрийн нэвтрэх эрхээр үзэх эрхтэй ба гадны уншигчдад хаалттай, хамгаалалттай хийлээ. Энэ нь уншигч номын сангаас ном авч уншдагтай адил үйлчилгээг гэрээсээ авч байна гэсэн үг юм.

2019-2020 оны хичээлийн жилд аудит, санхүүгийн бичиг баримтын шалгалтад баримт бүрдүүлэх, тайлан мэдээ, бичиг хэрэг хөтлөлт, номын сангийн тодорхой нэгжүүдийн үйл ажиллагааг шинэчлэх ажлуудыг амжилттай хийлээ. Номын сангийн нэг цэгийн үйлчилгээгээр профессор багш нарын ном сурах бичиг, бичиг хэрэг, хувилах, хэвлэх үйлчилгээнээс гадна хүрээлэнгүүдийн брэнд бүтээгдэхүүнийг гэрээний дагуу хэрэглэгчдэд хүргэж байна. Номын сангийн үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгааг уншигчдаас тогтмол авч үйлчилгээндээ нэвтрүүлэн ажиллаж байна.

Тус хичээлийн жилд номын сангийн хурлын танхимын чанга яригчийг иж бүрнээр нь шинэчлэн захиргаа, бүрэлдэхүүн сургууль, төрийн болон хувийн хэвшлийн дотоодын болон гадаадын байгууллагууд, ШУТИС-д олон улсын төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч байгууллагуудын зохион байгуулсан 2210 орчим оролцогчийг хамарсан (давхардсан тоогоор) 37 удаагийн эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөн, сургалт семинар, албан уулзалтуудыг зохион байгуулсан байна.

Номын санчдын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг тогтмолжуулж, докторантурт 2, магистрын сургалтад 1 номын санч суралцан, 1 номын санч СУИС-ийн магистрын зэргийг амжилттай хамгааллаа.

Номын санчдын үйлчилгээний хувцсыг шинэчлэн, уншлагын танхимуудыг цэцэгжүүлэн, үйлчилгээний тав тухтай орчныг бүрдүүлэн, уншигчдад хандсан соёлч, боловсон, нээлттэй мэдээллийн үйлчилгээ үзүүлэн ажиллалаа.


6.2. НОМЫН САНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ, ФОНД БҮРДҮҮЛЭЛТ

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС-ийн Төв болон бүрэлдэхүүн сургуулиудын /БуХС, МТХС, МехТС, ДаТС, ОрТС/ номын сангаас бүрдсэн 6 салбар номын сан 1998 уншигчийн суудалтайгаар давхардсан тоогоор 195,300 гаруй


уншигчдад 116,955 ном, материал болон цахим үйлчилгээг хүргэж ажиллалаа. Энэ хичээлийн жилд нөхцөл байдалтай уялдуулан цахим ном, судалгааны санг нэмэгдүүлж, доктор, магистрын судалгааны ажлуудыг 100 % цахим хэлбэрт оруулан онлайнар үзэх боломжийг бүрдүүлж, үйлчилгээг хүргэлээ. Цахим ном, сурах бичиг болон судалгааны сангаас 6300 гаруй гаруй уншигчид 16,200 гаруй цахим ном, судалгааны ажлыг үзэж онлайнар үйлчлүүлсэн байна. Уншигчдаас давхардсан байдлаар 8,900 гаруй удаа холбогдож, лавлагаа ном зүйн үйлчилгээ үзүүлээ.




Зураг 6.1. /Статистик мэдээллийг номын сангийн үйлчилгээний “Lib4u” програмаас гаргасан болно/




Зураг 6.2. Цахим ном, сурах бичиг, судалгааны сангийн үйлчилгээний статистик үзүүлэлт



Зураг 6.3. Докторын судалгааны ажлын цахим сан



Зураг 6.4. Магистрын судалгааны ажлын цахим сан




Зураг 6.5. Цахим ном, сурах бичгийн номын судалгаа


Энэ хичээлийн жилд электрон каталогт гаднын уншигч 26,828 удаа, ШУТИС-ийн профессор багш, оюутан, судлаачид 70,645 удаа хандаж, нийт 100,000 орчим хандалт хийсэн байна.

Тогтмол хэвлэлийн уншлагын танхимаар 12 нэр төрлийн гадаад сэтгүүл, 13 нэр төрлийн монгол хэвлэл захиалан уншигчдын хүртээл болгож байна.

Ном сэргээн засварлах, хувилах үйлчилгээгээр эргэлтэд их гарсан 180 гаруй ном, сурах бичгийг сэргээн засварлаж үйлчилгээнд гаргаж, багш нарын захиалгын дагуу зохиогчийн эрх нь шийдвэрлэсэн 40 орчим ном, сурах бичгийг хувиран олшруулах үйлчилгээ үзүүлээ.



Зураг 6.6. Гадаад хэвлэлийн захиалга: Нэр төрлөөр



Зураг 6.7. Гадаад хэвлэлийн захиалга: Үнийн дүнгээр

Фонд бүрдүүлэлт: ШУТИС-ийн фонд бүрдүүлэлт нь “Номын сангийн үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг үндэслэн хийгддэг. Тус журмын дагуу 2019-2020 оны хичээлийн жилд 98 сая гаруй төгрөгийн бүтээл, мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг авч оюутан сурагчдын хүртээл болгож байна.

ШУТИС-ийн түүхт 60 жилийн ойг угтсан бүтээлч ажлын хүрээнд сургалт, судалгааны үйл ажиллагааг хөгжүүлэх, оюутан суралцагчдын сургалтын хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэхээр профессор багш нарын “ҮНДСЭН СУРАХ БИЧИГ”-ийг бүтээн хэвлүүлээ. Нийт 100 гаруй профессор багш

нарын 61 үндсэн сурах бичгийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр номын сангийн үйлчилгээний програмд оруулан онлайн аар унших боломжийг бүрдүүлж ажиллалаа.


Тус номын сан БНХАУ-ын СЕРИЕС хэвлэлийн газартай хамтран ажиллаж, профессор багш нарын захиалгын дагуу техник технологийн 9 сая гаруй төгрөгийн 74 нэр төрлийн ном, сурах бичгийг авч фондын сан хөмрөгөө нэмэгдүүлэн, сургалт, судалгаанд ашиглаж байна.

ШУТИС-ийн номын фонд бүрдүүлэлтийн тоон үзүүлэлт /Сүүлийн 3 жилийн харьцуулсан судалгаа/


Хүснэгт 6.1

д/д	Номын сан	2017 он			2018 он			2019 он			2020 оны эхний хагас жил		
		Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн	Нэр төрөл	Тоо ширхэг	Үнийн дүн
1	ШУТТөв номын сан	312	3,715	107,917,815	326	4,345	115,898,840	185	3,670	82,938,480	152	1,900	40,832,999
2	БУХС номын сан	137	1,652	32,628,210	133	1,002	29,912,000	46	453	9,697,586	16	76	3,329,000
3	МехТС номын сан	116	1,280	16,208,000	15	1,572	38,692,000	72	1,594	17,445,000	2	10	300,000
4	МХТС номын сан	62	367	10,146,751	21	273	7,885,053	18	289	5,612,200	3	33	890,000
5	ДаТС номын сан	13	106	2,290,000	84	193	4,513,000	129	352	4,754,200	16	31	571,600
6	ОрТС номын сан	118	464	10,723,000	81	2,136	25,217,300	73	1,546	29,693,300	1	40	1,000,000
НИЙТ :		758	7584	179,913,776	660	9,521	222,118,193	523	7,904	150,140,766	188	2,056	46,923,599

Тоо ширхэгээр



Үнийн дүнгээр



Зураг. 6.8. Номын фонд бүрдүүлэлтийн харьцуулсан судалгаа

6.3. САНГИЙН АВТОМАТЖУУЛАЛТ, ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭ

ШУТИС-ийн номын сан тус хичээлийн жилд цахим үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад анхаарч нээлттэй нөөц материалын санг нэмэгдүүлэн ОУ-ын мэдээллийн сангийн эрх авах, төрлийг нэмэгдүүлэх, цахим үйлчилгээг төрөлжүүлэн ажиллалаа.

Цахим сан хөмрөгийн баяжилт:

ШУТИС нь шинэ номын мэдээ-мэдээлэл, лавлагаа номзүй, хувиалан олшруулах, онлайн аар номын захиалга хийж профессор багш, судлаачдын мэдлэг чадвар, чадавхыг сайжруулах, цахим сургалтад нэн шаардлагатай, эрэлт хэрэгцээтэй, сурах бичиг, гарын авлагыг е-хэлбэрт оруулах, сэргээн засварлан, олшрууллаа.

2019-2020 оны хичээлийн жилд ШУТИС номын сангийн Lib4u програм хангамжийг үйлчилгээнд ашиглаж нэгдсэн каталогтой болсон нь цахим сургалтын үед

давуу талтай байлаа. Нэвтрэх эрх бүхий уншигчид нь катологид орсон веб хувилбартай номыг бүрэн эхээр нь бүх төрлийн төхөөрөмж /компьютер, гар утас, таблет г.м/ ашиглан унших, гэрээр авсан ном, материалын хугацаа дуусахад онлайнаар сунгуулах хүсэлт явуулах, мэдээлэл авах зэргээр цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлсэн нь профессор багш, судлаач, уншигчдын талархлыг хүлээсэн үйлчилгээний нэг хэсэг болсон.

Цахим санг нэмэгдүүлэх үүднээс Үндсэн сурах бичиг, Профессор багш нарын бүтээлийн номзүй, судалгааны ажил /магистр, докторын зэрэг горилсон бүтээл/, эрдэм шинжилгээний бичиг, уншигчдын хэрэгцээ шаардлага, хүсэлтийн дагуу мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлагыг PDF хэлбэрт хөрвүүлж ШУТИС-ийн электрон катологид оруулж онлайнаар судлах боломжийг бүрдүүллээ.


Мэдээллийн сангуудыг ашигласан байдал:

Шинжлэх Ухаан Технологийн төв номын сан нь эрдэм шинжилгээ сургалтын үйл ажиллагааг дэмжих, мэргэжлийн ном сэтгүүлийн цахим нөөцийг бүрдүүлэх зорилгоор техник, технологийн чиглэлийн олон улсын мэдээллийн сангийн эрхийг авч судлаачдын хүртээл болгож байна. Нээлттэй мэдээллийн сангийн ашиглалт, статистик, татгалзлын судалгааг тогтмол гарган үр дүнгээс хамаарч цаашид ямар төрлийн мэдээллийн сан эрэлт хэрэгцээтэй байгаад дүгнэлт хийж, тухайн салбарын мэдээллийн сангийн эрх авах, е-номын захиалгад тусган ажиллаж байна.

ОУ-ын SpringerNature, EBSCO мэдээллийн сангийн Energy & Power Source, Applied Science & Technology Source Ultimate, Engineering Source, Computers & Applied Sciences Complete багцуудын эрхийг авч, Wiley-ийн 1997 оноос хойш хэвлэгдсэн 1600 гаруй сэтгүүлийн 8 сая гаруй мэдээлэл үзэх туршилтын үнэгүй эрхийг ашиглалаа.

Дэлхий нийтээр цахим сургалт явуулж байгаатай холбогдуулан EBSCO-оос ШУТИС-ийн уншигчдад зориулан тусгай <http://ebSCO.cc/must> линк гарган Harvard Business Publishing-ийн 600 гаруй цахим номыг 2020 оны 5 дугаар сарын 30-ны өдөр хүртэл үзэх боломжийг олгосон нь судлаачдад маш их эрэлттэй байлаа.

Онлайнаар хэрэглэгчийн бүртгэл болон нууц үг сэргээх үйлчилгээ, заавар, зөвлөмж, мэдээлэл өгч ажиллав. Мөн веб сайт, нийгмийн сүлжээний хэрэгслээр электрон каталог, мэдээллийн санг хэрхэн ашиглах зөвлөмж, шинээр нэмэгдсэн веб хувилбартай е-Ном, ашиглах боломжтой мэдээллийн сангуудын мэдээллийг тухай бүрд нь мэдээлэл бэлтгэн хүргэв.



Зураг 6.9. Мэдээллийн сангийн хандалтын судалгаа

Мэдээллийн сангийн хандалтын судалгаа

Хүснэгт 6.2

Database	Applied Science & Technology Source Ultimate	Computers & Applied Sciences Complete	Energy & Power Source	Engineering Source	TOTAL
Abstract Requests	140	320	75	186	721
Database Sessions	304	293	283	294	1174
Total Requests	385	742	258	463	1848
- Эрчим хүчний үнэ өртөг тогтвортой.

Нийгмийн хүчин зүйлс



- Хүний хөгжлийн индексээр 92
- Дундаж наслалт 69.5
- Хөдөлмөрийн чадвартай ажилгүйдчүүд 7%
- Авьяасыг дэмжих байдлаараа дэлхийн 63 орны хамгийн сүүлийн байр эзэлсэн.
- Нийгэмд дээд боловсролын чанарыг сайжруулах шаардлага бүрдсэнийг бүх шатандаа ойлгосон

Технологийн хүчин зүйлс




- Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 0.2% (96)*
- Шинэ патент 1 сая хүнд -0.45 (76)
- Хүн амын цахим ур чадвар 3.7 (94)
- Интернэт хэрэглэгчид 22.3% (115)
- Хөдөлгөөнт холбоо хэрэглэгч 100 хүнд 126.4 (49)


4. Хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсэгт орж ажиллан, ДБ-ын байгууллагын хүний нөөцийн судалгаа хийх, багшийн ур чадварыг сайжруулах стратеги төлөвлөгөө боловсруулан, ШУТИС-2030 хөгжлийн хөтөлбөр, стратегийн төлөвлөгөөнд тусгуулахаар ажилласан.
5. Дээд боловсролын сургалтын байгууллагын Багшийн хөгжлийг дэмжих төвийн үйл ажиллагааг жигдрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны дагуу “Дээд боловсролын инновац дэвшилтэт технологи нэвтрүүлэх арга зам”-ыг боловсруулах ажлын хэсэгт Д.Ганбат, Р.Найдандорж, Д.Ариунболор, П.Цэрэнчимэд нар ажиллан, тайланг БСШУСЯ-ны ажлын хэсэгт хүлээлгэн өгөв. Энэ ажлын хүрээнд Дээд боловсролын багшийн үнэлгээний системийн концепц загвар гаргах, Үнэлгээний аргачлал, арга зүйг судлан, хэлэлцүүлэг хийх ажлыг багийн гишүүдийн хамт хийж байна.

СУРГАЛТАД ИННОВАЦ, ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ

Дэд ажлын хэсгийн тайлан
2020.04.25



ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН СУРГАЛТЫН ШИНЭ АРГА ТЕХНОЛОГИ ЭЗЭМШИХ, НЭВТРҮҮЛЭХ ХЭРЭГЦЭЭНИЙ СУДАЛГАА



- УДСБ-CDIO хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтвортой хөгжүүлэх зорилгоор ИДС-ийн Багшийн мэргэшлийн стандарт боловсруулах ажлын хэсэгт Д.Ганбат, Р.Найдандорж, Д.Ариунболор, П.Цэрэнчимэд нар орж ажиллан, “Их сургуулийн багшид тавигдах нийтлэг шаардлага” мөн “Их сургуулийн багшийн түвшин бүрт тавигдах нийтлэг шаардлага”-ын санал боловсруулан, БСШУС-ын сайдын 2020 оны 05-р сарын 29-ний өдрийн А/270 тоот тушаалаар “Дээд боловсролын сургалтын байгууллагын багшид тавигдах нийтлэг шаардлага” баталгаажсан.



7. ШУТИС-ийн ахисан түвшний сургалтыг шинэчлэх ажлын хэсэгт орж ажиллав. Дүрэм журамд оруулах ажлын хэсгийн санал боловсруулсан.
8. ШУТИС-ийн хөтөлбөрийн шинэчлэлийг дэмжих зорилгоор /ШУТИС-ийн БОЛОВСРОЛ 4.0/ хөтөлбөрийг боловсруулахаар багаараа ажиллаж байна.



9. ШУТИС-ийн нийт багш нарт зориулсан lightboard технологийг ашиглан дижитал хичээл бэлтгэх зөвлөмж хичээлийг боловсруулж Covid-19 цар тахлын үед онлайн хичээл бэлтгэх заах арга зүйгээр багш нарт дэмжлэг үзүүлсэн.
10. БСШУСЯ, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд “Дээд боловсролын удирдлага” Нийтэд зориулсан нээлттэй онлайн хичээл буюу МООС бэлтгэх ажлыг хариуцан гүйцэтгэж, 2020 оны 06-р сарын 30-ны өдөр хүлээлгэж өгөхөөр бэлтгэн, 6-р сарын 23-нд урьдчилсан хэлэлцүүлэг хийсэн.


**“ДЭЭД БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА” МООС-ИЙГ ТАНИЦУУЛАХ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР**

Хаана: ШУТИС-ийн 8-р байр

Хэзээ: 2020 оны 6 дугаар сарын 23-ны Мягмар гараг, 10:00-12:00


Зохион байгуулагч: ШУТИС, Нээлттэй боловсролын төв

Хугацаа	Үйл ажиллагаа	Танхим	Хариуцах эзэн
9:30-9:50	Зочдыг угтан авах	8-р байрны 1-р давхарт	А.Гандолгор
10:00-10:20	МООС-ийн төслийн тухай товч танилцуулга	12-р давхар, ОУ-ын ЭШ-ний хурлын танхимд	Д.Ганбат
10:20-10:30	Дээд боловсролын онол арга зүй ном	12-р давхар, ОУ-ын ЭШ-ний хурлын танхимд	Д.Бадарч
10:30-11:00	Дээд боловсролын менежмент МООС	12-р давхар, ОУ-ын ЭШ-ний хурлын танхимд	Д.Ганбат Б.Мөнххүж П.Цэрэнчимэд
11:00-11:30	Хэлэлцүүлэг	12-р давхар, ОУ-ын ЭШ-ний хурлын танхимд	Д.Бадарч Д.Ганбат Р.Найдандорж
11:30-12:00	НБТ-ийн дижитал орчны танилцуулга	8, 9-р давхар	Д.Ганбат Р.Найдандорж
12:00-13:00	Сургалтын бэлтгэл ажлын онлайн нээлт, техник хангамжийн тохиргоо, бүртгэл, бэлтгэл ажил, зүтгүүлэлт /edX платформы/	12-р давхар, ОУ-ын ЭШ-ний хурлын танхимд	Б.Мэндсайхан П.Цэрэнчимэд



11. Дээд боловсролын онол арга зүй номыг иж бүрэн боловсруулан материал бэлтгэх, өрөлт хийх, редакторлах ажлуудыг хийж гүйцэтгэн, номоо хэвлүүлсэн
12. Дээд боловсролын судалгаа, хөгжүүлэлт хийх ажлын хүрээнд:
 - Сингапур, Англи, Австрали болон бусад гадаадын их сургуулиудын багшийн мэргэшлийн стандарт тогтолцоог судлан мэдлэгээ сайжруулан, ажилдаа тусган, хэрэгжүүлж байна.
 - Багшийн манлайлал, багшийн ачаалал тооцох загвар, номын сангийн үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр судалгааны ажил хийж байна.
 - Багшийн хөгжлийн дэмжих хөтөлбөрийг ШУТИС-ийн стратеги төлөвлөгөө, хүний нөөцийн бодлоготой уялдуулж, хөтөлбөрийн талаар эмхэтгэл гаргаж хэвлүүлсэн.
 - Их сургуулийн багшийн ур чадварын шаардлагыг тогтоох, багш бэлтгэх, мэргэжлийн баримжаа олгох, залгамж халааг дэмжин чадавхжуулах дадлагажигч багшийн хөгжүүлэх хөтөлбөр гаргасан.

- Дээд боловсролын сургалтын байгууллагын гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт, үнэлгээний системийн хөгжүүлэлтээр судалгаа хийж эрдэм шинжилгээний өгүүлэл гаргасан.
- Багш ажлын байран дээр хөгжих асуудлаар судалгаа хийж эрдэм шинжилгээний өгүүлэл гаргасан.
- Их сургуулийн хэмжээний ёс зүйн бүтээлээрээ Зохиогчийн эрхийн гэрчилгээ авсан.
- IPOST-Proceedings Volume II-Case study will be one of the contemporary methods for training нэг сэдэвт бүтээл гаргасан.
- Goals of the mentor program. Дадлагажигч багш нарыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж байна.
- Инженерийн ёс зүйн хичээлийн гарын авлага, боловсрол судлалын гарын авлага боловсруулж сургалтад нэвтрүүлсэн.
- ШУТИС, МУИС, МУБИС, ХААИС-ийн Багшийн хөгжлийн хөтөлбөрийн багшийн чадамжийн тодорхойлолтод зэрэгцүүлсэн судалгаа хийв.
- ШУТИС-ийн багш нарын заах арга зүй, мэргэжил дээшлүүлэх сургалтын хэрэгцээ тодорхойлох асуулгын асуулга бэлтгэсэн.
- "Teacher development: How will we support and train teachers" брошур орчуулав.
- Using ICTs and Blended Learning in Transforming TVET Colin Latchem уншиж орчуулсан.
- 2020 оны 5 сард "Их сургуулийн сургалтад идэвхтэй сургалтын арга хэрэглэх нь" сэдэвт ЭШХ материалыг эмхэтгэн боловсруулж, редакторласан эхийг 21 хувь хэвлүүлж илтгэл тавьсан багш нарт хүргүүлэв.
- Бүрэлдэхүүн сургуулийн багшийн хөгжлийн багуудтай хамтран багуудын үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнд хяналт тавих цахимаар холбогдож асуудалд суурилсан сургалт зохион байгуулсан.



3. БСШУСЯ, АХБ-ны санхүүжилтээр хэрэгжүүлж буй Дээд боловсролын шинэчлэл төслийн хүрээнд Инженерийн боловсролд CDIO арга зүйг нэвтрүүлэх, CDIO арга зүйг түгээн дэлгэрүүлэх багшлах ур чадварыг сайжруулах сургалт явуулах, Багшийн хөгжлийн төвийг дэмжих ажлын хүрээнд орчин үеийн технологид суурилсан сургалт, судалгааны орчин бий болгох, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл захиалж, нийлүүлэх процесст зөвлөж ажилласны үр дүнд 2020 оны 1 ба 3-р сард 90.0 гаруй сая төгрөгийн олон үйлдэлт өнгөт лазер принтер, лазер проектор, өндөр хүчин чадлын компьютер, зөврийн компьютер зэрэг цахилгаан бараа, тоног төхөөрөмж, багшийн ур чадварыг сайжруулах сургалтын өрөөний тохижилтод зориулан 44 ширээ, 44 сандлыг Нээлттэй боловсролын төвд хүлээн авсан.

3.1 БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨВҮҮДИЙГ ТОХИЖУУЛАХ, ОРЧИНГ САЙЖРУУЛАХ

Инженерийн боловсролд CDIO арга зүйг нэвтрүүлэх, Багшийн хөгжлийн төвийг дэмжих ажлын хүрээнд орчин үеийн технологид суурилсан сургалт, судалгааны орчин бий болгох, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл захиалж, нийлүүлэх процесст зөвлөж ажилласны үр дүнд цахим хичээлийг бичих камер, олон үйлдэлт өнгөт болон хар цагаан лазер принтер, лазер проектор, өндөр хүчин чадлын компьютер, ноутбуук, ширээ, сандал зэрэг 900,0 гаруй сая төгрөгний өртөг бүхий техник хэрэгслийг ШУТИС, МУИС, ХААИС, СУИС, МУБИС, ҮБХИС-д хүлээлгэн өгсөн.



4. ШУТИС-ийн профессор багшийн албан тушаалд тавигдах нийтлэг шаардлагын төслийг хийж гүйцэтгэн, 2020 оны 06-р сарын 22-ны өдрийн ШУТИС-ийн Захирлын зөвлөлөөр хэлэлцүүлсэн.

НИЙГЭГ ШААРДАГА	А.Мэдлэг Learning to know	В. Үнэгт зүйл Learning to live together	С.Чадвар Learning to be
	A1. Судлагдахуун, салбар шинжлэх ухааны болон мэргэжлийн мэдлэг A2. Багшлахуй ба суралцахуйн арга зүй, боловсрол судлалын мэдлэг A3. Аливааг шинжлэх ухааны үндэслэлтэй судлан, шинжлэх судалгааны ажлын арга зүйн мэдлэг A4. Нийгэм, хувь хүний хариуцлагын талаар мэдлэг A5. Хууль эрх зүйн мэдлэг A6. Байгаль, хүрээлэн буй орчны талаархи мэдлэг A7. Нийгэм, соёлын талаархи мэдлэг (хувь хүний сэтгэл судлал ба нийгмийн сэтгэл судлал, жөндөрийн эрх тэгш байдал, нийгмийн эрүүл мэндийн боловсрол) A8. Сургалтанд шинэ дэвшилтэт технологийг хэрэглэх мэдлэгтэй байх A9. Гадаад хэлний мэдлэг	B1. Хууль эрх зүйн хэм хэмжээг эрхэмлэх, дагаж мөрдөх B2. Хувь хүний болон судлаачийн ёс зүйтэй байх B3. Хувь хүн болон нийгмийн ашиг сонирхолд ээлтэй хандах B4. Мэргэжлийн болон судалгааны мэдлэг үр чадвараа тасралтгүй хөгжүүлж, насан туршийн суралцагч байх B5. Олон улсын болон үндэсний түүх, соёл, уламжлалыг хүндлэн, дээдэлж, хөгжилд хувь нэмэр оруулах эрмэлзэлтэй байх B6. Мэдээлэл, харилцаа холбооны технологийн аюулгүй хариуцлагатай ёс зүйтэй хэрэглээг мөрдөх B7. Хүнлэг энэрэнгүй сэтгэл зүйн төлөвшилтэй байх	C1. Харилцааны чадвар C2. Системтэйгээр бодох чадвар C3. Багаар ажиллах чадвар C4. Бусдыг ойлгох, сэтгэл хөдөлгөө удирдах чадвар C5. Асуудлыг цогцоор шийдвэрлэх чадвар C6. Удирдан чиглүүлэх чадвар C7. Туршилт хийх, мэдлэг бүтээх чадвар C8. Мэдээллийн технологи ашиглах чадвар C9. Дижитал үр чадвар (сошиал медиа, дата аналитик, видео) C10. Гадаад хэлээр харилцах чадвар C11. Байнга суралцах чадвар

D.Үйл Learning to do		
D1. Сургалт	D2. Судалгаа, инноваци	D3. Нийгмийн болон мэргэжлийн үйлчилгээ
D1.1. Сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах D1.2. Сургалтын хөтөлбөр боловсруулах, үнэлэх, сайжруулах D1.3. Багшлахуйн болон оюутны суралцахуйн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах чаналх, дэмжих D1.4. Оюутны мэргэжлийн шинжлэх ухааны мэдлэг болон суралцах арга барил эзэмшиж байгаа байдлыг үнэлэх, тэдэнд арга зүйн зөвлөгөө өгөх D1.5. Суралцагч төвтэй сургалтын орчинг бүрдүүлэх, заах арга зүйн үр чадвараа хөгжүүлэх	D2.1. Салбар шинжлэх ухаан, салбар дундын болон мэргэжлийн хүрээнд сургалтын арга зүй болон судалгааны ажлыг бие даан болон багаар байнга хийж гүйцэтгэх D2.2. Экологи, байгаль орчин, нийгэмд ээлтэй шинэ мэдлэг, инновацийг бүтээх чадвар D2.3. Өөрийн шинэ бүтээлээ сургалт болон эдийн засгийн эргэлтэд оруулах талаар санаачлага гаргах D2.4. Үндэсний болон Олон улсын хэмжээний төсөл, хөтөлбөрт оролцох, хэрэгжүүлэх D2.5. Судалгааны ажлын үр дүн болон шинжлэх ухааны мэдээллийг олон нийтэд сурталчлах, түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачлагатай оролцох D2.6. Өөрийн ажил, мэргэжилтэй холбоотой шинжлэх ухааны суурь судалгаа, төсөл, хөтөлбөр боловсруулах, удирдах, оролцох, хэрэгжүүлэх	D3.1. Суралцагчийг түүх, соёл, ёс зүй, уламжлалаа хүндлэн дээдэлж, эрхэмлэх үйлд хөтлөх D3.2. Суралцагчдын хариуцлагатай, зөв хандлагатай мэргэжилтэн-бие хүн болж төлөвшилийг чиглүүлж, дэмжлэг үзүүлэх D3.3. Суралцагчид болон олон нийтэд зориулсан мэргэжлийн олон-арга зүйн зөвлөмж мэдээлэл бэлтгэх, ажлын арга зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх D3.4. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн чиглэлээр нийгэмд үйлчилгээ үзүүлэх D3.5. Нийгмийн сайн сайхны төлөө сайн дурын үйл ажиллагаанд оролцох D3.6. Улсын болон их сургуулийн хэмжээний бодлого, эрх зүйн баримт боловсруулах ажилд оролцох, дагаж мөрдөн засан сайжруулах талаар идэвх санаачлага гарган ажиллах

5. ШУТИС-ийн профессор багшийн багшлах үр чадварыг шат дараатайгаар хөгжүүлэх зорилгоор ШУТИС-ийн профессор багшийн хөгжлийн загвар хөтөлбөр, багшлах арга зүйн сургалтын агуулга боловсруулахаар төлөвлөж байна.

2. Профессор багшийн үр чадварыг сайжруулах загвар хөтөлбөр боловсруулах




6. Монголын ИДС-ийн багш нарыг чадавхжуулах зорилгоор ШУТИС-ийн удирдлага, БСШУСЯ, ДБШТ, АХБ-тай зөвшилцөн, хэлэлцүүлэг хийж, багшийн үр чадварыг хөгжүүлэх 6 МООС, 6 цахим сургалтын удирдамж, хөтөлбөр, төсвийн саналыг боловсруулан, БСШУСЯ-ны ДБШТ-ийн нэгжид илгээгээд байна.

7. Боловсролын хөгжил, хөтөлбөрийн агуулгыг дэмжих үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлуудыг хийх ажлын хүрээнд ШУТИС дээр ҮДСБ хөтөлбөрийг тогтвортой хэрэгжүүлэхээр 8-р байрны 801, 802, 803, тоот ангийг тохижуулах, иж бүрэн тоноглох, ЮНЕСКО-ийн шугамаар БНХАУ-ын IСНIЕ байгууллагатай гэрээний хүрээнд “Смарт анги”-тай болох ажлын дагуу 805, 806, 807 тоот ангийг “Смарт анги” болгон тохижуулах ажлыг хийж гүйцэтгэж байна.

8. ҮДСБ бодлогын арга зүйг сургалтын тогтолцоонд тогтвортой нэвтрүүлэх арга зам, Боловсрол 4.0, сургалтад дижитал технологи хэрэглэх нь сэдвээр МехТС-ийн 100 гаруй багш ажилтанд 2020 оны 1-р сарын 04-ний өдөр, ҮТС-ийн 60 гаруй профессор багшид 2020 оны 1-р сарын 16-ны өдөр сургалт явуулав.



9. ИДС-ийн багшийн хөгжлийг дэмжих ажлын хүрээнд хийгдэх цахим контент бэлтгэх ажлын үзэл баримтлал гаргахаар ажиллаж эхлэв.
10. МПТ-тай хийсэн гэрээний дагуу Механик инженерийн хөтөлбөрийг нутагшуулах ажлыг эхлүүлэх бэлтгэл хийгдэж байна.
11. ШУТИС-ийн хичээлийн 8-р байр шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан Нээлттэй боловсролын төвийг шинэ байранд нүүлгэн шилжүүлж, шинээр худалдан авч суурилуулалт хийх тоног төхөөрөмжийн зураг төсөл, судалгаа, захиалга хийж, шаардлагатай засвар тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд MOOC студи, Lightboard студи, Ухаалаг ангийн засвар тохижилтын ажлыг иж бүрэн хийж гүйцэтгэсэн. Нийтийг хамарсан нээлттэй онлайн хичээл (MOOC) бэлтгэх студи болон Ухаалаг анги: Цаашид чанартай Нээлттэй нөөц эх материал (OER) болон Нийтэд зориулсан нээлттэй онлайн хичээлийг бэлтгэж хөгжүүлэх чиглэлээр MOOC студи байгуулан ажиллаж байна.





11. ШУТИС-ийн Эрдэм шинжилгээ, инновацийн газартай хамтран "Зохиогчийн эрх" онлайн хурал зохион байгуулж, ШУТИС-ийн Захирлын зөвлөл, Эрдмийн зөвлөл, Удирдах зөвлөлийн хурлын зохион байгуулалтыг “Microsoft Office 365” платформ ашиглан явуулахад дэмжиж оролцсон.

12. ШУТИС-ийн нийт 902 багш 3130 оюутныг “Microsoft Office 365”-платформд бүртгэж, 2019/20 оны хичээлийн жилийн бакалаврын болон ахисан түвшний диплом хамгаалалтыг онлайнаар явуулах боломжийг олгож дэмжиж ажиллаж, статистик үзүүлэлтүүдийг гаргасан.

13. ШУТИС-ийн бакалаврын диплом хамгаалалтад шаардагдах програм хөгжүүлэлт болон хамгаалалтын үйл ажиллагааг зохион байгуулах програм боловсруулсан.


А. БИЧЛЭГ

Физик /200 мин/
 Монголын түүх /180 мин/
 Физик /315 мин/
 Хими /330 мин/
 Математик АС /240 мин/


Б. МОНТАЖ


Ерөнхий хими - 4 лекц /48 мин/
 Физик 2 - 5 лекц /184 мин/
 Математик 2 - 5 лекц /118 мин/
 Материалын эсэргүүцэл 2 - 5 лекц, 2 сем /176 мин/
 Механизмын зохион бүтээлт - 5 лекц /142 мин/
 Физик 1 - 3 лекц /73 мин/
 Физик химийн - 4 лекц /50 мин/
 Монголын түүх - 2 лекц /37 мин/
 Япон хэл - 3 лекц /19 мин/
 Онолын механик - 5 лекц /141 мин/
 Машины эд анги - 5 лекц /60 мин





14. ШУТИС-ийн 2019/20 оны хичээлийн жилийн хаврын улирлын төгсөлтийн ёслолын арга хэмжээг цахимаар зохион байгуулж, facebook хуудсаар 2 цаг шууд дамжуулан 135000 хүний хүртээл болгосон.
15. ШУТИС-ийн Маркетингийн албатай хамтран элсэлтэд зориулсан ГУУС-ийн шинэ хөтөлбөрийн танилцуулга, ШУТИС, Нийслэлийн цагдаагийн газартай хамтран хотын соёл хичээлийн видео дүрс болон монтажийг хийх зэргээр дэмжин ажилласан
16. COVID-19 цар тахлын үеийн хөл хорио тогтоосон үед ШУТИС-ийн профессор, багш, ажилтнууд, оюутнуудад хичээлийг онлайнаар заах, вебинар удирдан явуулах арга зүйн зөвлөмж өгч ажилласан. Тухайлбал, MS Teams, MS 365 аппликейшнүүдийг хэрхэн ашиглах талаар заавар зөвлөмж, видео танилцуулга бэлтгэж танилцуулсан.
17. Microsoft OFFICE 365 флатформийг ШУТИС-д нэвтрүүлэн, шаардлагатай гарын авлага, заавар зөвлөмжийг бэлтгэн 902 багш 3130 оюутанд хүргэсэн





18. ГУУС-ийн шинэ мэргэжлийн 5 цаг 50 минутын танилцуулга хийсэн.
19. Залуу үеийн төлөөлөл болгож VANDEBO хамтлагийн гишүүнийг оролцуулсан 60 минутын бичлэг, 4 минутын сурталчилгааны бичлэгийг боловсруулсан.
20. Цар тахалтай холбоотой оюутнуудад өгөх онлайн сургалтын мэдээлэл:
 - Ректор Б.Очирбат - 30 минутын бичлэг
 - СБЗГ-ийн дарга Д.Гэрэлт-Од - 30 минут
 - Проректор Х.Энхжаргал - 30 минут
 - МХТөвийн захирал Төрбат - 30 минут

7.4.3 Гадаад хамтын ажиллагаа


1. UNESCO-ICHEI болон ШУТИС хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хиймэл оюунаар тоноглогдсон боловсролын хөгжил, хөтөлбөрийн агуулгыг дэмжих ажлын хүрээнд НҮБ-ийн шугамаар ICHEI-ийн сургалт, хэлэлцүүлэгт цахимаар 4 багш хамрагдсан ба ШУТИС дээр смарт анги танхим байгуулах ажилд дэмжлэг үзүүлэхээр болов.



Month: June 2019

June 27, 2019

ICHEI Visited Mongolia and Signed MOU with Mongolian University of Science and Technology





On June 19-20, UNESCO-ICHEI paid a visit to Mongolia to confirm Mongolia as project country and MUST as the new partnership university in the Asia-Pacific.

2. Онлайн сургалтуудыг явуулж буй АНУ болон Хятадын туршлагыг судлан төрөл бүрийн Webinar онлайн хуралд оролцов.
3. ШУТИС, Нээлттэй боловсролын төв болон ЮНЕСКО-ийн дэмжлэгтэй Дээд боловсролын инновацийн олон улсын төвийн хооронд хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, Нээлттэй боловсролын төвд Ухаалаг анги байгуулах, Олон улсын онлайн боловсролын институтэд гишүүнээр элсэж орсон. Ингэснээр Ази,

Африкийн олон орны тэргүүлэх их дээд сургуулийн онлайн хичээлүүдийг харилцан үнэ төлбөргүй ашиглах боломжийг бүрдүүлсэн.


4. БСШУС-ын сайдын АНУ-ын MIT-тай 2019 оны 12-р сард хийсэн гэрээний дагуу ШУТИС-ийн хөтөлбөрийг шинэчлэх ажлын хүрээнд цахим уулзалт зохион байгуулж, MIT-ийн J-WEL 7 хоногийн цахим уулзалтанд оролцон, CDIO арга зүйн хэрэгжилтийн үр дүнг 2020 оны 04-р сарын 03-ны өдөр хэлэлцүүлэв.
5. БСШУСЯ-ны сайд Ё.Баатарбилэгийн АНУ-д айлчилсан айлчлалын хүрээнд Массачусетсийн технологийн их сургуулийн J-WEL лабораторитой хамтран ажиллах талаар байгуулсан гэрээний хүрээнд 2020 оны 3 сарын 30-аас 4 сарын 15-ны хооронд J-WEL 2020 Connection үйл ажиллагаанд ШУТИС-ийн 20 багшийг хамруулах үйл ажиллагааг зохион байгуулж 3 илтгэл, танилцуулга, презентас бэлтгэж оролцсон.




6. ШУТИС нь ОУ-ын CDIO санаачилгын гишүүн байгууллагын хувьд:

А. CDIO2020 Азийн бүсийн хурлыг зохион байгуулахаар ажиллаж эрх авсны дагуу дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд:

- CDIO2020 Азийн бүсийн хурлын бэлтгэл ажлын хүрээнд ОУ-ын CDIO-ийн төвөөс зөвшөөрөл аван <http://www.cdio.org> сайт дээр хурлын товчг зарлан, <http://www.cdio2020.edu.mn> вебийг агуулгын хамт шинээр боловсруулан холбуулав.



- CDIO-2020 Азийн бүсийн хурлыг 2020 оны 4 сард зохион байгуулахаар төлөвлөж бэлтгэлийг хангаж ажилласан боловч COVID-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан 2020 оны 9 сарын 24-27-ны хооронд онлайнар зохион байгуулав.



- CDIO2020 Азийн бүсийн олон улсын хурлын бүртгэлийн вебийг “Softconf” компани, хурлын үеэр ашиглагдах хэрэглээний программыг “Whova” компанитай холбогдон ажилласан.
- Хурлын нийт төсвийг боловсруулж дуусгаад, үнийн саналыг харьцуулан БСШУСЯ-ны ДБШТ-өөс 12000 долларын санхүүжилт авахаар хөөцөлдөж байна. CDIO 2020 хурлын шинэчилсэн танилцуулгыг бэлтгэж CDIO 2020 Олон улсын хуралд 2020 оын 06-р сарын 09-10-ны өдөр профессоруудын хамт хэлэлцүүлсэн.

Б. БСШУСЯ, АХБ, ДБШТ-ийн ТХН болон Сингапурын Темасек санд Ахисан түвшний CDIO арга зүйн хэрэгжилтийн явцыг тайлагнан, Ахисан түвшний CDIO арга зүйг хэрэгжүүлэх төслийн хаалтын ажиллагааг зохион байгуулж, Сингапуртай хамтран хэрэгжүүлж буй ажлаа үнэлүүлэн, дараагийн шатны “Чанарын баталгаажуулалт” төслийг 2020 оны 09-р сараас эхлэн 1 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр ажиллаж эхлээд байна.

7. ШУТИС болон Tsinghua их сургуулиудын хооронд онлайн болон зайн сургалтын чиглэлээр хамтран ажиллах, харилцаа тогтоох үйл ажиллагаанд оролцон ажиллав.
8. ЕХ-ны ERASMUS төслийг удирдаж олон улсын хуралд оролцох бэлтгэл ажлыг ханган, дараагийн шатны шинэ төслийн санал бэлтгэн, төслийн санал хүргүүлэв.
9. Австрийн засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд НБТ дээр төсөл хэрэгжүүлэхээр санал боловсруулан, хөөцөлдөж байна.

7.4.4 “Боловсрол судлал”, “Боловсролын удирдлага” хөтөлбөрийн сургалт, төгсөлт

1. Ахисан түвшний элсэлт, төгсөлтийн үйл ажиллагааг онлайн хэлбэрээр амжилттай зохион байгуулж, “Боловсрол судлал”, “Боловсролын удирдлага” хөтөлбөрөөр нийт 8 магистрыг төгсөв.
2. “Боловсрол судлал”, “Боловсролын удирдлага”-ын магистр болон докторын хөтөлбөрөөр 2019/20 оны хаврын улиралд 22 оюутан сонголт хийж, 30,388,402₮ сургалтын төлбөрт орж ирэхээс, төлбөрийн боломжгүй 12 оюутны материалыг Боловсролын зээлийн санд явуулсан.
3. Багшлах эрхийн сургалтыг 2 удаа зохион байгуулан 34 хүнийг төгсгөв.

4. UNIMIS болон БСШУСЯ-ны ДБУМС-ийн прорамм дахь өөрчлөлт, төгсөгчдийн материал, дипломын архивт үлдэх хувийг зохих журмын дагуу бэлтгэн СБЗГ-т хүлээлгэн өгсөн.
5. Мэргэжлийн хяналтын газраас шалгалт ирсэнтэй холбогдуулан 2018/19А, 2018/19В, 2019/20А улирлуудын буцалтгүй тусламж, оюутны хөгжлийн зээл, сургалттай холбоотой болон төлбөр төлөлттэй холбоотой материалуудын бүрдлийг бэлтгэж, ахлах нягтлан бодогчийн хамт хуваарьт хугацаанд нь очиж шалгуулсан.
6. Оюутны хөгжлийн зээлд хамрагдан суралцаж төгссөн зээлийн эргэн төлөлт хийгээгүй оюутнуудын судалгааг гаргаж явуулсан. Удирдлагаас ирсэн албан даалгаврын дагуу оюутнуудад мэдэгдэх хуудас явуулсан.
7. Багш, оюутан, суралцагчаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлтийг тухай бүрд нь холбогдох газарт уламжилж шийдвэрлүүлсэн.



7.4.6 Системийн динамикийн загвар боловсруулах

1. **“Монгол улсын хүн амын шилжилт хөдөлгөөн, суурьшлын загвар боловсруулах”** боловсруулсан /Барилгын хөгжлийн төв/
2. **“Монгол улсын Хүнсний аюулгүй байдлын системийн динамик загвар”** боловсруулах /ҮАБЗ-ын ажлын алба/
3. **“Улаанбаатар хотын стратеги, хөгжлийн загвар боловсруулах нь”** сэдэвт ажлыг 2020 онд хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.





НАЙМДУГААР БҮЛЭГ

САНХҮҮ НЯГТЛАН, БОДОХ БҮРТГЭЛ

НАЙМ. САНХҮҮ, БҮРТГЭЛ

8.1 САНХҮҮ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН АЛБА

Санхүү нягтлан бодох бүртгэлийн алба 2019 онд санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн програмд нэмэлт өөрчлөлтийг оруулж, санхүүгийн шинэ журмыг боловсруулж Захирлын зөвлөлийн хурлаар батлуулан, санхүүгийн ажилтнуудын мэдлэг мэргэжлийг дээшлүүлэх, сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үйлчилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаа. 2019 онд ШУТИС-ийн бүрэлдэхүүн 11 сургууль, Ахлах сургууль, “ШУТИС-Коосэн” Технологийн коллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, Ой мод сургалт судалгааны хүрээлэн, Хэвлэлийн газар, Шинжлэх ухаах технологийн номын сан, Эрдэмнэт сүлжээний төв зэрэг нийт 21 нэгжүүд үйл ажиллагаа явуулж тайлан баланс гаргасан. Монгол улсын Сангийн сайдын 388 тоот санхүүгийн тайлан, тодруулга, 55 тоот эдийн засгийн ангилал болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Санхүүгийн байдлын тайлан (СТ-1А), үр дүнгийн тайлан (СТ-2А), мөнгөн гүйлгээний тайлан (СТ-3А), цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (СТ-4А), санхүүгийн тайлангийн тодруулга (ТБСТТ-1-12) зэргийг гарган өгч, ШУТИС-ийн удирдлагын нэгдсэн системийн дэд хэсэг болох УСНББОУС-д нийцсэн санхүүгийн мэдээллийг боловсруулах “И-Finance” санхүүгийн программаар санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан. 2019 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газар, “Гранд Торнтон” аудитын компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дагуу санхүүгийн тайланд залруулах бичилтүүдийг мөн хийж гүйцэтгэсэн.

ШУТИС-ийн хэмжээнд тайлант хугацаанд 2285 үндсэн орон тоотой ажилласнаас гүйцэтгэх ажилтан 1324, үйлчилгээний ажилтан 405, гэрээт болон цагийн багш 451 хүн байна. 2020 оны 3 дугаар сарын 3-ны байдлаар нийт оюутны тоо: идэвхтэй сурч буй сонголт хийсэн бакалавр 10830, магистр 1011, доктор 117 оюутан суралцагчид байна. Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэн, нэгжүүд тус бүрийн 2019 оны санхүүгийн тайланг бүрэлдэхүүн нэгжийн захирлын зөвлөлийн хэлэлцүүлэн 5 дугаар сарын 18-ны өдөр, ШУТИС-ийн удирдах зөвлөлийн хурлаар 5 дугаар сарын 27-ны өдөр хэлэлцүүлсэн. ШУТИС-ийн 2019 оны санхүүгийн тайланг балансын бүтэц, орлогын үр дүн, зарлагын үр дүн, санхүүгийн тайлангийн аудитын үр дүн гэсэн бүтэцтэйгээр танилцуулж байна.

8.2 БАЛАНСЫН БҮТЭЦ

Балансын бүтцийг авч үзвэл нийт хөрөнгө 142,261.0 сая төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 1.26% буюу 1.8 тэрбум төгрөгөөр буурсан байна. Эргэлтийн хөрөнгө 21.1 хувийг, эргэлтийн бус хөрөнгө 78.9 хувийг эзэлж эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 8.8 хувиар буурсан байна. Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 8.0 хувь, эзний өмч 92.0 хувийг тус тус эзэлж эзний өмчийн дүн нийт хөрөнгөд эзлэх хувь өнгөрсөн оноос 0.9 хувиар буурчээ.

Эргэлтийн хөрөнгө мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материалаас бүрдэж байна. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 9.7 тэрбум төгрөгөөр, авлага 3.1 тэрбум төгрөгөөр, урьдчилж гарсан зардал 114.4 сая төгрөгөөр буурсан дүнтэй гарсан байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 17.3% буюу 9.7 тэрбум төгрөгөөр буурч, авлага 52.4% буюу 3.1 тэрбум төгрөгөөр, урьдчилж гарсан зардал 14.9% буюу 114.36 сая төгрөгөөр буурсан байна.

Балансын бүтцийн харьцуулалт
 /сая төгрөгөөр/

Хүснэгт 8.1

д/д	Балансын зүйл	2018 он		2019 он		Өөрчлөлт	
		дүн	хувь	дүн	хувь	абсолют	хувь
1	Мөнгө ба түүнтэй адил хөрөнгө	34,413.10	23.9	24,656.96	17.3	- 9,756.14	28.35
2	Авлага	6,015.22	4.2	2,864.31	2.0	- 3,150.91	52.38
3	Бараа материал	1,898.37	1.3	1,900.06	1.3	1.69	0.09
4	Урьдчилж гарсан зардал	765.55	0.5	651.19	0.5	- 114.36	14.94
	Эргэлтийн хөрөнгийн дүн	43,092.2	29.9	30,072.52	21.1	13,019.72	30.21
1	Биет хөрөнгө	93,435.00	64.8	104,671.49	73.6	11,236.49	12.03
2	Биет бус хөрөнгө	7,552.72	5.2	7,516.99	5.3	- 35.73	-0.47
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	100,987.72	70.1	112,188.48	78.9	11,200.76	11.09
	Нийт хөрөнгийн дүн	144,079.96	100.0	142,261.00	100.0	- 1,818.96	-1.26
1	Богино хугацаат өр төлбөр	10,206.11	7.1	11,307.11	7.9	1,101.00	10.79
2	Урт хугацаат өр төлбөр	67.10	0.05	61.41	0.0	- 5.69	-8.48
	Өр төлбөрийн дүн	10,273.21	7.1	11,368.52	8.0	1,095.31	10.66
1	Засгийн газрын сан	30,748.33	21.3	30,748.33	21.6	0.00	0.00
2	Хуримтлагдсан үр дүн	41,942.63	29.1	39,033.80	27.4	- 2,908.83	-6.94
3	Хөрөнгө дахин үнэлгээний зөрүү	61,115.80	42.4	61,110.36	43.0	- 5.44	-0.01
	Эзний өмчийн дүн	133,806.76	92.9	130,892.48	92.0	- 2,914.28	-2.18
	Өр төлбөр ба эзний өмч	144,079.97	100.0	142,261.00	100.0	- 1,818.97	-1.26

ШУТИС-ийн сургуулийн бүрэлдэхүүний 10 сургууль, 1 институт, Ахлах сургууль, Коосэн технологийн коллеж, Захиргаа, Эрдэм шинжилгээ инновацийн газар, ОМССХүрээлэн, ШУТТНомын сан, ОУДБСТөв, Нээлттэй боловсролын төв, Эрдэмнэт сүлжээний төв, Хэвлэлийн газар, 2 Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг нийт 23 нэгжийн санхүүгийн тайланг нэгтгэгддэг байна. ШУТИС-ийн бүрэлдэхүүн ШУТИС-ийн харьяа Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэнгийн орлого, зардлын төлөвлөгөө нь ШУТИС-ийн Удирдах зөвлөлөөр батлуулдаг боловч санхүүгийн тайланг Шинжлэх ухаан технологийн санд нэгтгэдэг байна. Эрдэмнэт сүлжээний төвийн төлөвлөгөөг БСШУЯамнаас томилогдсон Удирдах зөвлөлөөс төсвийг баталж, санхүүгийн тайланг ШУТИС-ийн санхүүд нэгтгүүлдэг байна.

ШУТИС-ийн ректорын 2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар Барилга, архитектурын сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Дарханы технологийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Механик, тээврийн сургууль, Үйлдвэрлэлийн

технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Эрчим хүчний сургууль, Гадаад хэлний сургууль, Е нээлттэй институт, Олон улсын дээд боловсрол судлалын төвийн Голомт, ХААН, Улаанбаатар хотын банкнууд дахь харилцах данснуудын 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хуримтлагдсан үлдэгдлийг ШУТИС-ийн Төвийн харилцах дансанд төвлөрүүлэхээр

А/02 дугаар тушаалаар бүрэлдэхүүн сургуулиудын банкин дахь харилцах дансны нэг, хоёрдугаар гарын үсгийг холбогдох бүрэлдэхүүн сургуулиудын захирал, ахлах нягтлан бодогч нараар тус тус зуруулж байхаар даалгасан байна. Мөн ШУТИС-ийн төв нэгжид ХААН болон Улаанбаатар банканд хөрөнгө оруулалт санхүүжилтийн зориулалтаар тус бүр нэг данс, Улаанбаатар банканд урсгал санхүүжилтийн зориулалтаар харилцах данс, бүрэлдэхүүн нэгжүүдийн хувьд Голомт банканд Геологи, уул уурхайн сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Эрчим хүчний сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Гадаад хэлний сургууль, Е нээлттэй институт, Дарханы технологийн сургуулиудад, Хаан банканд Барилга, архитектурын сургууль, Олон улсын дээд боловсрол судлалын төвд, Улаанбаатар хотын банканд Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Механик, тээврийн сургуулиудад зарлагын зориулалтаар шинээр харилцах данс нээхийг,


А/03 дугаар тушаалаар бүрэлдэхүүн нэгжүүдийн идэвхгүй, ашиглагдахгүй байгаа Голомт банкны Барилга, архитектурын сургуулийн 8115007019 тоот, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн долларын 1105024233 тоот, Худалдаа хөгжлийн банкны Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн 453025010 тоот, ХААН банкны Дарханы технологийн сургуулийн 5046194723 тоот данснудыг 01 дүгээр сарын 02-ны өдрөөр хааж ШУТИС-ийн Төвийн голомт дахь урсгал санхүүжилтийн 1102928165 тоот дансанд шилжүүлэхээр тус тус тушаал гарсан.

ШУТИС-ийн ректорын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн **А/11** дүгээр тушаалаар докторантур, магистрантурын түвшний сургалтын суурь шинжлэх ухааны хичээлүүд болон диссертаци, магистрын гадаад хэлний нэгдсэн шалгалт, докторантын мэргэжлийн нэгдсэн шалгалт, дээд боловсролын диплом шинэчлэн солих, нөхөн олгох, кредит дүйцүүлэн тооцох төлбөрүүдийг ШУТИС-ийн Захиргааны ХААН банкин дахь 5431012534 дансанд төвлөрүүлэхээр болсон байна.

Монгол улсын Засгийн газрын 2018 оны “Журам шинэчлэн батлах, дүрэмд өөрчлөлт оруулах тухай” 46 дугаар тогтоолын хавсралт болох “Дээд боловсролын сургалтын байгууллагын оюутан, суралцагчид оюутны хөгжлийн зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Сургууль зээлийн 5 хувьтай тэнцэх хэмжээгээр Зээлийн эрсдэлийн сан бүрдүүлж, зээлийн гэрээний гүйцэтгэлийг дүгнэх” гэсний дагуу эрсдэлийн сан бүрдүүлсэн байна.

ШУТИС-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлаар нийт хөрөнгийн болон өр төлбөрийн дүн өмнөх оноос 1,818.9 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх үзүүлэлттэй харьцуулахад мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөр, хуримтлагдсан үр дүнд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

-Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан шалтгаан нь оюутны тоо буурсан, хичээлийн 8 байр ашиглалтад орсонтой холбоотой байна.



Зураг 8.1. ШУТИС-ийн 2019 оны балансын бүтэц

- Нийт авлага 2019 онд 2,864.3 сая төгрөг болж, 2018 оноос 3,150.9 сая төгрөгөөр буюу 52.4 хувиар буурсан байна. Үндэсний аудитын газраас БСШУССайдад 2019 оны 689 дугаартай албан бичгээр “Төрийн өмчит 11 сургуулийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд туссан тогтмол зардлын өрийг тус яамны Дотоод аудитын нэгжээр хянуулан шийдвэрлэх”-ээр зөвлөсөн байна. Энэ хүрээнд БСШУСЯамны Дотоод аудитын хорооны 2019 оны 03 дугаар тогтоол гарч төрийн өмчит их дээд сургуулиудын тогтмол зардлын өр, авлагыг нягтлан бодох бүртгэлийн алдаагүй залруулга, бичилт хийхийг сургуулийн Удирдах зөвлөлд зөвшөөрсөн тул 2018 оны тайлан балансад бүртгэлтэй байгаа тогтмол зардлын өр, авлагыг сургуулийн өмч хамгаалах комиссоор хэлэлцүүлж удирдах зөвлөлөөр шийдвэрлүүл гэсэн 2019 оны 11/8682 тоот албан тоот албан бичиг БСШУСЯамнаас ирсэн байна. Үүний дагуу Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай холбогдох тогтмол зардлын 2,639.1 сая төгрөгийн найдваргүй авлагыг Удирдах Зөвлөлийн 2020 оны 01-р сарын 10-ны өдрийн 03 тоот тогтоолоор данс бүртгэлээс хассан.

2018 оны сургалтын төлбөрийн авлагын 42.9 хувь буюу 1,000.5 сая төгрөг нь бакалаврын, 36.8 хувь буюу 859.9 сая төгрөг нь магистрын, 9.3 хувь буюу 217.7 сая төгрөг нь докторын, 11.0 хувь буюу 255.7 сая төгрөг нь ахлах сургуулийн сургалтын төлбөрийн авлага байна. Сургалтын төлбөрийн авлага 2019 оны эцэст 2,247.0 сая төгрөг болж өнгөрсөн оноос 86.8 сая төгрөг буюу 3.7 хувиар буурсан байна. Магистрын сургалтын төлбөр 20.5 сая төгрөгөөр нэмэгдэж, бусад төлбөрийн авлага 17.7-52.4 сая төгрөгөөр буурчээ.

2019 оны сургалтын төлбөрийн авлагын 42.9 хувь буюу 963.3 сая төгрөг нь 2083 оюутантай холбоотой бакалаврын, 39.2 хувь буюу 880.5 сая төгрөг нь 860 оюутантай холбоотой магистрын, 7.4 хувь буюу 165.2 сая төгрөг нь 152 оюутантай холбоотой докторын, 10.5 хувь буюу 237.9 сая төгрөг нь 204 суралцагчтай холбоотой ахлах сургуулийн сургалтын төлбөрийн авлага байна. Сургалтын төлбөрийн авлагын 50.6

хувь буюу 1,136.0 сая төгрөг нь 3-аас дээш жилийн насжилттай бөгөөд үүнээс 483.5 сая төгрөгийн авлага нь найдваргүй авлагад тооцогдож байна.

**Сургалтын төлбөрийн авлага
(бүрэлдэхүүн сургуулиар)
/мянган төгрөгөөр/**

Хүснэгт 8.2

Сургууль, нэгжийн нэр	2018 он	2019 он	Өссөн (+) буурсан (-)	Эзлэх хувь /2019 /
Барилга, архитектурын сургууль	271,615.3	234,727.5	(36,887.8)	10.4
Бизнесийн ахисан түвшний сургууль	0.0	439,166.9	439,166.9	19.5
Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	515,365.1	128,696.5	(386,668.6)	5.7
Геологи, уул уурхайн сургууль	487,804.9	378,472.6	(109,332.4)	16.8
Гадаад хэлний сургууль	28,521.9	14,820.9	(13,701.1)	0.7
Дархан-Уул аймаг дахь Технологийн сургууль	197,474.6	265,442.7	67,968.2	11.8
Механик тээврийн сургууль	68,123.2	72,759.8	4,636.6	3.2
Мэдээлэл холбооны технологийн сургууль	122,315.4	141,954.0	19,638.5	6.3
Үйлдвэрлэлийн технологийн сургууль	82,327.6	77,314.7	(5,013.0)	3.4
Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	14,636.8	12,628.3	(2,008.5)	0.6
Эрчим хүчний сургууль	153,483.4	143,589.8	(9,893.7)	6.4
Е-Нээлттэй институт	12,942.4	0.0	(12,942.4)	0.0
“ШУТИС-Коосэн” технологийн коллеж	122,374.8	84,964.8	(37,410.0)	3.8
ШУТИС-Ахлах сургууль	122,745.4	130,960.4	8,215.0	5.8
Нээлттэй боловсролын төв	0.0	121,574.1	121,574.1	5.4
Олон улсын дээд боловсрол судлалын төв	134,218.8	0.0	(134,218.8)	0.0
Нийт дүн	2,333,949.7	2,247,072.8	(86,876.8)	100.0

-Үндсэн хөрөнгийн их хэмжээгээр өөрчлөгдсөн нь “Дээд боловсрол шинэчлэл”, “Инженер, технологийн дээд боловсрол” төслүүд, хамтран ажилладаг Японы Нагоя их сургууль, БНСУ-ын Санмён их сургууль зэрэг байгууллагуудаас хандив тусламжаар сургалтын орчныг сайжруулах лабораторийн тоног төхөөрөмж орж ирсэнтэй холбоотой байна.

- Урт хугацаат өр төлбөр болон нэг жилийн хугацаанд богино хугацаанд бусад өр төлбөрт 2010 оны 11 сарын 11-ний өдрийн ТӨХ-ны 436 тоот тогтоолоор балансаас балансад шилжүүлсэн “Улаанбаатар Дулааны Сүлжээ” ХК-ийн зээлийн хөрөнгөөр бэлтгэсэн халаалтын цогц төхөөрөмжүүдийн төлбөр болох урт хугацаат зээлийн үлдэгдэл (61.4 сая төгрөг) байна.

-Богино хугацаат өр төлбөр 1,205.6 сая төгрөгөөр өссөн нь шинээр ашиглалтад орсон “Хичээлийн 8-р байр”-ны гүйцэтгэлийн баталгаа /5%/-тай холбоотой 445.2 сая төгрөгийн өглөг, 2018 оноос төсөл гэрээт ажлын орлогыг аккурал сууриар бүртгэж

эхэлсэнтэй холбоотойгоор урьдчилж орсон орлого 2,003.1 сая төгрөгийг орлого хүлээн зөвшөөрснөөс хамааралтай ба сургалтын төлбөрийн урьдчилж орсон орлого 1,528.9 сая төгрөгөөр буурсан байна.

Хуримтлагдсан үр дүн буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдэл, авлага, түр сургалт, төсөл, гэрээт ажлын урьдчилж орсон орлогын залруулга, өмнөх жилүүдэд ашиглалтад тавьж олгосон бараа материалын зардал зэрэг нийт 1,768.8 сая төгрөгийг бүртгэсэн байна. БСШУСЯамнаас авах тогтмол зардлын санхүүжилтийн 2,639.1 сая төгрөгийн авлагыг Удирдах зөвлөлийн 2020 оны 03 тоот тогтоолоор найдваргүй авлагын зардлаар бүртгэсэнтэй холбоотой байна.

8.3 ОРЛОГО ҮР ДҮН

ШУТИС-ийн орлого нь татаас, санхүүжилтийн орлого, бараа үйлчилгээний орлого гэж ангилагддаг. Орлогын дүнг төсвийн гүйцэтгэлийн (СТ-5А) тайлангаас авч, тайлант онд үүссэн дүнг төсөв болон гүйцэтгэлтэй харьцуулан тооцсон.

Оны төсөв болон гүйцэтгэл /мянган. төгрөгөөр/

Хүснэгт 8.3

Д/Д	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Татаас, санхүүжилтийн орлого	2,545,143.10	575,647.81	1,969,495.29	22.6
	Улсын төсвөөс	1,976,138.90	0.00	1,976,138.90	0.0
	Орон нутгийн төсвөөс	98,023.00	129,249.50	-31,226.50	131.9
	Бусад төсөвт байгууллагаас	337,860.70	358,549.71	-20,689.01	106.1
	Бусад тусгай зориулалтын сангаас	133,120.50	87,848.60	45,271.90	66.0
2	Бараа үйлчилгээний орлого	43,704,381.00	48,599,291.16	-4,894,910.15	111.2
	Өмчийн орлого	109,794.00	1,784,526.40	-1,674,732.40	1,625.3
	Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	43,594,587.00	46,814,764.75	-3,220,177.75	107.4
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	46,249,524.10	49,174,938.9	-2,925,414.86	106.3

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 14 дүгээр тогтоолоор 2019 оны үйл ажиллагааны орлогыг 63,817.4 сая төгрөгөөр, зарлагыг 63,127.8 сая төгрөгөөр, үүнээс хөрөнгө оруулалт, барилга, тоног төхөөрөмж, урсгал засвар, тавилга эд хогшлыг 9,043.8 сая төгрөгөөр баталсныг, 2019 оны 12 дугаар тогтоолоор 2019 оны үйл ажиллагааны зарлагын төсвийн хөрөнгө оруулалтын зардлын лаборатори, тоног төхөөрөмжийн зардлын зүйлийг 589.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж хөрөнгө оруулалтыг 9,632.8 сая төгрөгөөр баталсан байна.

Шинжлэх ухаан, технологийн их сургууль 2019 онд 63,817.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 57,817.9 сая төгрөгийн орлогыг тус тус олсон байна. Тус сургууль 2019 оны 57,817.9 сая төгрөгийн орлогоос 67.3 хувь буюу 38,916.1 сая төгрөг нь үндсэн үйл ажиллагааны орлого, 7.8 хувь буюу 4,518.8 сая төгрөг нь эрдэм шинжилгээний орлого, 8.6 хувь буюу 4,983.0 сая төгрөг нь туслах үйл ажиллагааны орлого, 16.3 хувь буюу 9,399.9 сая төгрөг нь төсвийн санхүүжилт тус тус эзэлж байна. Орлогын үзүүлэлтүүдийг үндсэн үйл ажиллагааны төрөл ангиллаар харуулбал:

Орлогын үзүүлэлтүүд /мянган. төгрөгөөр/


Хүснэгт 8.4

д/д	Үзүүлэлт	2019 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү /+, -/ Хувь
1	Үндсэн үйл ажиллагааны орлого	36,273,307.6	38,916,096.1	2,642,788.5 107%
	Боловсролын зээлийн сан		970,223.6	970,223.6
	Сургалтын төлбөрийн орлого	35,348,307.6	37,224,961.6	1,876,654.0 105%
	Бакалаврын сургалтын төлбөр	30,439,261.1	32,460,607.2	2,021,346.1 107%
	Магистрын сургалтын төлбөр	3,175,922.5	3,019,854.9	-156,067.6 95%
	Докторын сургалтын төлбөр	440,794.0	474,125.7	33,331.7 108%
	Бусад /МСҮТ, Ахлах сургууль/	1,292,330.0	1,270,373.8	-21,956.2 98%
	Түр сургалтын орлого	925,000.0	720,910.9	-204,089.1 78%
2	Эрдэм шинжилгээ орлого	3,774,436.6	4,518,835.7	744,399.1 120%
3	Туслах үйл ажиллагааны орлого	2,666,827.4	4,983,035.3	2,316,207.9 187%
4	Санхүүжилтийн орлого /хандив/	3,745,143.1	9,399,913.7	5,654,770.6 251%

Шилжих үлдэгдэл: Хөгжлийн бодлого, төлөвлөлт газраас шилжих үлдэгдлийг “ШУТИС тухайн жилд олж байгаа орлого нь үйл ажиллагаагаа бүрэн санхүүжүүлж хүрэхгүй байгаагаас шалтгаалан тухайн оны төсөвт шилжих үлдэгдлийг тооцож төсөвлөдөг. Шилжих үлдэгдлийг тооцохдоо жилийн эцсээр үлдэх мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс урьдчилж орсон орлогыг хасаж төсөвлөдөг” хэмээн тайлбарласан.

ШУТИСургуулийн харьяа нэгжүүд болох Геологи, уул уурхайн сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик, тээврийн сургууль, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Эрчим хүчний сургууль, Олон улсын дээд боловсролын судлалын төв, Коосен технологийн коллеж, Эрдэмнэт 2018 онд 34.3-3,357.1 сая төгрөгөөр, 2019 онд Барилга, архитектурын сургууль, Бизнесийн ахисан түвшний сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик, тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Эрчим хүчний сургууль, Гадаад хэлний сургууль, Олон улсын дээд боловсролын судлалын төв, Хэвлэх газар, Захиргаа, Эрдэмнэт 16.1-5,170.9 сая төгрөгөөр орлогыг давуулан биелүүлсэн байна (Зураг 8.2).

ШУТИС-ийн үндсэн үйл ажиллагааны орлогод бакалавр, магистр, доктор, ахлах сургууль болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, Коосэн Технологийн коллежийн сургалтын төлбөр, түр сургалтын орлогоос бүрдэж байна. 2019 онд 38,916.1 сая төгрөг болж 7.5 хувь буюу 2,642.8 сая төгрөгөөр давж биелжээ. Үндсэн үйл ажиллагааны орлогын 82.9-83.4 хувийг бакалаврын сургалтын төлбөрийн орлого, 8.1-7.8 хувийг магистрын сургалтын төлбөрийн орлого, 1.0-1.2 хувийг докторын сургалтын төлбөрийн орлого, 2.8-3.3 хувийг ахлах сургууль болон МСҮТ, Коосэн Технологийн коллежийн сургалтын төлбөрийн орлого, 3.0-2.5 хувийг Боловсролын зээлийн сангийн санхүүжилт, 2.2-1.8 хувийг түр сургалтын орлого бүрдүүлж байна.



Зураг 8.2. ШУТИС-ийн 2019 оны бүрэлдэхүүн нэгжийн орлогын төсөв, гүйцэтгэл

Сургалтын төлбөрийн орлого: 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 08 дугаар тогтоолоор 2019-2020 онд элсэн суралцагчид 12.5-21.2 хувь, 2018-2019 он, 2018 оноос өмнө элсэн суралцагчдын сургалтын төлбөрийг 10 хувиар тус тус нэмэгдүүлэх шийдвэр гарсан байна.

Нэг кредитийн үнэлгээ
/төгрөгөөр/

Хүснэгт 8.5

д/д	Бүрэлдэхүүн сургуулийн нэрс	УЗ-ийн 2019 оны №08 тогтоолоор 2017-2018 оны хичээлийн жил		
		2019-2020 оны хичээлийн жилд элсэгч	2018-2019 оны хичээлийн жилд элссэн	2018 оноос өмнө элссэн
1	Барилга архитектурын сургууль	90800	82390	80300
2	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	88800	86790	84590
3	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	90800	82390	80300
4	Геологи, уул уурхайн сургууль	90800	82390	80300
5	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	90800	86790	84590
6	Эрчим хүчний сургууль	90800	84370	82170
7	Механик тээврийн сургууль	90800	82390	80300
8	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	79300	75790	73920
9	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	79300	74360	72490
10	Гадаад хэлний сургууль	79300	72160	70400
Бакалаврын сургалтын дундаж үнэлгээ		82042		

Магистрантурын сургалт	Кредитийн үнэлгээг 1.4 дахин нэмэх
Докторантурын сургалт	Кредитийн үнэлгээг 1.9 дахин нэмэх
ШУТИС-д хэрэгжүүлж байгаа гадаадын их, дээд сургуулиудтай хамтарсан хөтөлбөрийн гадаад хэлээр заагдаж байгаа хичээл	Бакалаврын сургалтын нэг кредитийн үнэлгээг 2.0 дахин нэмэгдүүлэх
Ахлах сургууль, Коосэн технологийн коллеж	3.0 сая төгрөг
Дархан-Уул аймаг дахь лицей сургууль	1.2 сая төгрөг
Цагийн сургалтаар элсэн суралцаж байгаа	Кредитийн үнэлгээг 1.2 дахин нэмэх

Оюутны тоо буурсан боловч сургалтын төлбөрийн орлого 2019 онд 38,195.2 сая төгрөгийн орлого орж сургалтын төлбөрийн орлого 2019 онд 1,118.6 сая төгрөгөөр өссөн байна. Бүрэлдэхүүн сургуулиудын сургалтын төлбөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Сургалтын төлбөрийн орлого

/мянган төгрөгөөр/

Хүснэгт 8.6

№	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2019 оны сургалтын орлого		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү / илүү /-, дутуу/ + /
1	Барилга, архитектурын сургууль	5,252,929.3	6,012,065.8	-759,136.5
2	Бизнесийн ахисан түвшний сургууль	1,109,189.7	1,100,481.7	8,708.0
3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	2,863,440.0	3,043,649.4	-180,209.4
4	Геологи, уул уурхайн сургууль	4,738,420.4	4,123,806.8	614,613.6
5	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	2,573,609.6	3,012,715.2	-439,105.6
6	Механик, тээврийн сургууль	3,490,846.8	4,102,196.6	-611,349.7
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	4,099,676.4	4,330,796.8	-231,120.4
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	4,140,478.0	4,011,808.4	128,669.6
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	672,820.5	967,450.5	-294,630.0
10	Эрчим хүчний сургууль	4,881,664.9	5,915,667.6	-1,034,002.7
11	Е-нээлтэй институт	21,254.4	98,912.2	-77,657.8
12	Нээлтэй боловсролын төв	58,675.8	476,979.2	-418,303.4
13	Гадаад хэлний сургууль	470,301.8	482,155.0	-11,853.2
14	Ахлах сургууль	450,000.0	516,500.0	-66,500.0
15	Коосен технологийн коллеж	525,000.0	0.0	525,000.0
16	Олон улсын дээд боловсролын судлалын төв		0.0	0.0
Сургалтын орлогын дүн		35,348,307.6	38,195,185.2	-2,846,877.6

Түр сургалтын орлого: Түр сургалтын орлого 2019 онд 204.1 сая төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй гарчээ. Түр сургалтын орлогод зөвлөх инженер, мэргэжил

дээшлүүлэх болон курс дамжааны богино хугацааны сургалтын төлбөр хамаардаг байна.

Сургалтын төрийн сангийн талаар: Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт болох “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид суралцагчийн тэтгэлэг олгох журам”-ын 4.1-ийн дагуу 2019 онд 516 оюутанд буцалтгүй тусламжийг олгосон байна. Үүнээс 2019 онд 2 оюутан нийт 25 оюутанд УИХ-ын гишүүд, Боловсролын зээлийн сангийн даргын цохолтоор буцалтгүй тусламжид оруулсан байна.

Эрдэм шинжилгээний орлого. Эрдэм шинжилгээний орлого 2019 онд 19.7 хувь буюу 744.4 сая төгрөгөөр давж биелсэн байна. Эрдэм шинжилгээний орлогын гүйцэтгэл нэмэгдэхэд БСШУСЯ-ны “Дээд боловсролын шинэчлэл” төслийн хүрээнд гадаад төслийн санхүүжилтийн эх үүсвэртэй бүрэлдэхүүн сургуулиуд хөрөнгөөр болон мөнгөн хөрөнгөөр олгосон 1.4 тэрбум төгрөгийн эрдэм шинжилгээний орлогууд бүртгэгдсэн байна.

Тайлант онд ШУТСангаас 2019 онд 637.7 сая төгрөгийн гэрээт ажил хийж гүйцэтгэсэн байна. Мөн БСШУСЯ-нд хэрэгжиж буй Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Дээд боловсролын шинэчлэл төслөөс 2019 онд 399.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, урсгал засварын ажлыг хийж эрдэм шинжилгээний орлогыг нэмэгдүүлсэн байна.

Туслах үйл ажиллагааны орлого. Туслах үйл ажиллагааны орлогод оюутны байр, түрээсийн, хүүгийн, оюутны үйлчилгээний, үйлдвэрлэл үйлчилгээний болон бусад орлого ордог байна.

Оюутны байрны орлого: Оюутны байрны орлого 2019 онд 88.0 сая төгрөгөөр давж биелсэн байна. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2019 оны 09 тоот тогтоолоор оюутны байрны төлбөрийг тогтоосон байна. Удирдах зөвлөлийн 2019 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 09 тоот тогтоолоор оюутны байрны төлбөрийг 10.0 мянган төгрөгөөр нэмж тогтоосон байна.

Түрээсийн орлого: ШУТИС-д 20 гаруй аж ахуйн нэгж, хувь хүнд 1221 м.кв талбайг цайны газар, хүнс болон бичиг хэргийн дэлгүүр, хэвлэх олшруулах үйлчилгээ, банк, АТМ, ундааны машин, антен зэргийг түрээслүүлдэг байна. Түрээсийн орлого 2019 онд 1.9 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Түрээсийн орлого буурсан гол шалтгаан нь цайны газрын талбай том байдгаас түрээсийн төлбөрөө төлж чадаагүйтэй холбоотой байна.

Хүүгийн орлого: ШУТИС-ийн захиргаанаас Хаан банк, Голомт банк, Улаанбаатар хотын банктай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажилладаг байна. ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоолоор ШУТИС-ийг хөгжүүлэх бодлогын хүрээнд батлагдсан төсөв, төлөвлөгөөний дагуу төвлөрсөн дансанд байрлах дансны хүүгийн орлого болон хөрөнгө оруулалтын зориулалттай байршиж буй мөнгөн төгрөгийг богино хугацааны байгууллагын хадгаламж хэлбэрээр банканд байршуулж хөрөнгө оруулалтын зориулалтаар санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэхийг зөвшөөрсөн байна.

Үйлдвэрлэл үйлчилгээний орлого: Үйлдвэр үйлчилгээний орлогод Үйлдвэрлэл технологийн сургуулийн Милл пласын цайны газрын орлого, Эрдэмнэт төвийн интернэтийн үйлчилгээний орлого, Хэвлэлийн газар, Олон улсын дээд боловсрол судлалын төвийн хурлын өрөөний төлбөр, анги танхим тохижилт, багшийн эрхийн сургалт, Тоёото сангийн сургалтын тэтгэлэг, Эрдэм шинжилгээ инновацийн газрын эрдэм шинжилгээний сэтгүүл, эмхэтгэлийн орлого, зуны сургалт болон оюутны карт хэвлэх, оюутны сонголтын төлбөр зэрэг орлогууд ордог байна.

Бусад орлого: Бүрэлдэхүүн сургуулийн хурлын заалны төлбөр, ромбын төлбөр, багш нарын хичээл таслалт, Горхийн полигоны айлуудаас орсон төлбөр, түрээсийн гэрээтэй газруудын цахилгааны төлбөр гэх мэт орлогууд орж байна.

Тогтмол зардлын санхүүжилт: Тус сургуульд 2019 онд Мэргэжлийн сургууль үйлдвэрлэлийн төвийн санхүүжилт 358.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс Дарханы технологийн сургууль, Ахлах сургуулийн лицей сургалтад 129.2 сая төгрөг, Дээд боловсролын шинэчлэл, инженер техникийн дээд боловсрол төслөөс 503.4 сая төгрөг, Шинжлэх ухаан технологийн сангаас 648.6 сая төгрөг, Боловсролын зээлийн сангаас оюутны унааны зардалд 87.8 сая төгрөг, буцалтгүй тусламж, гадаад оюутны сургалтын төлбөр, тэтгэлэгт 970.2 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна.

ШУТИС-д 2016 онд 667.0 сая төгрөг, 2017 онд 930.0 сая төгрөг, 2018 онд 1,041.0 сая төгрөг нийт 2,639 сая төгрөгийн гэрэл, цахилгаан, дулаан, халаалт, цэвэр, бохир усны зардал гарсан хэдий ч төлөгдөөгүй авлагаар бүртгэгдсэн байна. Төсвөөс санхүүжигдэх орлого нь 2018 онд төлөвлөснөөс 2.3 дахин 3.8 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь 2018 оны 12 сарын 27-нд Япон улсын төслийн бус буцалтгүй тусламжаар Коосен ТК-д 3.1 тэрбум төгрөгийн лабораторийн тоног төхөөрөмжийн хандивласан хөрөнгийн эх үүсвэрийг тусламжийн орлогоор бүртгэсэнтэй холбоотой юм.

8.4 ЗАРЛАГА ҮР ДҮН

ШУТИС нь 2019 онд 58,931.1 сая төгрөгийг тус тус зарцуулж, батлагдсан төлөвлөгөөт зардлыг 4,033.9 сая төгрөгөөр хэмнэлттэй зарцуулсан байна.

Зардлын гүйцэтгэлийг авч үзэхэд: 2019 онд 59.7 хувийг цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, 26.7 хувийг бараа, ажил үйлчилгээний урсгал зардал, 13.6 хувийг хөрөнгө оруулалтын зардал тус тус эзэлж байна. Нийт зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал

Нийт зардал /мянган төгрөгөөр/

Хүснэгт 8.7

Үзүүлэлт	2019 он		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/хэмнэлт /+, хэтрэлт -/ /
Ажиллагчидтай холбогдсон зардал	35,821,242.5	35,169,750.7	651,491.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал	31,822,283.4	31,243,638.1	578,645.3
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	3,998,959.1	3,926,112.6	72,846.5
Бараа, ажил үйлчилгээний урсгал зардал	17,510,899.1	15,758,122.9	1,752,776.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,846,066.5	1,404,890.9	441,175.6
Гэрэл цахилгааны зардал	895,197.5	653,124.6	242,072.9
Түлш, халаалтын зардал	650,843.7	509,667.9	141,175.8
Цэвэр бохир усны зардал	300,025.3	242,098.4	57,926.9
Хангамж бараа материалын зардал	833,040.1	679,830.4	153,209.7
Бичиг хэргийн зардал	58,469.5	45,961.5	12,508.0
Тээвэр шатахууны зардал	68,481.2	55,360.8	13,120.4

Шуудан, холбоо, интернэтийн зардал	33,877.0	22,035.6	11,841.4
Ном, хэвлэлийн зардал	481,988.4	385,523.1	96,465.3
Хог хаягдал зайлуулах хортой мэргэчдийг устгах, ариутгах	46,474.0	33,083.1	13,390.9
Бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	143,750.0	137,866.3	5,883.7
Норматив зардал	137,061.3	98,082.6	38,978.7
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	29,500.0	23,919.3	5,580.7
Хоол, хүнс	45,396.0	17,240.0	28,156.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	62,165.3	56,923.3	5,242.0
Эд хогшил, урсгал засварын зардал	1,648,154.0	1,560,017.2	88,136.8
Багаж, техник хэрэгсэл	6,500.0	5,944.0	556.0
Тавилга	231,500.0	208,208.4	23,291.6
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	50,954.0	32,063.1	18,890.9
Урсгал засвар	1,359,200.0	1,313,801.7	45,398.3
Томилолт, гадаад зочны зардал	433,676.8	342,535.8	91,141.0
Гадаад томилолтын зардал	227,250.8	189,775.4	37,475.4
Дотоод томилолтын зардал	70,886.0	34,877.5	36,008.5
Зочин, төлөөлөгч хүлээн авах	135,540.0	117,882.9	17,657.1
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,866,973.2	2,847,298.0	1,019,675.2
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	206,700.0	120,472.9	86,227.1
Мэдээлэл, сурталчилгааны зардал	160,860.0	140,762.3	20,097.7
Тээврийн хэрэгслийн оношилгоо, даатгал	16,386.9	11,055.5	5,331.4
Тээврийн хэрэгслийн татвар	6,000.0	5,385.5	614.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	5,110.7	8,228.1	(3,117.4)
Газрын төлбөр	10,479.0	10,394.3	84.7
Төлбөр хураамж бусад зардал	3,095,444.0	2,210,264.5	885,179.5
Өмгөөлөл, хуулийн зөвлөхийн үйлчилгээний хөлс	3,500.0	984.8	2,515.2
Мэдээлэл технологийн үйлчилгээ	63,528.6	34,753.3	28,775.3
Харуул хамгаалалтын зардал	298,964.0	304,996.8	(6,032.8)
Бараа үйлчилгээний бусад зардал	7,921,206.1	8,086,090.2	(164,884.1)
Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,023,288.6	1,671,587.5	351,701.1
Эрдэм, шинжилгээ судалгааны ажил	4,514,917.5	5,133,831.2	(618,913.7)
Инновацын үйл ажиллагаа	322,500.0	103,629.8	218,870.2
Үйлдвэрлэл, үйлчилгээний зардал	1,060,500.0	1,177,041.7	(116,541.7)
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	824,721.1	739,377.8	85,343.3
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	1,200.0	1,108.0	92.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	500,000.0	456,540.1	43,459.9

	Эмчилгээний төлбөр	40,000.0	39,707.8	292.2
	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	283,521.1	242,021.9	41,499.2
Өөрийн хөрөнгөөр хийсэн хөрөнгө оруулалт		9,632,800.0	8,003,209.7	1,629,590.3
	Барилга байгууламжийн хөрөнгө оруулалт	7,916,167.6	6,269,699.5	1,646,468.1
	Лаборатори, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт	1,655,632.4	1,685,117.0	(29,484.6)
	Тавилга эд хогшил, бусад хөрөнгө оруулалт	61,000.0	48,393.2	12,606.8
Нийт зардлын дүн		62,964,941.6	58,931,083.3	4,033,858.3

Зардлын зүйл ангиар авч үзэхэд: 2019 онд банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамжийн зардал 3.1 сая төгрөг, харуул, хамгаалалтын зардал 6.0 сая төгрөг, эрдэм, шинжилгээ судалгааны ажил 618.9 сая төгрөг, үйлдвэрлэл, үйлчилгээний зардал 116.5 сая төгрөг, лабораторийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын зардал 29.5 сая төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.

Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүдийн хувьд зардлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлснээр зардлаа нийт дүнгээр нь бууруулан ажилласан байна.

Зардлын төлөвлөгөө

/Мянган төгрөгөөр/

Хүснэгт 8.8

д/д	Бүрэлдэхүүн сургууль, нэгжүүд	2019 он		
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/хэмнэлт /+/, хэтрэлт -/ /
1	Барилга, архитектурын сургууль	5,813,279.0	6,700,770.6	-887,491.6
2	Бизнесийн ахисан түвшний сургууль	952,213.0	924,108.5	28,104.5
3	Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль	4,237,340.6	4,970,089.4	-732,748.8
4	Геологи, уул уурхайн сургууль	4,780,522.2	4,949,541.0	-169,018.8
5	Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль	3,198,268.7	3,500,958.3	-302,689.6
6	Механик, тээврийн сургууль	4,466,564.1	5,273,779.0	-807,214.9
7	Мэдээлэл, холбооны технологийн сургууль	4,458,935.4	4,840,136.2	-381,200.8
8	Үйлдвэрлэлийн технологийн сургууль	5,962,844.3	6,685,188.0	-722,343.7
9	Хэрэглээний шинжлэх ухааны сургууль	3,665,839.0	3,820,114.9	-154,275.9
10	Эрчим хүчний сургууль	4,613,125.6	4,307,071.7	306,053.9
11	Е-нээлтэй институт	95,156.0	125,455.4	-30,299.4
12	Нээлтэй боловсролын төв	1,001,804.1	695,097.5	306,706.6
13	Гадаад хэлний сургууль	2,570,653.5	2,499,509.0	71,144.5
14	Ахлах сургууль	591,886.5	577,711.7	14,174.8
15	Коосен технологийн коллеж	656,013.9	1,135,109.1	-479,095.2

16	Олон улсын дээд боловсролын судлалын төв	-108,020.7		-108,020.7
17	Ой мод сургалт судалгааны хүрээлэн	312,524.9	212,188.9	100,336.0
18	Хэвлэх газар	459,236.6	661,647.6	-202,411.0
19	Захиргаа	13,253,177.6	5,536,422.0	7,716,755.6
20	Эрдэм шинжилгээ инновацын газар	683,102.8	644,177.2	38,925.6
21	Эрдэмнэт	125,654.3	117,567.3	56,949.0
22	Төвлөрсөн	299,999.9	4,704.3	295,295.6
23	ШУТөв Номын сан	874,820.3	798,597.7	76,222.6
НИЙТ		62,964,941.6	58,931,083.3	4,033,858.3

Зардлыг нийт дүнгээрээ хэмнэлттэй зарцуулсан боловч 2019 онд Барилга, архитектурын сургууль, Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургууль, Геологи, уул уурхайн сургууль, Дархан-Уул аймаг дахь технологийн сургууль, Механик, тээврийн сургууль, Мэдээлэл, холбооны технологийн сургууль, Хэрэглээний шинжлэх ухааны сургууль, Е-нээлтэй институт, Коосен технологийн коллеж, Үйлдвэрлэлийн технологийн сургууль, Олон улсын дээд боловсролын судлалын төв, Хэвлэх 30.3-887.5 сая төгрөгөөр тус тус төсвийг хэтрүүлэн зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө 2019 онд 27,080.6 сая төгрөгөөр нэмэгдэж 9,530.5 сая төгрөгөөр тус тус хасагдаж, 2019 оны жилийн эцэст 147,726.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгийн өөрчлөлт

/мянган.төгрөг/

Хүснэгт 8.9

Үзүүлэлт	2019 он			
	Оны эхэнд	Нэмэгдсэн	Хасагдсан	Оны эцэст
Барилга байгууламж	76,720,254.8	9,839,936.0	877.8	86,559,313.0
Авто тээврийн хэрэгсэл	1,340,170.7	25,000.0	36,628.0	1,328,542.7
Машин, тоног төхөөрөмж	32,556,449.2	9,641,111.8	459,616.5	41,737,944.5
Тавилга хэрэгсэл	5,572,956.3	808,319.8	67,636.3	6,313,639.8
Түүх соёлын дурсгалт зүйлс	7,609.2	120,806.4	-	128,415.6
Номын фонд	2,323,119.3	119,335.3	109,943.8	2,332,510.8
Дуусаагүй барилга	2,818,202.4	6,396,025.3	8,847,828.6	366,399.1
Бусад үндсэн хөрөнгө	237,037.5	46,783.4	7,984.9	275,836.0
Программ хангамж	1,394,892.6	83,330.2	-	1,478,222.8
Бусад биет бус хөрөнгө	7,205,498.5	-	-	7,205,498.5
Дүн	130,176,190.5	27,080,648.2	9,530,515.9	147,726,322.8

Нэмэгдсэн хөрөнгийн талаар: 2019 оны эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 147,726.3 сая төгрөг болж өнгөрсөн оны мөн үеэс 13.5 хувиар нэмэгдсэн байна. Үндсэн хөрөнгийн нэмэгдсэн эх үүсвэрийг авч үзвэл:

- Үндсэн хөрөнгийг худалдан авсан – 9,227.1 сая төгрөг
- Үнэ төлбөргүй авсан – 7,611.3 сая төгрөг

- Бусад хэлбэрээр буюу данс хооронд -10,242.2 сая төгрөг байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө 27,080.6 сая төгрөгөөр нэмэгдсэн ба үүнд 9,227.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг өөрийн хөрөнгөөр, 7,611.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг гадаад зээл тусламжаар, аж ахуй нэгжээс, олон нийтийн байгууллагаас, бусад эх үүсвэрээс үнэ төлбөргүй, хандиваар бэлтгэж, 10,242.2 сая төгрөгийн данс хооронд, урьдчилгаанаас, балансаас балансад шилжүүлсэн байна.

2019 онд Боловсрол, соёл шинжлэх ухааны, спортын яам хэрэгжүүлж байгаа “Дээд боловсролын шинэчлэл”, “Инженер, технологийн дээд боловсрол” төслүүдийн санхүүжилтээр сургалтын орчныг сайжруулах лабораторийн тоног төхөөрөмж, мөн хамтын ажиллагаатай ажилладаг Япон улс Нагоя их сургууль, БНСУ-н Санмён их сургууль зэрэг байгууллагаас хандив тусламжаар нийт 7,611.3 сая төгрөгийн хөрөнгө авсан байна.

Оюутны байрууд, сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн албаны чиг үүрэг, орон тоонд өөрчлөлт орсонтой холбоотой Захирлын 2019 оны А-04, А-135, А-156, А-171, А-231, А-262 тоот тушаалаар бүрэлдэхүүн сургууль, нэгж хооронд 10,242.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Хасагдсан хөрөнгийн талаар: Тус сургууль 2019 онд үндсэн хөрөнгө 9,530.5 сая төгрөгөөр хасагдсан нь 651.0 сая төгрөгийн хөрөнгийг акталж устгасан, 8,879.5 сая төгрөгийн хөрөнгийг данс хооронд шилжүүлэн бүртгэсэн байна.

2019 онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 07-р сарын 08-ны өдрийн А-2/2252 албан тоотор 396 нэр төрлийн 301.0 сая төгрөг, 2019 оны 07-р сарын 22-ны өдрийн 302 тоот тогтоолоор 350.0 сая төгрөг нийт 651.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 2019 оны 82 дугаар тогтоолоор элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31.6 сая төгрөгийн Toyota Mark II, Nissan Xtrial маркийн 2 автомашиныг “Хөвсгөл АЗЗА” ТӨХК-д балансаас балансад шилжүүлсэн байна.

Хичээлийн 8-р байр: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 534 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар байгууллагын төсөвт батлагдсан 8,920.1 сая төгрөгт багтаан бараа, ажил үйлчилгээ олж авахыг зөвшөөрсөн байна. Уг тогтоолын 3 дугаар хавсралтаар барилга угсралтын ажлыг 8,364.9 сая төгрөг, гадна цахилгаан хангамжийн угсралтын ажлыг 226.2 сая төгрөг, гадна бохир, ус хангамжийн угсралтын ажлыг 66.7 сая төгрөг, гадна дулаан хангамж, дулааны зангилааны угсралтын ажлыг 262.4 сая төгрөг нийт бараа, ажил үйлчилгээний дээд хязгаарыг 8,920.1 сая төгрөгөөр баталсан. Тус сургуулийн захирлын 2018 оны А/15 тоот тушаалаар ШУТИС-ийн хичээлийн 8 дугаар байрны барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээний хороо байгуулагдан, үнэлгээний хорооны ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Монкон констракшн” ХХК шалгарсан байна. ШУТИС-ийн захирал, “Монкон констракшн” ХХК нар 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдөр “Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хичээлийн VIII байрыг барих барилгын ажлын” ШУТИС/201801017 дугаар гэрээг байгуулж Хичээлийн VIII байрны барилгыг 8,698.0 сая төгрөгт багтаан гүйцэтгэхээр сургалтын зориулалттай хичээлийн байрыг батлагдсан зургийн дагуу хавтан суурь, цугтамал болон блокон хана, цугтамал хучилттай зоорь, техникийн давхартай 12 давхар барилга, гадна дотор инженерийн шугам сүлжээний угсралтын ажлыг 2018 оны 05 дугаар сарын 14-ний өдөр эхэлж 2019 оны 08 дугаар сарын 31-ний өдөр ашиглалтад оруулахаар гэрээг байгуулсан байна.

2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан нэмэлт ШУТИС/201801017 тоот гэрээгээр хичээлийн 8 байрыг барих барилгын ажлын явцад барилгын материалын үнийн өсөлт огцом өөрчлөгдсөн тул нэмэлт 207.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж байгуулсан байна. Хичээлийн VIII байрны барилгын ажлыг 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлсэн бөгөөд ерөнхий гүйцэтгэгчээр “Монкон констракшн” ХХК, Зураг төсвийн ажлыг ШУТИС-ийн Барилга архитектурын сургуулийн Зураг төсөл судалгааны



төв, Техник хяналтыг ШУТИС-ийн БАС-ийн Реконстракшн төв, захиалагчаар ШУТИС-ийн хөрөнгө оруулалт, хангамжийн газар тус тус ажиллаж Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 2019/677 дугаартай дүгнэлтээр ашиглалтад оруулсан байна. Барилгын тухай хуулийн 14.3, 14.6-д заасны дагуу баталгааны хугацааг тогтоож гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 5 хувь буюу 434.9 сая төгрөгийг суутган авч үлдсэн байна. Энэ барилга ашиглалтад орсноор лабораторийн 53 (суудлын тоо 1620) танхим, багш нарын 18 (суудлын тоо 181) өрөө, хурлын 1 (суудлын тоо 170) танхим, уулзалтын 1 (суудлын тоо 20) өрөө, 190.5 м² үзэсгэлэнгийн талбай, 735 м² музей үзвэрийн талбай бүхий хүчин чадалтай сургалт судалгааны орчин үеийн эрдэм шинжилгээ, инновацын төвтэй болж байна. Уг барилга нь 33.0м*25.0м хэмжээтэй, 48.05 м² өндөртэй, 9799.66 м² талбайтай 12 давхар (-1 зоорьтой) төмөр бетон араг бүтээц хийцтэй байна.

Хичээлийн 8 байрны төсөв

/мянган төгрөгөөр/

Хүснэгт 8.10

Зардлын нэр	ТӨХ-ны 534 тоот тогтоол	Гэрээний нийт дүн	Гүйцэтгэл дүн		
			2018 он	2019 он	Нийт дүн
Барилга угсралтын зардлын дүн	8,364,858. 0	8,475,374.9	2,609,400.9	5,627,730.3	8,237,131. 2
Барилга угсралтын зардал					
НӨАТ / 742094042 /		8,176,392.2	2,609,400.9	5,479,311.5	8,088,712. 4
Нормчлолын сан / 13357694 /					
Захиалагчид олгох хөнгөлөлт		(200,000.0)			-
Бусад зардал / цахилгаан шат 4 ширхэг, зураг, төслийн үнэ, даатгал, ХАБЭА /		350,563.9			-
Баталгааны 5 хувь					-
Магадалшгүй ажлын зардал		148,418.8		148,418.8	148,418.8
Захиалагчийн албаны зардал		148,418.8	7,200.0	13,200.0	20,400.0
Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал		74,209.4	42,100.0	19,999.6	62,099.6
БАС- Пүрэв-Эрдэнэ			29,683.8	14,841.9	44,525.6
МОНАР ХХК-зураг			12,000.0		12,000.0
Техникийн болон барилгын ажлын зөвшөөрөл			416.2		416.2
Оргилт од ХХК Хичээлийн 8-р байрны гадна цахилгаан хангамжийн ажлын зураг				2,200.0	2,200.0

Өрхтэй өрөмт ХХК Хичээлийн 8-р байрны гадна холбооны ажлын зураг боловсруулах				1,000.0	1,000.0
Шилэн кабелийн холболт, угсралтын зардалд				1,957.8	1,957.8
Бусад зардлын дүн	555,284 .2	222,628.2	49,300.0	33,199.6	82,499.6
Нийт дүн	8,920,142. 2	8,772,212.5	2,700,800.9	5,680,929.6	8,381,730. 5

ШУТИС-ийн 60 жилийн ойн баяр: Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/840 дүгээр тушаалаар Шинжлэх ухаан технологийн их сургууль үүсэн байгуулагдсаны түүхт 60 жилийн ойг 2019 оны 10 дугаар сарын 25-31-ний өдрүүдэд гэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрсөн байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2018 оны А/211 дүгээр тушаалаар тус сургууль үүсэж байгуулагдсаны 60 жилийн ойн баярын арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө болон зардал төсвийг баталсан байна. Тус тушаалд ойг угтсан бэлтгэл ажлын төсвийг 520.3 сая төгрөг, ойн баярын арга хэмжээний төсвийг 384.2 сая төгрөгөөр тус тус баталснаас гүйцэтгэлээр 332.1 сая төгрөгийн зардал гарсан байна.

Ойн арга хэмжээний зардлын төсөв, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хүснэгт 8.11

№	Зохион байгуулах арга хэмжээ	Төсөв	Гүйцэтгэл	
			Гүйлгээний утга	Дүн
1	ШУТИС-ийн хэвлэмэл танилцуулга, богино хэмжээний кино, нэвтрүүлэг шторк зэргийг монгол, англи хэлээр шинэчлэн гаргах зардал	25,000.0	МҮОНРТелевиз Элсэн цаг нэвтрүүлгийн бооцоо,	3,000.0
			Медиаболовсрол суваг ХХК 2019.10.8 Мөнгөтэй зочин нэвтрүүлэг	1,500.0
2	ШУТИС-ийн түүхэн үйл явдал, үйл ажиллагааны талаар сурталчлах хэвлэл мэдээллийн зардал	35,000.0	Ж.Эрдэнэцэцэг ШУТИС 60 жил ойн баярын мэндчилгээ хэвлэлтийн редакцын хөлс	35.0
			Ийгл Бродкастинг ХХК ШУТИС 60 жил ойн их сургуулиудын олон улсын форум мэдээ,	10,550.0
			Масс Ти Ви ХХК Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах үеэр мэдээний зардалд	350.0

			Эн-Ти-Ви Броадкастинг ХХК 8 н удаагийн мэдээ, шторк	3,870.0
			Монцамэ агентлаг 60 жил ойн их сургуулиудын олон улсын форум мэдээ,	1,040.0
3	ШУТИС-ийн ойд зориулсан хөгжлийн түүхэн замналын цуврал ботиудыг хэвлүүлэх зардал	30,000.0	Түүхэн замнал 1-6 боть 1000 ш	30,490.8
4	Төгсөгч, ахмадууд, захиргааны ажилтнуудын зориулсан үйл ажиллагаа зохион байгуулах	30,000.0	Сэргэлэн мичнүүд ТББ ШУТИС 8-р байрны видео	3,500.0
			Чингис хаан цогцолбор ХХК ШУТИС Төгсөгч, ахмад ажилтнуудын үйл ажиллагаа /160 хүний /	10,200.0
			Глобал партс монголиа ХХК 60 жилийн ойн лого хэвлэлт	105.0
			Есөн мөчир ХХК Төгсөгчдийн уулзалт зохион байгуулах Акрилан Лого 80*15 үнэд	1,800.0
			Супер жобс Төгсөгчдийн уулзалт зохион байгуулах зардалд - хулдаасан хэвлэлийн үнэнд	399.3
			ШУТИС ҮТС Ахмадын хоол	3,200.0
			Монгол Кувейтын байгаль хамгаалах төв ТӨААТҮГ 120 хүн	7,436.8
5	ШУТИС -60 түүхэн гэрэл зургийн цуврал үзэсгэлэн зохион байгуулах	20,000.0	Б.Дарханзул Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах замтай гэрэл, цагаан хоолой	870.8
			Сне графикс ХХК Гэрэл зургийн үзэсгэлэн зохион	14,470.0

			байгуулах гэрэл зураг хэвлэх бэлтгэх	
			ШУТИС ҮТС Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах цай, кофены зардалд 5,17-нд /	350.0
			Нармандах Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах нээлтэд цэцгийн үнэд 5,17-нд /	12.0
			Алтан алим Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах энгэрийн тэмдгийн наалтын үнэд 5,17-нд /	55.6
			Тэнгэр алтай трейд Гэрэл зургийн үзэсгэлэн зохион байгуулах нээлтэд тууз, бээлийний үнэд 5,17нд	16.6
6	Багш ажилчдыг шагналд тодорхойлох, шагналын зардал	1,500.0		-
7	ШУТИС-ийн багш ажилтан, ажилчдад зориулсан бэлэг дурсгалын загвар гарган бэлтгэх	100,000.0	Ньк синдкат ХХК Бэлэг, дурсгал Цүнх 1100 ширхэг, Бал хайрцагтай 1700 ширхэг, Цайны аяга 300 ширхэг, 60 жилийн ойн тэмдэг 2000 ширхэг	48,952.3
			Глобал партс монголиа ХХК ШУТИС 60-н жил бэлэг Лого	75.6
			ШУТИС ҮТС Бэлэг боох тууз үнэд 2 боодол	225.0
			С.Зэвсэг ШУТИС 60 жилийн ойн календарь 250 ширхэг	6,800.0
			Мөнх-Эрдэнэ Повер банк 1700 ширхэг	38,846.2
8	Багш ажилтан, оюутны шилдэг үзүүлбэрээс бүрдсэн ШУТИС-	55,000.0	СУИС -ийн 7 багшийн цалин	25,406.9

	ийн 60 жилийн ойд зориулсан концерт бэлтгэх тоглолт зохион байгуулах		Хан мюзик ХХК морин хуур 5 ш, Басс гитар 2ш, Соло гитар 2ш, Бөмбөр 1ш	7,594.0
			Скай хайпермаркет ХХК Подволк 31ш	244.9
			Сутайн бумбаг ХХК найрал дуу 50 плате,	2,311.4
			Тотал Мюзик ХХК Кабелийн үнэд / Урлаг зааланд /	1,951.9
			Моннидер ХХК Ойн баярын концертод оролцох оюутнуудын бэлтгэлд / 200 оюутан /	1,200.0
			ШУТИС 60 жил тоглолт өдөр хоол 22 хүн	363.0
			ШУТИС 60 жил тоглолт ус 42 ш	302.4
			14 Хувь хүнээс хувцас түрээс	7,648.5
			Тотал Мюзик ХХК Ойн баярын концертод цаасан салют	199.5
			Саруул Ойн арга хэмжээний зочдын цэцэг/ 8 ш /	280.0
			ШУТИС 60 жил тоглолт Д.Цоодол ажлын хөлс	3,094.6
			ШУТИС 60 жил Толкин дуучны хөлс	555.0
			М.Булганаа Консерваторын 25 ш хөгжим түрээс үнэд	742.5
			Д.Оюунхишиг Найрал дуу 4 хоолойд 16 оюутны хөлс	475.2
			9	Тэргүүний сургууль, салбар тэнхим багш, ажилтны үр дүнгийн болон эрдэм шинжилгээний бүтээл, сурах бичиг, гарын авлагын үзэсгэлэн зохион байгуулах, шагнаж урамшуулах
ҮЭ-тэй хамтарсан болзолт уралдааны 1-р байрын шагналд, / МХТС /	5,000.0			

			ҮЭ-тэй хамтарсан болзолт уралдааны 2-р байрын шагналд./ МехТС/	250.0
10	ШУТИС-60 ойн ёслолын хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулах	20,000.0	Нийслэлийн соёлын төв өргөө ШУТИС 60 жилийн ойн тоглолт 4 цагийн хөлс,	12,000.0
			Урантогос Лед дэлгэц түрээс	5,000.0
			Нийслэлийн соёлын төв өргөө ШУТИС 60 жилийн ойн тоглолт 4 цагийн хөлс, Урантогос Лед дэлгэц түрээс, VIP зочдын ус, кофе хоол	810.0
11	ШУТИС-ийн Багш нарын баярын ёслолын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах	50,000.0	Улаанбаатар зочид буудал ХХК 60 жилийн хүлээн авалт Лед дэлгэц	650.0
			Улаанбаатар зочид буудал ХХК 60 жилийн хүлээн авалт хивс / 600 хүн /	30,975.0
			ШУТИС ҮТС ШУТИС 60 жилийн ойн хүлээн авалтын зардалд / 600 хүн /	19,017.8
			ШУТИС 60 жил тоглолт Энхтайван дуучин ажлын хөлс	555.0
			Л.Намжилдорж Айраг, Бензин үнэд	119.9
			Дүн	444,500.0

8.5 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ҮР ДҮН

Үндэсний аудитын газраас тус сургуулийн 2019 оны нэгдсэн санхүүгийн тайланд аудит хийж Япон улсын Шема Секи компанитай байгуулсан гэрээний дагуу 72.0 мянган ам долларын хөрөнгийг бүртгэлд аваагүй, хэвлэх үйлдвэр, номын санг хариуцсан ахлах нягтлан бодогчийн эзэмшсэн мэргэжил нь эдийн засагч, 5 тендерийн гэрээг дүгнэн акт үйлдсэн баримтыг тендерийн хавтаст хэрэгт хавсаргаагүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт сүүлийн онуудын хууль, тогтоомж, дүрэм журам, холбогдох өөрчлөлтүүдийг тусгаагүй зэрэг 161.8 сая төгрөгийн зөрчлүүдэд 2 албан шаардлага хүргүүлж “ЗӨРЧИЛГҮЙ” санал дүгнэлт өгсөн байна.

8.6. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХАНГАМЖИЙН ТАЛААР

Хөрөнгө оруулалт, хангамжийн газар нь холбогдох хууль, журам, дүрмийн хүрээнд дараах чиг үүргийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

I. ШУТИС-ийн төсөв, хөрөнгө оруулалтыг оновчтой төлөвлөн батлуулах, батлагдсан төсвийг хуваарилах, төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулах, хэрэгжилтэд хяналт тавих

Бүрэлдэхүүн сургуулиудаас ирүүлсэн төсвийн төслийг 2 үе шаттай хэлэлцэн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Удирдах зөвлөлд батлуулахаар бэлтгэл ажлыг хангасан.

2020 оны төсвийн төсөөлөл, 2021-2022 оны төсвийн хүрээний мэдэгдэлд тусгах төсөл арга хэмжээний санал болон урсгал зардлыг нэмэгдүүлэх арга хэмжээнд холбогдох маягтын дагуу санал боловсруулан илгээсэн.

2020 онд ШУТИС-ийн хэмжээнд нийт 3,3 тэрбум төгрөгийн 153 нэрийн худалдан авалтын төлөвлөгөөг удирдах зөвлөлөөр батлуулан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвлөлөөр оруулан хянуулж, хөрөнгө олж авах, худалдан авалт хийх зөвшөөрөл бүхий тогтоолыг батлуулсан.

II. ШУТИС-ийн хэмжээнд худалдан авах үйл ажиллагааг хууль тогтоомжийн хүрээнд ил тод, нээлттэй зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийн явцыг хянан шалгаж, баталгаажуулах, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангах

Худалдан авах үйл ажиллагааг ил тод үнэн зөв явуулах үүднээс Худалдан авах ажиллагааны удирдах академи Төрийн бус байгууллагатай 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хамтран ажиллах гэрээг дүгнэн сунгаж үнэлгээний хорооны үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө үйлчилгээ авч, хараат бус 2-оос доошгүй гишүүдийг тогтмол авч ажиллаж байна.

Худалдан авах ажиллагааны цахим системд батлагдсан төлөвлөгөөг оруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Сангийн ямаар батлуулан худалдан авах ажиллагааг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах” хуулийн хүрээнд зохион байгуулан ажиллаж байна. 1,1 тэрбум төгрөгийн 75 нэрийн худалдан авалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд зарим худалдан авалтыг цар тахлын нөхцөл байдлаас хамааран хойшлуулж, санхүүгийн жилийн сүүлийн хагаст худалдан авахаар төлөвлөсөн.

III. Барилга, байгууламж барих зөвшөөрөл, техникийн нөхцөлийг бүрдүүлэх, төслийн өмнөх шатны судалгаа, тооцооны ажлыг гүйцэтгэх, барилга байгууламжийн хүчин чадал, техник, технологийн сонголт хийх арга хэмжээг зохион байгуулах

1.Оюутны II байрны газар дээрх барилгын дахин төлөвлөлтийн ажил

2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ГБМЗХ2018/11-011 тоот дугаартай архитектур төлөвлөлтийн даалгаврыг батлуулсан бөгөөд техникийн тодорхойлолтыг дурдвал:

Шинээр барих барилга нь оюутны байр, олон улсын стандартад нийцсэн спорт заалны хэсгээс бүрдэнэ. Оюутны байрны барилгын хэсэг нь 43,14x20,2м хэмжээтэй, 25,8м өндөртэй 9 давхар /-1 зoorьтой/, 7744.3 м2 талбайтай. Спорт заалны барилгын хэсэг нь 31,7*25,36м хэмжээтэй, 804 м2 талбайтай сандвичэн байна.

1. Зоорийн давхарт автомашины граж /9 машин/ , фитнесийн хэсэг/ хувцас солих өрөө, эр эм шүршүүр, 00-ын өрөө/, нийтийн хувцас угаалгын өрөө
2. 1-р давхарт угтах хэсэг, харуулын хэсэг, эргэлтийн уулзалтын өрөө, лекц, уулзалтын танхим, хүнсний дэлгүүр, агуулах, кофе шоп, эмчийн өрөө, оффисын хэсгээс бүрдэнэ.
3. 2-р давхарт ном уншлагын өрөө, хичээл давтлагын өрөө, чөлөөт хөгжүүлэлтийн өрөө, лекцийн танхим, оффис өрөө байрлана.
4. 3-7 давхарт 170 оюутны өрөө /1 өрөөнд 2 оюутан, 4 оюутны дунд 00-ын өрөө, шүршүүрийн өрөө, гал тогооны хэсэгтэй/
5. 8-9 давхарт 12 өрөө гэр бүлтэй оюутанд зориулсан / өрөө тус бүрдээ 00-ын өрөө, шүршүүрийн өрөө, зочны өрөө, гал тогоо, унтлагын өрөөтэй /
6. 8-9 давхарт 12 өрөө ахисан түвшний оюутанд зориулсан /2 өрөө дунд 00-ын өрөө, шүршүүрийн өрөө, хичээл давтах, гал тогооны хэсэг, тус тусын унтлагын өрөө/
7. Давхар бүрт уулзалтын өрөө

Мөн дараах холбогдох зөвшөөрөл, судалгааны ажлыг хийгээд байна.

Архитектур төлөвлөлтийн даалгавар батлагдсаны дараагийн үе шатны ажил болох инженер геологийн дүгнэлтийг “Сойл трейд” ХХК-тай гэрээ байгуулан ажлыг Ус сувгийн удирдах газар, Улаанбаатар дулаан сүлжээ ТӨХК, Мэдээлэл холбооны ТӨХК мөн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК зэрэг газруудаас техникийн нөхцөлүүдийг авах хүсэлтийг хүргүүлж авсан.



Хуучин барилга



Шинээр төлөвлөж буй оюутны байр

Зураг 8.3. Оюутны 2 дугаар байр

2. Хичээлийн IV байрны дахин төлөвлөсөн барилгын ажлын зураг, төсвийг бэлэн болголоо.

Хичээлийн IV байрны дахин төлөвлөсөн барилгын ажлын зураг, төсвийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2 үетэй шаттайг явууллаа. Уг шалгаруулалтад “Ди Ди Эй Жи” ХХК шалгарч зураг төсөв зохиох гэрээ байгуулан ажиллаж байна. Гүйцэтгэгч компанитай ажлын хэсгийн уулзалтыг 3 удаа мөн сургуулийн багш ажилтнуудтай уулзалт хийж шаардлагатай талбайг судлан үзэж зохион байгуулалтын оновчтой шийдлүүдийг гаргаж баталгаажуулсан. Хичээлийн IV байр нь архитектур төлөвлөлтийн даалгаварт тусгагдсаны дагуу ажлын зургийг доорх үзүүлэлтээр гарлаа. Үүнд:

Барилгын суурийн тэнхлэгийн хэмжээ 74,4 x 39,6м

Барилгын өндөр 38,02м


Барилгын нийт талбай 29462,4м²

Зоорийн давхар

Лабораториуд, авто зогсоол, техникийн өрөөнүүд

- 1-р давхар. Үүдний танхим, сургалтын алба, өлгүүр, ШИМА лаборатори, усан бассейн
- 2-р давхар. Сургуулийн захиргаа, номын сан, кофе мухлаг, Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын лабораториуд
- 3-р давхар. Хөнгөн үйлдвэрлэлийн технологи инженерчлэлийн салбарын лабораториуд, лекц семинарын танхимууд, багш нарын өрөө, оюутны клуб
- 4-р давхар. Хүнсний инженерчлэлийн салбарын лабораториуд, лекц семинарын танхимууд, багш нарын өрөө, оюутны клуб
- 5-р давхар. Дизайны салбарын лабораториуд, лекц семинарын танхимууд, багш нарын өрөө, оюутны клуб
- 6-р давхар. Хоолны газар, Хүнсний инженерчлэлийн салбарын лабораториуд, Дизайны салбарын лабораториуд, лекц семинарын танхимууд
- 7-р давхар. Спорт танхим, бялдаржуулах танхим, багш нарын амралтын өрөө, лекц семинарын танхимууд, лабораториуд
- 8-р давхар. Биотехнологи, шим гэжээлийн салбарын лабораториуд, лекц семинарын танхимууд, 216 хүний суудалтай хурлын танхим, оюутны клуб
- 9-р давхар. Биотехнологи, шим гэжээлийн салбарын лабораториуд, лекц семинарын танхимууд, багш нарын өрөө, оюутны клуб

Лаборатори – 85 өрөө, Лекцийн танхим – 8 танхим, Семинарын танхим – 11 өрөө, хурлын танхим - 216 хүний суудалтай, Оюутны клуб – 8 клуб ажиллах боломжтой. Давхар бүрд багш нарын ариун цэврийн өрөө, оюутны ариун цэврийн өрөөнүүд төлөвлөсөн.



Зураг 8.4. Шинээр барих ШУТИС-ийн үйлдвэрлэлийн технологи инновацын барилга

3. Хичээлийн VIII байрны барилгыг ашиглалтад орууллаа.

Хичээлийн VIII байрны барилгын ажлыг 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс ерөнхий гүйцэтгэгчээр Монкон консртакшн ХХК, Зураг төсвийн ажлыг ШУТИС-ийн БАС-ийн Зураг төсөл судалгааны төв, Техник хяналтыг ШУТИС-ийн БАС-ийн Реконстракшн төв, захиалагчаар ШУТИС-ийн Хөрөнгө оруулалт, хангамжийн газар тус тус ажиллаж Барилга байгууламж ашиглалтад оруулах улсын комиссын 2019 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 2019/677 дугаартай дүгнэлтээр ашиглалтад орууллаа.



Хичээлийн 8-р байрны гадна байдал



ШУТИС-ийн музей, хурлын заал

Зураг 8.5. Хичээлийн 8-р байр



Зураг 8.6. Барилга байгууламжийн ашиглалтын гэрчилгээ

Хичээлийн VIII байр нь 33.0м*25.0м хэмжээтэй, 48.05 м² өндөртэй, 9799.66 м² талбайтай 12 давхар /-1 зорьтой/ төмөр бетон араг бүтээц хийцлэлтэй, лабораторийн 53 танхим /суудлын тоо 1620/ танхим, багш нарын 18 /суудлын тоо 181 /өрөө, хурлын 1 /суудлын тоо 170/ танхим, уулзалтын 1 /суудлын тоо 20/ өрөө, 190.5 м² үзэсгэлэнгийн талбай, 735 м² музей үзвэрийн талбай бүхий хүчин чадалтай.

4. Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн хичээлийн байрны өргөтгөл ашиглалтад оруулсан.

Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн хичээлийн байрны өргөтгөлийн зураг төсвийг ШУТИС-ийн Төсөл судалгааны төвөөр гүйцэтгүүлэн, Барилгын хөгжлийн төв болон Нийслэлийн мэргэжлийн хяналтын газраар хянан баталгаажуулалт хийлгэсэн.





Зураг 8.7. Мэдээлэл, холбооны технологийн сургуулийн хичээлийн байрны өргөтгөл


Уг ажилд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу үнэлгээний хороог байгуулан ажиллуулж тендерийг зарлан “Тэгш өргөө” ХХК шалгарч барилга угсралтын ажлыг 2019 оны 8 дугаар сарын 14-ний өдрөөс эхлүүлэн /гэрээний дугаар ШУТИС/201901060/ хийж гүйцэтгэн улсын комисст хүлээлгэж өгсөн. Тус өргөтгөлийн барилга нь хичээлийн байртайгаа давхар бүрээрээ холбогдсон, тэнхлэгээрээ 15,2 х 5,35 м хэмжээтэй төмөр бетон араг бүтээцэт хийцтэй, 243,9 м² талбайтай 3-н давхар барилгын ажлыг дуусгасан.

5. ШУТИС-д засвар тохижилтын ажлын зураг төсөв, ажлын тендерийн баримт бичиг бэлтгэх, зарлах, сонгон шалгаруулалт явуулах, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, түүний биелэлтийг хангуулах, гүйцэтгэлийн явцад хяналт тавих арга хэмжээг зохион байгуулах

Засварлах объектуудын бүрэлдэхүүн нэгжүүдийн албан хүсэлтийг үндэслэн шаардлага болон ач холбогдлыг нь нягтлан шалгаж, инженер, аж ахуйн ажилтнуудтай хамтран газар дээр нь үзэж хэмжилт хийж ажлын даалгаврыг боловсруулан засвар тохижилтын ажлын 815,0 сая төгрөгийн 27 хяналтын төсөв боловсруулан тендерт бэлтгэн худалдан авалтыг зохион байгуулж гүйцэтгэлийг хянан, ашиглагчдад хүлээлгэн өгсөн.

Байр ашиглалтын болон эдийн засгийн хувьд хэмнэлттэй гэсэн үндэслэлээр ажилчдынхаа дотоод нөөц бололцоог ашиглан, засвар тохижилтын 4 ажлыг аж ахуйн аргаар гүйцэтгэхээр инженерүүд ажлын даалгаврыг хянан, 68, 9 сая төгрөгийн ажлыг гүйцэтгүүлсэн.

► Засварын дараа



Зураг 8.8. Урлаг заалны засвар



Зураг 8.8. Мэргэжилтний байрны засвар



Зураг 8.9. Оюутны байрны дээврийн засвар

6. Өмч хөрөнгийн тайлан, мэдээ гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх, удирдлагыг мэдээллээр хангах

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай өмчийг эзэмшүүлэх гэрээ-2018 байгуулж, өмнөх Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний хавсралт мэдээлэл, тайланг хянаж, нэгтгэн 86 онооны үнэлгээтэйг дүгнүүлээ.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын төрийн өмчийн программын ашиглалт, цахимд оруулсан мэдээллийн иж бүрдлийг хянаж шалган, уг мэдээллийг үндэслэн бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн өмч эзэмшүүлэх гэрээг дүгнэж баталгаажууллаа. 2019 оны жилийн эцсийн тооллогын дүнгээр актлагдах хөрөнгийн жагсаалтыг нэгтгэж хянан, ШУТИС-ийн өмч хамгаалах байнгын зөвлөлөөр хэлэлцүүлэн зохих газарт хандаж, нийт 1,9 тэрбум төгрөгийн үндсэн хөрөнгийг актлаж, данснаас хасах зөвшөөрлийг авч тогтоолын биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг холбогдох төрийн захиргааны байгууллагад хүргүүлсэн.

2018, 2019 оны ТӨБЗГ-тай хийсэн түрээсийн гэрээний дагуу бүрэлдэхүүн сургууль нэгжүүдийн 23 хувь хүн, албан байгууллагын түрээсэлсэн нийт 1198 м2 талбайн сонгон шалгаруулалт, гэрээний биелэлтийг хянаж түрээсийн төлбөрийн тооцоог хянан баталгаажуулж ажилласан. 2019 оны сүүлийн хагас жилд 12.2 тэрбум төгрөгийн, 2020 оны эхний хагас жилд 294,1 сая төгрөгийн сургууль хооронд шилжиж хөрөнгийн хөдөлгөөнийг шийдвэрлэв.

7. Сургалтын төлбөрийн болон бусад авлагыг багасгах тал дээрх ажлыг эрчимжүүлж бүрдэлдэхүүн нэгжүүдтэй хамтран ажиллаж байна.

Шүүх дэх эвлэрүүлэн зуучлах ажиллагааны хүрээнд

Үлдэгдэлтэй болон маргаантай сургалтын төлбөрийн асуудлыг эвлэрүүлэн зуучлах ажиллагааг зохих байгууллагуудтай хамтран гүйцэтгэж төлүүлэх гэрээ байгуулж шүүхийн захирамжаар баталгаажуулалт хийлгэж байна.

Нийт- 482 өргөдөлд Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдсэн байна. Одоо ажиллагаанд байгаа 15 өргөдөл шүүхийн эвлэрүүлэн зуучлах ажиллагаа хийгдэж байна. БАС- 3 оюутны 1,032.8 мян төг, БАТС-13 оюутны 16,142.3 мян төг, ГУУС-37 оюутны 27,887.7 мян төг, ДАТС-15 оюутны 13,057.2 мян төг, МехТС- 14 оюутны 10,474.1 мян төг, ҮТС-9 оюутны 4,397.1 мян төг нийт 72,991.4 мян төг бүхий маргааныг шүүхийн эвлэрүүлэн зуучлалаар гэрээ байгуулсан бөгөөд 48,450.0 мян төг эргэн төлөгдөөд байна.

Шүүхэд нэхэмжлэл, хүсэлт гаргасан байдал.

Шүүхэд ХШУС-ийн 16 хариуцагчийн материалыг бэлдэж, нэхэмжлэл гаргасан байна. 12,530.9 мян төгрөгийн нэхэмжлэл гаргасан. 9 хариуцагч шүүхэд нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрөн захирамж гарч 4,752.5 мян төгрөг төлөгдсөн. Шүүх 7 хариуцагчийг хаяг дээрээ байхгүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт нийт 11 төлбөр төлөгчийн 135,5 сая төгрөгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа хийгдэж байна.

8.7. БАЙР АШИГЛАЛТЫН НЭГДСЭН АЛБА

Байр ашиглалтын нэгдсэн алба оюутны байрны үйл ажиллагааг Их сургуулийн захирлын 2019 оны 8 дугаар сарын 20- ны өдрийн Б/246 тоот тушаалаар тус албанд шилжүүлсэн, зорь бүхий 12 давхар, 9799.6 м2 талбайтай шинэ барилга ашиглалтад



орсноос шалтгаалж 46 хүнээр орон тоо нэмэгдэж нийт 70 хүний орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирлээ.

2019-2020 оны хичээлийн жилд байр ашиглалтын нэгдсэн алба нь Дээд боловсролын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Эрчим хүчний хэмнэлтийн тухай хуулиуд, Улсын их хурал, Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагын тогтоол, тушаал, стандарт, ШУТИС-ийн дүрэм, журмуудыг мөрдөн ажиллалаа.

Тус алба нь барилга байгууламжийн их болон урсгал засварын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу хийлгэх, хяналт тавих, орчны /гадаад, дотоод/ тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах, хичээлийн болон оюутны байруудын дэд бүтцийн хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих, өмч хөрөнгийг үр ашигтай зарцуулах, түрээслэгчдийн түрээсийн гэрээний биелэлтэд хяналт тавих зэрэг ажлуудыг гүйцэтгэлээ.

Тайлангийн хугацаанд сургалтын үйл ажиллагааг тасралтгүй хэвийн явуулах орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр шинэ хичээлийн жил, өвөлжилтийн бэлтгэлийг хангах засвар тохижилтын ажлын календарчилсан төлөвлөгөө гарган мөрдөж, дараах ажил үйлчилгээг үзүүлэв.

➤ **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйлчилгээний чиглэлээр**

“ШУТИС-ийн хамтын гэрээ”-ний өөрийн үйл ажиллагааны холбогдох бүлэгт тусгагдсан зүйл заалтын хэрэгжилтийг зохих түвшинд хангуулахад анхаарч ажиллалаа. Эрүүл мэндийн төвтэй хамтран үйлчлэгч нарт цэвэрлэгээний бодис материалыг зөв хэрэглэх дадал олгох сургалтыг явуулав. Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилладаг үйлчилгээний ажилчдад олгох хор саармагжуулах бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээнүүдийн биелэлтийг хангуулж ажиллалаа. Ариутгал, халдваргүйжүүлэлт, шавж, мэрэгч устгалын ажлыг гэрээний дагуу зохион байгуулав. Оюутны соёл үйлчилгээний алба, эрүүл мэндийн төвтэй хамтран оюутны байрны орчинд нэгдсэн шалгалтыг хийж, авч хэрэгжүүлэх ажил үүргийг байр тус бүрээр гарган холбогдох арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Цайны газрын ерөнхий үйл ажиллагаа, хоолны чанар, цэвэрлэгээ үйлчилгээнд Эрүүл мэнд төв, Оюутны холбоотой хамтран үзлэг, шалгалтыг хийж хяналт тавин ажиллав. Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж “Өндөржүүлсэн бэлэн байдал”-ын үед ажиллах төлөвлөгөөг боловсруулав. Устгалд оруулах шаардлагатай химийн бодис урвалжийн нэгдсэн судалгааг гаргаж ШУА-ийн химийн хүрээлэнгийн холбогдох ажилтанд цахимаар хүргүүлээ. Мөн химийн хорт болон аюултай бодис ашиглах тусгай зөвшөөрлийг сунгуулж шинээр авах материалыг бүрдүүлж БОАЖЯ-д хүргүүлж ажиллалаа.

➤ **Барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээний ашиглалтын талаар**

Хичээлийн болон оюутны байрнуудын сантехникийн найдвартай ажиллагааг хангах үүднээс халаалтын улирал дуусмагц инженерийн шугам сүлжээнд үзлэг шалгалт хийж, дүнг нэгтгэн илэрсэн доголдлыг засварлах ажлыг зохион байгууллаа. Тайлант онд хичээлийн байрнуудын ашиглалтын шаардлага хангахгүй болсон халаах хэрэгслийн хаалт винтель, сгон контур, муфтыг шинэчлэн солилоо. Хичээлийн I байрны ажлын даралт даахгүй болсон хүйтэн усны 184м шугамыг хаалтуудын хамт шинээр сольж бүрэн дулаалав. Хичээлийн II байрны халаалтын I дүгээр хэлхээний 24м урт гадна шугам, А блокийн халаалтын магистраль 180м урт шугамыг солилоо. Оюутны III байрны халаалтын системийн автомат хаалтын удирдлагыг шинэчилж зардлыг тогтворжуулав.

Мөн 322, 422 тоотын бохир зайлуулах босоо шугамыг шинээр сольж, 207, 307, 305 тоотуудын давхар хоорондын ус алдалтыг засварлав. Оюутны I байрны халаалтын болон хэрэглээний халуун усны шугамыг хэсэгчлэн шинээр солив. Хичээлийн байрнуудын халаалтын насосонд тосолгоо үйлчилгээ хийж, зарим дулааны узелийн манометр, термометрийг шинэчиллээ. Эдгээр засвар үйлчилгээний ажилд халаах хэрэгслийн хаалт, винтель, сгон, контур, муфьт, холигч, уян хоолой давхардсан тоогоор нийтдээ 150 ширхэг, төрөл бүрийн хөндлөн огтлол бүхий 500 гаруй метр урт ган хоолой оржээ.

Хичээлийн I,II,III,VIII байр орчмын гадна ариутгах татуургын 250 гаруй у/м шугамыг улирал тутам угаах, 16ш худгийг лайдах ажил хэвшил болсон байна. Хичээлийн жилийн хугацаанд угаалтуур, суултуур, босоо шугам, гадна худаг бөглөрсөн нийт ариутгах татуургын давхардсан тоогоор 198 дуудлага хүлээн авч цаг алдалгүй шуурхай шийдвэрлэж ажиллаа. Үүнд: Ус хангамжийн шугам тоноглолоос ус алдсан 76, ариутгах татуургын шугам хоолой бөглөрсөн 51, халаалтын 71 дуудлага хүлээн авсан байна.

Мэргэжилтний байрны найман өрөөний халуун, хүйтэн усны шугам тус бүр дээр тоолуур тавьж үргүй зардлыг бууруулав.

Хичээлийн I байрны эрчим хүчний хэрэглээнд судалгаа, тооцоо хийж эрчим хүч хэмнэх боломжийг тодорхойлох ажлыг эхлүүлж, инженер техникийн ажилчид, оюутны байрны эрхлэгчид, байр ашиглалт хариуцсан менежерүүд, нярвуудад эрчим хүчний хэмнэлтийн бодлого түүний ач холбогдол, эрчим хүчийг хэмнэх энгийн аргуудын талаар сургалт зохиолоо.

ШУТГНС, хичээлийн II,VIII байрны нийт 9ш цахилгаан шатны аюулгүй ажиллагаа, техникийн бүрэн бүтэн байдал, өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хариуцан техникийн үзлэг, үйлчилгээг гэрээт байгууллагаар хийлгэж гэрээний биелэлтэд хяналт тавин ажиллав. Лифтний ээлжит магадлалыг Улаанбаатар НӨҮГ-аар хийлгэж, илэрсэн зөрчлийг арилгах талаар гэрээт байгууллагатай төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Хичээлийн I,II,III,IV,V,VIII байр, ШУТГНС-ийн хотын болон дотуур утас, станц, шугам аппаратын найдвартай ажиллагааг ханган, лавлагаа мэдээлэл, засвар үйлчилгээг хариуцан ажиллаа. Энэ хичээлийн жилд телефон аппаратын, холбооны кабелийн нийт 164 дуудлага ирж 4 аппарат ашиглалтаас гарч 163 дуудлагын гэмтлийг тодорхойлж засвар, үйлчилгээ хийв. Оюутны байруудын хяналтын камеруудыг шинэчлэх, засварлах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Хичээлийн болон оюутны байрнуудын цахилгаан тоног төхөөрөмж, цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг хариуцан, цахилгаан системийн аюулгүй байдлыг ханган ажиллаж байна. Цахилгааны 28ш ерөнхий, 74ш групп шитэнд техникийн үзлэгийг сар бүр тогтмол хийж осол, аваараас урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгууллаа. Хичээлийн VIII байрны 6, 10 дугаар давхруудад гурван гаргалгаатай ерөнхий шит угсарч лаборатори байгуулах нөхцөлийг бүрдүүлж ажиллав. Тайлант онд разетка, унтраалга, гэрэл солих, цахилгаан хэрэгсэл суурилуулах, тэжээл татах, сургуулийн гадна орчинд зохиогддог арга хэмжээний үеэр цахилгаан тэжээл татах зэрэг ажлуудыг ямар нэг гомдол чирэгдэлгүй гүйцэтгэж ажилласан байна.

“Соргог” ХХК, “Дорнод монгол эрдэс” ХХК-ийн Дорнод монгол секьюрити байгууллагуудтай харуул хамгаалалтын чиглэлээр гэрээтэй ажиллаж байна. Харуулын



албаны ахлагч нартай байнгын холбоотой ажиллаж, гэрээний үүргээ биелүүлж ажиллахыг анхааруулан холбогдох үүрэг чиглэлийг өгч, өдөр тутмын үйл ажиллагаанд нь хяналт тавин ажиллаж байна.

Хичээлийн I, II, III байр орчмын авто зогсоолд байрлах автомашины бүртгэл, судалгааг гаргаж, автомашин нэвтрүүлэх зөвшөөрлийг шинэчлэн автомашин эзэмшигчдэд олгож зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллав.

Нийтийн эзэмшлийн зам талбай, орчны их цэвэрлэгээг улирал тутам зохион байгууллаа.

Тайлант онд Удирдах зөвлөлийн 2019 оны 13 тоот тогтоол, 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн “2020 оны төсвийн тодотгол батлах тухай” 10 тоот тогтоолоор батлагдсан 2020 оны хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан урсгал засварын ажлын даалгаврыг боловсруулж, гүйцэтгэлийг зохион байгуулсан.



